



**ХАМТДАА
БҮТЭЭСЭН
ХАМГААЛЛЫН ТҮҮХ**
**PATHWAYS TO CHILD
PROTECTION**



Save the Children

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл
(2023-2025)

“Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia”
project(2023-2025)

ХАМТДАА БҮТЭЭСЭН ХАМГААЛЛЫН ТҮҮХ

PATHWAYS TO CHILD PROTECTION

Stories of Transformation

Улаанбаатар хот 2025
Ulaanbaatar 2025

ХАМТДАА БҮТЭЭСЭН ХАМГААЛЛЫН ТҮҮХ

PATHWAYS TO CHILD PROTECTION

Зөвлөх: Ж.Батцэцэг, Г.Цолмон, П.Цэдэндэмба
Редактор: Ч.Батпүрэв, Э.Соёл-Эрдэнэ
Орчуулгын редактор: Шарон Гортон
Орчуулагч: Н.Бүрэнжаргал, Ч.Сансар
Дизайнер: Л.Лхагвачимэг

Зохиогчийн эрх © Хүүхдийг Ивээх Сан 2025

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Аризона төвийн 4-р давхар
Утас: 11329365, 11329371

Advisors: J.Battsetseg, G.Tsolmon, P.Tsedendamba
Editors: Ch.Batpurev, E.Soyol-Erdene
Translation editor: Sharon Gorton
Translators: N.Burenjargal, Ch.Sansar
Layout and design: L.Lkhagvachimeg

Copyright © 2025 Save the Children

Address: 4th floor of Arizona Center, 1st khoroo,
Chingeltei district, Ulaanbaatar city
Phone: 11329365, 11329371

ГАРЧИГ/ CONTENTS

Өмнөх үг/Foreword	5
Хүүхдийн итгэлт анд-“Миний дэвтэр”	8
A Child’s Loyal Friend - “My Notebook”	8
Дэлхийтэй хөл нийлсэн жилүүд	12
Keeping Pace with the World	
Мэргэжлийн бүлэг байгуулж мэдлэг, арга зүйг түгээв	16
A Professional Team Formed to Share Knowledge and Methodologies	16
Мөрөөдлийн 130-р сургууль	22
Dream School No. 130	22
Ирээдүйн төлөө өнөөдөр	27
Today for a Better Future	27
Хамтын ажиллагааны загвар нутагшин үлдлээ	32
A Model of Collaboration Takes Root	32
“Нүд нээсэн” төсөл	36
The “Eye-Opening” Project	36
Багийн амжилт, мэдлэг, туршлага	40
Team Achievements, Knowledge, and Experience	40
Залуу багшийн гараа сайн	47
A Young Teacher Off to a Strong Start	47
Оргилын өндөр бэлийн намаас эхэлдэг	51
The Height of the Peak Begins from the Foot of the Hill	51
Үлгэр жишээ Эцэг эхийн зөвлөл	56
Exemplary Parents’ Council	56
Чадварлаг баг-амжилтын үндэс	60
A Competent Team — The Foundation of Success	60
Хүүхдээ хайрлах ухаарал өгсөн “Гэрэлт самбар”	65
The Light Board That Inspired Parents to Love Their Children More	65
Хүүхэд бүрийг хамгаалах сэтгэл	68
A Commitment to Protect Every Child	68

Эерэг хандлага, хүмүүжил бий болжээ	73
Positive attitudes and behaviors	73
Тэгш оролцоо, хамтын амжилтууд	76
Equal Participation, Shared Successes	76
Тууштай байдал, хичээл зүтгэлийн эзэн багш	80
Persistence and Dedication of a Committed Teacher	80
Үл тасалдах амжилтын буухиа	84
The Social Worker Making a Difference: Protecting and Empowering Children	84
Үр дүн, амжилт тодорхойлогч	87
Driving force behind the success	87
Мөрөөдлийг минь хөгжүүлсэнд баярлалаа	91
Thank You for Nurturing My Dream	91
Оролцоонд тулгуурлаж зохиосон, олуулаа мөрдөх “Ангийн дүрэм”	94
Classroom Rules Built on Participation and Shared Responsibility	94
Мэдлэг дагаж хандлага өөрчлөгдөв	98
Empowering a Teacher to Transform a Community	98
Өөрийгөө хөгжүүлж, бусдад түгээсэн замнал	102
A Journey of Self-Development and Sharing Knowledge	102
“Эверестийн оргилд нисэж буй болжморууд”	107
A Smart Board Game Created by Students to Test Their Knowledge	107
Аюулгүй сургуулийн аз жаргалтай сурагчид	111
Safe Schools, Happy Students	111
Ангийн дүрмийг зүйр цэцэн үгэнд “хөрвүүлнэ”	116
Classroom Rules Expressed As Proverbs	116
Баянзүрх дүүрэг төслийн арга зүйг түгээнэ	121
Scaling Success:Bayanzurkh District Expnads Child Protection Model	121
Хүүхдийн төлөөх миний замнал	125
My Journey for Children	125
Талархалууд	128
Acknowledgements	128



Л.Баян-Алтай

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь
Суурин төлөөлөгч

L.Bayan-Altai

Country Manager and Representative of Save
the Children Japan in Mongolia

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сан нь Монгол Улсад Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа олон улсын байгууллагуудын томоохон төлөөллийн нэг юм. Бид 1994 оноос хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр олон төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжүүлж ирлээ. Түүнчлэн нийгмийн ажлын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, хүүхэд хамгааллын мэргэжлийн арга зүйг боловсронгуй болгох, олон улсын шилдэг туршлагаудыг улс орондоо нутагшуулах, хууль, эрх зүйн бичиг баримтад санал, зөвлөж өгөх зэргээр хувь нэмрээ оруулсан байна.

Бид хүүхэд хамгааллын салбарын тэргүүн шугамд ажиллаж буй Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулсан арвин туршлагадаа тулгуурлан, боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын механизмыг бэхжүүлэх чиглэлээр “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг 2023-2025 онуудад амжилттай хэрэгжүүлээ. Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн тус төсөлд Улаанбаатар хотын таван дүүрэг, Говь-Алтай, Ховд аймгийн ерөнхий боловсролын 14 сургууль, 14 хамтарсан баг хамрагдсан юм.

Төсөл нь хүүхдийн өсөж хөгжих, сурч боловсрох үйл явцыг хүчирхийллийн бус аргаар багш, эцэг эх хэрхэн дэмжиж ажиллах,

FOREWORD

Save the Children is one of the leading international organizations making a substantial contribution to strengthening Mongolia's child protection system. Since 1994, we have successfully implemented numerous projects and programs focused on child protection and the promotion of children's rights. In addition, we have contributed to training professional social workers, the improvement of child protection methodologies, the localization of international best practices, and the provision of expert recommendations for relevant laws and policy documents.

Building on our extensive experience in strengthening the capacity of Multi-Disciplinary Teams (MDTs) working on the frontlines of child protection, we successfully implemented the 'Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia' project from 2023 to 2025, aimed at strengthening child protection mechanisms within the school environment. Funded by Save the Children Hong Kong, the project was carried out in 14 general education schools and 14 Multi-Disciplinary Teams across five districts of Ulaanbaatar, as well as in Govi-Altai and Khovd provinces.

The project's goal was to equip teachers and parents with knowledge and skills to support children's growth, learning, and development

сургууль, хамтарсан баг хүүхэд хамгаалалд хэрхэн хамтарч болох, хүүхдүүд өөрсдөө хүүхэд хамгаалалд хэрхэн оролцоотой байх болон үе тэнгийнхэндээ зөвлөн туслах чадвартай болгох зорилготой байлаа. Тус төслөөр багш, сурган хүмүүжүүлэгчдийн чадавхыг бэхжүүлэх, арга зүй өгөх, эцэг эхийг хүмүүжлийн эерэг аргад сургах, хүүхдийн оролцоог дэмжих, хүүхдүүд бэрхшээлийг даван туулах чадвартай болох, хүүхэд, эцэг эхчүүд хүүхэд хамгааллын чиглэлээр төсөл санаачлан хэрэгжүүлэх чадвартай болоход анхааран ажиллалаа.

Төслийн хүрээнд багш, эцэг эх, сурагчдад зориулсан 15 төрлийн гарын авлагыг боловсруулан гаргажээ. Эдгээр гарын авлагуудын агуулга ба сургалтын модулиудыг холбогдох байгууллагуудаас сайшаан, бусад сургуулиудад түгээх, хүргэхэд хамтран ажиллахаа илэрхийлж байна. Түүнчлэн, 800 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчийг хүүхдийн эрх, хамгаалал, хүмүүжлийн эерэг арга, багшийн ёс зүй, сургуулийн сайн сайхан байдал, хүчирхийллээс ангид сургууль, хүүхэд хамгааллын үйлчилгээ хэрхэн үзүүлэх модуль сургалтуудад хамруулан сургагч багшаар бэлтгэлээ. Эдгээр сургагч багш нар нь 2700 багш, ажилтанд сургалтын модулиудыг уламжлан зааж, түгээн дэлгэрүүлсэн байна.

Төслийн зорилтот сургуулиудын Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл 784 хүнийг “Сайн эцэг эх” сургалтын сургагч багшаар бэлтгэж, улмаар 18170 эцэг эхийг сургалтын түгээн дэлгэрүүлэлтэд хамрууллаа.

“Би найзаа дэмжинэ” өсвөр үеийнхэнд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлснээр сурагчид өөрт тулгарсан аливаа бэрхшээлийг даван туулах ба үе тэнгийнхэндээ зөвлөн туслах үр чадварт суралцлаа. Өсвөр үеийнхэн болон сурагчдад чиглэсэн сургалт, үйл ажиллагаанд нийт 14339 орчим хүүхэд хамрагдсан байна.

Төслөөс хэрэгжүүлсэн ололттой зүйл нь тухайн сургуульд буй хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн гишүүд болон хүүхдийн бүлгүүдийн санаачлан хэрэгжүүлсэн төсөл юм. Зорилтот сургуулиудын эцэг эхийн зөвлөлөөс санаачлан хэрэгжүүлсэн төслүүдэд 11000 эцэг эх, 12302 сурагч хамрагдсан байна. Хүүхдийн бүлгүүдээс

through non-violent methods; to strengthen collaboration between schools and Multi-Disciplinary Teams in child protection; and to enable students to participate in child protection and provide support to their peers. Through this project, we focused on strengthening the capacity and methodology of teachers and educators, training parents and caregivers in positive discipline methods, promoting children's participation, helping children build resilience, and empowering children and parents to initiate and implement micro-projects related to child protection.

As part of the project, 15 manuals were developed and published for teachers, parents, and students. The content of these manuals and associated training modules has been endorsed by the relevant authorities, who have also expressed their willingness to collaborate in distributing and sharing them with other schools.

In addition, over 800 teachers and educators were trained as project trainers in modules covering children's rights and protection, positive discipline methods, teacher ethics, enhanced learning environment, students' well-being violence-free school, and the provision of child protection services. These trainers subsequently delivered the modules to 2,700 teachers and staff, ensuring the knowledge and skills reached a wider audience.

Within the project, 784 representatives from the Parents' Councils of the target schools became trainers for the “Safe Families” program and subsequently reached 18,170 parents through the wider dissemination of the training.

Through the implementation of the “I Support My Friends” school-based peer support program, students developed skills to overcome personal challenges and to advise and support their peers. In total, approximately 14,339 children participated in the training and activities targeting adolescents and students.

One of the project's key achievements was the implementation of micro-projects to address child protection issues in the schools. These initiatives were led by Parents' Council members and

санаачилж хэрэгжүүлсэн төслүүдэд 12935 сурагч хамрагджээ.

Бид төсөл эхлэхийн өмнөх нөхцөл байдлыг тодруулахаар гарааны суурь судалгааг, төслийн үр дүнг хэмжих зорилгоор төгсгөлийн судалгааг авч, үр дүнг харьцуулдаг уламжлалтай. Хүүхдүүдээс авсан судалгаануудын харьцуулсан үр дүнгээс дурдвал: “Төсөл хэрэгжсэнээр хүүхдүүдийн 73.9 хувь нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болсон, 66.7 хувь нь хүүхдүүд хоорондоо эергээр харилцаж бие биеэ дэмждэг болсон, 61.7 хувь нь ангиараа баримтлах дүрмээ хүүхдүүд хамтаараа гаргасан, 59.8 хувь нь хүүхдүүд ангид болон сургууль дээрээ өмнөхөөсөө илүү дэг журамтай болсон, 56.4 хувь нь өөрт нь болон хэн нэгэн хүүхдэд хэрэгтэй байгаа дэмжлэгээ хаанаас авахаа, хэнд хандахаа мэддэг болсон” гэж төслийн үр дүнгийн үнэлгээнд хамрагдсан хүүхдүүд дүгнэсэн байна. Түүнчлэн эцэг эх, асран хамгаалагчид, багш нарын зүгээс хүүхдүүдэд бие махбод болон сэтгэл санааны шийтгэл үзүүлэх байдал төслийн гарааны судалгаатай харьцуулахад 2 дахин буурсан нь хүүхдүүдээс авсан судалгааны үр дүнгээр батлагджээ.

Эдгээр бүх үр дүнд хүрэхэд төсөлд оролцогч бүх талын хамтын ажиллагаа, оролцоо, дэмжлэг үнэтэй хувь нэмэр оруулжээ. Бид төслийн хүрээнд хувь хүн, хамт олны гаргасан амжилт, дэвшилтэд тулгуурлан тус номыг монгол, англи хэлээр гаргаж байна.

Цаашид төслийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн бүхий л шатны байгууллагуудтай илүү уялдаатай ажиллаж, төслөөс боловсруулсан сургалтын модуль, гарын авлагыг Монгол Улсын бүх сургуулиудад түгээн дэлгэрүүлэх, хүүхдийн оролцоонд тулгуурласан үйл ажиллагааг нэмэгдүүлэх, хүн амын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дараагийн төслийг хэрэгжүүлэхээр зорьж байна.

Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд хамтран ажилласан, дэмжлэг туслалцаа үзүүлсэн бүхий л талуудад гүн талархал илэрхийлье.

children’s groups. A total of 11,000 parents and 12,302 students participated in micro-projects initiated by the Parents’ Councils, while children’s groups led separate micro-projects which involved 12,935 students.

Following best practice, we conducted a baseline survey to assess the situation before the project and an endline survey to measure the project’s outcomes, allowing us to compare the results. Key findings from the surveys conducted with children are as follows:

- 73.9% of children they are now able to express their opinions freely; 66.7% interact positively with their peers and provide mutual support; 61.7% they collectively established the Classroom Rules; 59.8% behave with greater order and discipline in class and at school than before; and 56.4% know where and to whom to turn for support for themselves or other children in need.
- the endline survey indicate that parents, caregivers, and teachers use half as much physical and emotional punishment compared to the baseline at the start of the project.

All outcomes were made possible thanks to the valuable collaboration, active participation, and support of all parties involved in the project. Building on the individual and collective achievements realized through the project, this publication has been produced in both Mongolian and English.

To ensure the long-term sustainability of the project, we aim to strengthen collaboration with government institutions at all levels; disseminate the training modules and manuals developed by the project to all schools across Mongolia, expand child-centered activities, and design and implement the next project in alignment with the specific characteristics and needs of the communities we served.

We extend our sincere gratitude to everyone who collaborated, supported, and contributed to the successful implementation of the project.



ХҮҮХДИЙН ИТГЭЛТ АНД-‘МИНИЙ ДЭВТЭР’

Үйлдэл үгнээс ч чанга “ярьдаг” учир би чамайг ойлгоно, дэмжинэ...

A CHILD’S LOYAL FRIEND – ‘MY NOTEBOOK’

Actions speak louder than words I understand you and I am here to support you.

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 17 дугаар сургуульд амжилттай хэрэгжиж байна. Тус сургуулийн 12в ангийн сурагч Ч.Анужин, П.Ижилцэцэг, Т.Учрал, Б.Идэрмөнх, Ц.Мөнхтөр нар нь төслийн хүрээнд “Би найзаа дэмжинэ” үе тэнгийнхэнд чиглэсэн хөтөлбөрт хамрагдан, тус хөтөлбөрийн үе тэнгийн сургагчаар бэлтгэгдсэн байна. Тэд сургуулийнхаа бага, дунд ангийн нийт 150 хүүхдэд хөтөлбөрийн хүрээний сургалтаа заажээ. Түүгээр зогсохгүй “Миний дэвтэр” нэртэй төсөл бичсэн нь Хүүхдийг Ивээх Сангийн бичил төслийн уралдаанд шалгарч, санхүүжилт авчээ. Сурагчид “Би найзаа дэмжинэ” хөтөлбөрийн сургалтаар олж авсан мэдлэгээ ашиглан ийм дэвтэр бүтээсэн юм.

The “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project, implemented by Save the Children at School No. 17 in Chingeltei district, has been successful. As part of this project, Grade 12B students Anujin, Ijltssetseg, Uchral, Idermunkh, and Munkhtur participated in the “I Support My Friends” peer support training program and were trained as peer educators. They conducted peer support sessions for 150 younger students in the primary and lower secondary classes at their school. Their efforts didn’t stop there; the students developed a project proposal, ‘My Notebook,’ which was selected for funding through Save the Children’s micro-projects. Drawing on the knowledge and experience gained from the “I Support My Friends” program, they created this special notebook to promote friendship, understanding, and mutual support among children.

“Миний дэвтэр” нь 35 хуудастай, төлөвлөгч дэвтэр юм. Хүүхдүүд уралдаанд шалгарч авсан санхүүжилтээрээ тус дэвтрийг нийт 200 гаруй ширхэг хэвлүүлсэн байна. Тухайн сурагч энэ дэвтэрт долоо хоногийн ажлын төлөвлөгөөгөө бичихээс гадна “Миний сэтгэгдэл, дүгнэлт” хуудаст тухайн өдөр болсон үйл явдалд ямар мэдрэмж, сэтгэгдэл төрснөө тэмдэглэн үлдээх ажээ. Дэвтрийн хойд хэсэгт яаралтай үед тусламж авахаар холбогдох утасны дугаарыг хэвлэсэн нь онцлогтой байлаа. Гэмтлийн эмнэлэг, Цагдаагийн газар, Яаралтай тусламжийн төв, Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг төв, Хүүхдийн түргэн тусламж, Гоц халдвартын төв, Түлэнхийн төв, Хордлогын үндэсний төв гэхчлэн 30 гаруй чухал албан байгууллагын утасны дугаарыг хэвлэсэн нь эрсдэл бүхий нөхцөлд тухайн хүүхэд өөртөө болон найздаа цаг алдалгүй тусламж хүсэх боломж бүрдүүлжээ.

“Миний дэвтэр” мөн мэдлэг, ойлголт түгээнэ. Жишээ нь, “Өөртөө итгэх итгэлийн гурвалжин” гэж юу болох, “Миний удирдаж чадах, чадахгүй зүйл” гэвэл юу байх, “хамгаалагч найз”, “оюун санааг тэлэгч найз”, “холбогч найз”, “хамтран зүтгэгч найз”, “хөтөч найз”, “бүтээгч, босгогч найз”, “идэвхжүүлэгч найз”, “ижил сонирхолтой найз” гэж хэн болох, тэднийг хэрхэн таних тухай тайлбарлан өгүүлжээ. “Миний дэвтэр”-ийн хуудас бүрд хүүхдэд нэн хэрэгтэй мэдээллийг өгч, холбогдолтой зургаар чимэглэн өнгө үзэмжтэй хэвлэсэн ажээ. “Чи хэтрүүлэн бодох үедээ бич. Түгшихдээ бясалга. Ядарвал унт. Гуниглавал дасгал хөдөлгөөн хий. Стрессээд байвал алх, уурлавал хөгжим сонс, уйтгарлавал бусадтай холбогд, халширвал завсарлага ав” гэх мэтээр үе тэнгийнхэндээ зориулсан зөвлөмжийг оруулжээ. “Үйлдэл үгнээс ч чанга “ярьдаг” учир би чамайг ойлгоно, дэмжинэ, чам руу ярина” гэсэн зөвлөмж нь уг дэвтрийг хэрэглэгч хүүхэд бүрд дотно мэдрэмж төрүүлж, итгэл найдвар өгч байгаа мэт санагдана.

‘My Notebook’ is a comprehensive 35-page planner. Each child can use the notebook to write down weekly plans and goals, while the section titled ‘My Thoughts and Reflections’ allows them to record their feelings and impressions about daily events. Using the micro project funding, they printed more than 200 copies. One unique feature of the notebook is a list of emergency contact numbers printed at the back. It includes more than 30 key organizations, such as the National Center for Mental Health, Police Department, Emergency Center, Center Against Domestic Violence, Child Emergency Service, Infectious Disease Center, Burn Center, and National Poison Control Center. This ensures that children can quickly access help for themselves or their friends in case of an emergency or risky situation.

‘My Notebook’ also provides knowledge and guidance. For example, it explains concepts such as the ‘Triangle of Self-Confidence,’ ‘What a child can or cannot control,’ and ‘Who are Supportive friends’ — including a ‘protector friend,’ ‘mind-expanding friend,’ ‘connector friend,’ ‘collaborating friend,’ ‘guiding friend,’ ‘creator and builder friend,’ ‘motivating friend,’ and ‘friend with shared interests’ — along with tips on how to recognize them.

Each page of ‘My Notebook’ is designed to provide children with useful information, enhanced by relevant illustrations and visually appealing layouts. The notebook also includes practical advice for handling daily challenges, such as: Write when you overthink. Meditate when you feel anxious. Sleep when you feel tired. Exercise when you feel sad. Walk when stressed. Listen to music when angry. Connect with others when lonely. Take a break when you feel overwhelmed.

The guidance section also features the phrase: “Actions speak louder than words - I understand you, I support you, and I will reach out to you.” This message creates a warm, reassuring feeling for every child using the notebook, fostering a sense of trust and hope.

“Миний дэвтэр” төслийн багийнхан дэвтрээ танилцуулж, нээлтийн арга хэмжээ зохион байгуулжээ. Нээлтэд хүрэлцэн ирсэн хүүхдүүд өнгө өнгийн цаасан дээр сэтгэгдлээ бичин үлдээсэн нь тус сургуулийн сэтгэл зүйч Д.Ариунбаярын өрөөний нэг ханыг дүүргэсэн байв. “Миний дэвтэр” төслийн чиглүүлэгч багшаар сэтгэл зүйч Д.Ариунбаяр, математикийн багш Б.Гэрэлчимэг нар ажиллажээ. Тэд Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн багийн гишүүн, сургагч багш нар юм.

Чиглүүлэгч багшийн хувьд “Миний дэвтэр” төслийн багийнхандаа сэтгэл хангалуун байна. Сурагчид төгсөх ангийн ах, эгч нарынхаа санаачилсан энэ дэвтрийг талархалтайгаар хүлээж авсан. “Миний дэвтэр” нь хэрэглэгч хүүхдүүдэд ирээдүйдээ итгэх, ажлаа төлөвлөж сурах, зорилготой байхын давуу тал олгох юм. Хүүхдийн дотно найз нь байж, тухайн хүүхэд хэнд ч хэлэхгүй нандин нууцаа энэ дэвтэрт “итгэж” бичдэг байгаасай. “Миний дэвтэр” бол хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг “Би найзаа дэмжинэ” хөтөлбөрийн арга зүйг ашиглан дэмжих төсөл юм. “Хүүхэд хамгааллын шинэ мэдлэг, мэдээллээр хангаж, шинэлэг арга зүйг нутагшуулсанд “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хамт олондоо талархаж байна” сэтгэл зүйч Д.Ариунбаяр ярилаа.

Түүний нэмж хэлснээр, “Миний дэвтэр”-ийг бусад аймаг, орон нутаг болон нийслэлийн зарим сургуулийн багш, нийгмийн ажилтнууд сонирхон, үзэж харж, туршлага судлах хүсэлт тавьжээ.

“Миний дэвтэр” төслийн багийнхан бүгд сургагч хүүхдүүд юм. Тэд “Би найзаа дэмжинэ” хөтөлбөрөөр олж авсан мэдлэгээ үе тэнгийнхэн болон дүү нартаа дамжуулан түгээж байна. Сургалтаа сонирхолтой арга хэлбэр ашиглан явуулсан учир үр дүн сайтай байна. Тухайлбал, сургагч хүүхдүүд маань “Чи найзаа “хар, сонс, холбо” гэсэн гурван зарчмыг

The ‘My Notebook’ project team introduced their notebook at a launch event, children wrote their impressions on colorful pieces of paper, which covered an entire wall. Ariunbayar, the school psychologist, together with mathematics teacher Gerelchimeg, acted as the project trainer. They are members of the project implementation team.

As a project facilitator, Ariunbayar expressed satisfaction with the ‘My Notebook’. *“The students warmly welcomed the notebook, which was initiated by their senior classmates. ‘My Notebook’ helps children build confidence in their future, learn to plan their tasks, and develop a sense of purpose. I hope the notebook will serve as a close friend for each child, a place where they can safely write their personal thoughts and secrets. ‘My Notebook’ is a project designed to support children’s mental well-being, using the methodology from the ‘I Support My Friends’ program.”*

According to Ariunbayar, teachers and social workers from other provinces, regions, and some schools in the capital have shown interest in ‘My Notebook,’ reviewing it and requesting guidance to learn more about the project. He expressed gratitude to the team from the “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project for providing new knowledge and information on child protection and for adapting this innovative approach to local contexts.

All members of the ‘My Notebook’ project team are peer educators. They share the knowledge they gained from the “I Support My Friends” program with their peers and younger students. Their training sessions are highly effective because they used engaging, interactive methods. For example, the peer educators used “Observe, Listen, Link” through a short drama performance, which captured the students’ attention and interest.

The success of this initiative is due to the dedication and diverse talents of the project team members:

жүжигчилсэн тоглолт хэлбэрээр заасан нь хүүхдүүдийн сонирхлыг ихэд татсан байна.

Эцэст нь “Миний дэвтэр” төслийн багийн сурагчдыг товч танилцуулъя.

Ч.Анужин эрх зүйч, хуульч мэргэжил эзэмших хүсэлтэй. Тэрээр, 17 дугаар сургуульд үйл ажиллагаа явуулдаг “Галт шувуу” мэтгэлцээний клубт харьяалагддаг. Мэтгэлцээний сургуулийн аварга юм. Сагс, волейболын спортоор хичээллэдэг, нийгмийн идэвхтэй сурагч билээ.

П.Ижилцэцэг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил эзэмших сонирхолтой. Дуулдаг, сургуулийн урлагийн үзлэгийн алт, мөнгөн медальтай.

Т.Учрал сэтгэл зүйч болох сонирхолтой, мөн мэтгэлцээний урлагаар хичээллэдэг. Ирээдүйд герман хэл сурах, сувилахуйн ухааныг сонирхон судлах хүсэлтэй.

Б.Идэрмөнх эмч болно. Сагс, волейболын спортоор дүүрэг, нийслэл, улсын чанартай тэмцээн уралдаанд амжилттай оролцдог.

Ц.Мөнхтөр хөрөнгийн зах зээлийн шинжээч мэргэжил эзэмшихээр бэлтгэж байна. Математик, физикийн хичээл сонгон судалж, гадаад, дотоодын олимпиадад амжилттай оролцдог сурагч юм.

Let’s introduce the students of the ‘My Notebook’ project team.

Anujin aspires to become a lawyer. She is a member of the “Firebird” debate club at School No. 17 and has won a championship in school debates. She also plays basketball and volleyball and is an active participant in social activities.

Ijiltsetseg is interested in pursuing a career in public health. She enjoys singing and has won gold and silver medals in the school arts competitions.

Uchral hopes to become a psychologist and also participates in debate competitions. In the future, she plans to study German and explore nursing science.

Idermunkh aspires to become a doctor. He competes successfully in basketball and volleyball at district, city, and national levels.

Munkhtur is preparing to become a financial market analyst. He focuses on mathematics and physics and participates successfully in domestic and international Olympiads.

ДЭЛХИЙТЭЙ ХӨЛ НИЙЛСЭН ЖИЛҮҮД

KEEPING PACE WITH THE WORLD

Нийслэлийн ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 87 бүлэгт 3680 суралцагчтай, 170 багш, ажилтантай. Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэнээр хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц ахиц гаргажээ.

Энэхүү төсөл нь Хүүхэд хамгааллын үйлчилгээг сургуулийн орчинд үзүүлэх механизмыг бэхжүүлж, чадавхжуулах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг арга зүйг ашиглах боломж олгосон нь чухал ач холбогдолтой байлаа.

ХИС-гийн Олон улсын эвсэлээс боловсруулан, дэлхийн 120 гаруй оронд туршсан гарын авлага, арга зүйд тулгуурлан, төслийн багаас олон тооны сургалтын гарын авлага, материал боловсруулан гаргасан нь багш, эцэг эх, сурагчдад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай ойлголтыг зохих төвшинд өгч чадсан юм. Түүнээс гадна эдүгээ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Боловсролын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон эдгээр хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан салбарын сайдын дүрэм журмыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд түлхэц болсон.

Сургуулийн орчинд сургуулийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаа бүрэн зохион байгуулалтад орж, хүүхэд хамгаалал, хөгжлийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх загварыг бий болгож чадлаа. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс олон төрлийн сургалт явуулж, сургагч багш, эцэг эхийн зөвлөл, хүүхдүүдийг бэлтгэснээр ийм үр дүнд хүрсэн. Бид сургуулийнхаа орчинд хүүхэд хамгааллын

School No. 2 in Ulaanbaatar currently operates 87 classes, serving 3,680 students with the support of 170 teachers and staff. Since joining the Save the Children's ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project, the school has made remarkable progress in strengthening child protection systems and creating a safer learning environment for all students.

The project has played a crucial role in strengthening the school's child protection system by introducing internationally recognized best practices. Drawing on the handbook and methodology developed by Save the Children International and tested in more than 120 countries, the project team created a wide range of training manuals and materials tailored to the Mongolian context. These resources have greatly enhanced the understanding of child rights and protection among teachers, parents, and students.

In addition, the project has provided strong momentum for the effective implementation of Mongolia's Education Law and Child Protection Law, as well as the related ministerial regulations issued to enforce them. Within the school environment, the Child Protection Team activities were organized, creating a comprehensive model that addresses both child protection and student development.

According to Tsengelmaa, Principal of School No. 2, the project achieved these results by organizing training programs and building the capacity of trainers, parent councils, and students. “Within the school environment, we are successfully assessing, evaluating, improving, and monitoring our child protection activities,” she said.

үйл ажиллагаагаа дүгнэж, үнэлж, засан сайжруулж, хяналт тавин амжилттай ажиллаж байна” гэж 2 дугаар сургуулийн захирал Л.Цэнгэлмаа онцлон тэмдэглэв.

Тус сургууль нь төслийн үр дүнд хүүхэд хамгааллын үйлчилгээг хуулийн дагуу үзүүлэх, эрт илрүүлэх, шуурхай тусламж үзүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор хүүхэд хамгааллын бодлогоо шинэчилжээ. Хүүхэд хамгааллын бодлогыг сургуулийн дүрэм журмын бүтцэд тусгаж, жилдээ 1-2 удаа гадаад, дотоод орчинд эрсдэлийн үнэлгээ хийдэг болов. Суралцагчдын дунд үе тэнгийн дээрэлхэлтгүй байж, хүүхдүүд бие биедээ туслах, хамтдаа суралцаж, хөгжих боломж нээгджээ. Түүнчлэн эцэг эхчүүдийн хандлага эергээр өөрчлөгдөж, оролцоо нь нэмэгдсэн байна. Сургагч багш нарын зохион байгуулсан 4-5 удаагийн шаталсан “Сайн эцэг эх” сургалтад тус сургуулийн нийт 800 орчим эцэг эх хамрагдсан байна. Эцэг эхчүүд хандлагаа өөрчлөөд зогсохгүй хүүхэд хамгаалал, хөгжлийн асуудалд сургуультай хамтарч хэрхэн ажиллах талаар оролцоогоо мэдэж авсан нь ач холбогдолтой байсныг захирал Л.Цэнгэлмаа нэмж дурдав.

“Нийгэмд хүүхэд хамгаалал сул, гэмт хэрэг, хүчирхийлэл гардаг биш, үр хүүхдүүд минь найдвартай хамгаалагдсан, сурч хөгжсөн, цог золбоотой, идэвх санаачилгатай нийгмийг бий болгоход хүүхэд хамгаалалд оролцогч тал нэг бүрийн хүчин зүтгэл хэрэгтэй юм. Дүүргийн төр, захиргааны болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа сайжирч байна. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэнээр хүүхэд хамгааллын цогц

Strengthening Systems and Policies

The school has revised its child protection policy to ensure that services are provided in accordance with the law, with a focus on early detection, timely intervention, protection, and rehabilitation. The policy has been incorporated into the school's official regulations, and the school now conducts risk assessments of both internal and external environments once or twice a year.

Under the principal's leadership, the school established a Child Protection Team and streamlined its operations. Each member of the team, including social workers, psychologists, doctors, and teachers from all grades, was assigned clear responsibilities and worked according to a defined plan.

A critical improvement has been the collaboration between the school's Child Protection Team and the khoroo-level Multi-Disciplinary Team. Previously, this collaboration had been limited. However, as a result of the project, substantial improvements have been made. At the school level, a workflow chart for child protection services was developed, clarifying how to respond promptly and effectively when rights violations occur, as well as how to deliver appropriate support and follow-up.

Creating Safer Spaces for Children

The impact on students has been tangible. Incidents of peer bullying have decreased, and children now have more opportunities to support one another, learn collaboratively, and grow together. Every class at School No. 2 has developed its own set of “Classroom Rules,” which are reviewed and evaluated monthly. With all

үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй талуудын үйл ажиллагаа эрс чанаржиж, ахиц, амжилт гарсан” гэж Л.Цэнгэлмаа захирал дүгнэлээ.

Энэ хамт олон захирлаар удирдуулсан хүүхэд хамгааллын баг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлжээ. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, бүх бүлгийн багш нар оролцсон сургуулийн Хүүхэд хамгааллын багийн гишүүн бүрийг үүрэгжүүлж, ажлын төлөвлөгөө гарган мөрдөж байна. Хүүхэд хамгааллын багийн гишүүд сар сараар мэдээлэл солилцож, үйл ажиллагаагаа дүгнэж, тайлагнаж хэвшсэн ажээ. Сургуулийн хүүхэд хамгааллын баг нь хорооны хүүхэд хамгааллын Хамтарсан багтай илүү өргөн хүрээнд, үр дүнтэй хамтран ажиллах болж, үйл ажиллагаа нь идэвхижсэн байна. Өмнө нь сургуулийн Хүүхэд хамгааллын баг болон хорооны Хамтарсан багийн хамтын ажиллагаа хангалтгүй байсан бол төсөл хэрэгжсэнээр ийм үр дүнд хүрсэн ажээ. Сургуулийн хэмжээнд хүүхэд хамгааллын мэдээллийн хэлхээ бий болж, эрхийн зөрчил гарсан үед яаж түргэн шуурхай ажиллаж, хариу үйлчилгээ үзүүлэх вэ, нөхөн сэргээх вэ гэдэг ойлголт сайжирсан байна.

Мөн төслийн хүрээнд 2 дугаар сургуулийн анги бүр “Ангийн дүрэм”-тэй болжээ. Энэ дүрмийг бүлэг, багаараа сар бүр дүгнэн ажилладаг байна. Бүх сурагч баримтлах дэгтэй, дүрэмтэй болсноор сургалтын үйл ажиллагаа сайжирч байгаа аж. Сургуулийн өсвөр насны суралцагчдын сайн дурын оролцоо, санаачилгатай спорт, урлаг, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 клуб энэ сургуульд байсан бол “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэн өнгөрсөн гурван жилийн хугацаанд 12 болж нэмэгджээ.

Түүнээс гадна зөвхөн сурагчдын төдийгүй эцэг эхчүүдийн оролцоо нэмэгдсэн юм. Эцэг, эхчүүд сургуулийн үйл ажиллагааг ойлгож, дэмжих болсон. Сургуулийн Эцэг эхийн нэгдсэн зөвлөлөөс гадна бага, дунд, ахлах ангиуд тус бүртээ Эцэг эхийн зөвлөл байгуулжээ. Тус сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн санаачилсан суралцах

students following clear rules and guidelines, the quality of teaching and learning at the school has improved significantly.

Student engagement has grown. Previously, the school had eight student-led clubs, organized voluntarily and focused on sports, the arts, and child protection activities. Over the three years of project implementation, this number has grown to twelve, with increased participation and enthusiasm.

Increased protection has been provided in the girls’ changing room, through a micro-project initiated by the school’s Parent Council, improved the learning environment and renovated this space. As a result, girls can now change clothes in a dedicated room for physical education classes, thereby safeguarding their privacy and rights.

Engaging Parents as Partners

Parents’ attitudes have also been transformed, and their participation in school activities has increased significantly. Around 800 parents participated in multiple phases of the “Safe Families” training organized by project trainers, gaining valuable knowledge and practical skills.

Principal Tsengelmaa emphasized that it is significant not only that parents have changed their attitudes, but also that they have gained an understanding of how to actively collaborate with the school on child protection and development issues. *“Building a society where children are safe, educated, energetic, active, and creative—not one where child protection is weak and crime and violence prevail—requires the commitment of every stakeholder in child protection,” she said.*

Greater awareness among parents has strengthened collaboration significantly, providing a strong foundation for improvements in child protection and, ultimately, academic achievement. In addition to the overall Parent Council, separate parent councils have been established for each class across the primary, secondary, and high school levels, creating more opportunities for meaningful engagement.

орчинг сайжруулах, охидын хувцас солих өрөөг засварлах зорилготой бичил төсөл нь Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс зарласан бичил төслийн уралдаант шалгаруулалтад тэнцэж, санхүүжилт авсан байна. Ингэснээр охид биеийн тамирын хичээлд орохдоо тусгай өрөөнд хувцас сольж, тэр хэрээр эрхээ хамгаалуулж чаджээ. Эцэг эхчүүд ойлголтоо сайжруулснаар хамтын ажиллагаа шинэ шатанд гарч, хүүхэд хамгааллын, цаашлаад сурлагын ахиц, өөрчлөлтийг авчрах гол тулгуур болж байна.

Бид Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөлд хамрагдсандаа үнэхээр их баяртай байгаа. Маш их үр дүнтэй төсөл болсон. Өнгөрсөн гурван жилд үр дүнтэй, зохион байгуулалттай ажиллалаа. Сургуулийн жижүүр, үйлчлэгчээс эхлээд бүх багш, ажилчид тус бүрийн үүрэгтэй, зохион байгуулалттай болж, үйл ажиллагаагаа нэгтгэн тайлагнаж, засан сайжруулж, олон улсын арга аргачлалаас суралцсан. Үйл ажиллагаагаа нарийн нягт, үл үндэстэй төлөвлөж, төлөвлөснийхөө дагуу аливаа ажил, арга хэмжээг цаг хугацаанд нь, чанартай зохион байгуулж байсныг онцлон дурдаж, уг төслийн баг бүрэлдэхүүн, хамт олонд гүнээ талархаж байна. Төслийн багаас биднийг сургаж, хөгжүүлж, дэмжин тусалж, цаг үеийн мэдээ мэдээлэл, гарын авлага, материалаар хангаж, сургууль, эцэг эх, багш нар, хүүхдүүдийг жигд хөгжүүлж, чадавхжуулж өгсөнд тань талархаж байна. Төсөл дууссан ч мэдлэг, чадвар үлдэж байна. Бид хүрсэн үр дүнгээ улам бататган ахиулж, төслөөс олж авсан мэдлэг, арга зүйг сургуулийн албан ёсны бичиг баримтад тусган, бодлого, төлөвлөлтдөө нэн тэргүүнд баримтлан ажиллах болно. Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол зохион байгуулж, эцэг эхдээ тайлагнаж, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг жил бүр сайжруулна гэдгээ хэлье. Цаашид ийм ач холбогдолтой төсөл үргэлжлэх болтугай! гэж 2 дугаар сургуулийн захирал Л.Цэнгэлмаа хэллээ.

Ensuring Sustainability

“We are truly grateful to have participated this project. It has been an extremely effective initiative,” said Principal Tsengelmaa. “Over the past three years, we have worked efficiently and in an organized manner. From the school guard and janitorial staff to all teachers, every staff member has taken on responsibilities, coordinated their activities, reported systematically, and learned from international methodologies.”

She emphasized the importance of meticulous planning and systematic implementation. *“We deeply appreciate the project team for training, developing, and supporting us, providing timely information, handbooks, and materials, and helping the school, parents, teachers, and students develop and build capacity across all levels.”*

Looking ahead, Principal Tsengelmaa outlined the school's commitment to sustaining the gains. *“Even though the project has concluded, the knowledge and skills remain. We will continue to strengthen and expand the results we have achieved, integrate the knowledge and methodologies gained into the school's official documents, and prioritize them in our policies and planning. We will also conduct regular evaluations, report to parents, and continuously improve child protection activities each year. We hope that such meaningful projects will continue in the future!”*

Cooperation between district authorities and non-governmental organizations has been improving. Through the project, the efforts of all parties responsible for delivering comprehensive child protection services have been strengthened, leading to real progress and tangible results. As School No. 2 demonstrates, when schools, parents, and communities work together with clear systems and shared commitment, they can create environments where every child is protected, valued, and able to thrive.

Participation has increased not only among students but also among parents. Parents now have a clearer understanding of the school's activities and are more actively engaged in supporting them.

МЭРГЭЖЛИЙН БҮЛЭГ БАЙГУУЛЖ МЭДЛЭГ, АРГА ЗҮЙГ ТҮГЭЭВ

A PROFESSIONAL TEAM FORMED TO SHARE KNOWLEDGE AND METHODOLOGIES

Энэ хичээлийн жилд нийслэлийн ерөнхий боловсролын 33 дугаар сургуулийн 94 бүлэгт 4000 гаруй сурагч суралцаж байна. 145 багштай, ажилчид нийлбэл 200 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байна.

Тус сургуульд Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг хэрэгжүүлэх ажлын хэсэг ажилладаг. Тус ажлын хэсэг нь Захирал Н.Энхбат, Нийгмийн ажилтан Н.Цэнд, Ш.Болор-Эрдэнэ, Сэтгэл зүйч Г.Нацаг-Юм, Сургалтын менежер Б.Содонтуйа, бага ангийн багш Ш.Баасансүрэн, Г.Оюун-Эрдэнэ, дунд ангийн багш Р.Буянхишиг, Д.Уянга, А.Агваанжамц, ахлах ангийн багш О.Ариунсайхан, С.Нажидмаа, Б.Хэрлэнтуул нарын 14 гишүүнтэй.

Ажлын хэсгийг анх байгуулахдаа төслөөс хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарч сургуулийн нийт 145 багшаас бусдад нөлөөлөх чадвартай, манлайлагч багш нарын төлөөлөл сонгож, саналыг авсан байна. Өөрсдийн саналаар төслийн ажлын хэсэгт оролцох боломжтой багш, ажилтнууд багт нэгдсэнээс хойш огт солигдоогүй тогтвортой үйл ажиллагаа явуулжээ. Тиймээс багийн гишүүдийн мэдлэг, чадвар хоорондоо уялдаж, хамтын ажиллагаа, туршлага хослон тогтсон байна.

Хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа, сургалтууд нь хүүхдийн эрхэд суурилсан, оролцоог үргэлж ханган, дэмждэг. Тухайлбал, “Би найзаа дэмжинэ” үе тэнгийнхэнд чиглэсэн хөтөлбөрөөс олж авсан мэдлэг, мэдээллээ

This academic year, more than 4,000 students are enrolled in 94 classes at School No. 33. With 145 teachers and over 200 staff members, the school implements both educational and developmental activities.

N.Tsend, a social worker, serves as the head of the Project Implementation Unit (PIU) at School No. 33.

A dedicated PIU was established at the school to implement Save the Children's 'Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia' project. The PIU consists of 14 members, including school principal Enkhbat, social workers Tsend and Bolor-Erdene, psychologist Natsag-Yum, training manager Sodontuya, primary school teachers Baasansuren and Oyun-Erdene, secondary school teachers R. Buyankhishig, Uyanga, and Agvaanjamts, and senior school teachers Ariunsaikhan, Najidmaa, and Kherlentuul.

When the PIU was established, members were selected from among the school's 145 teachers based on their leadership qualities and ability to positively influence others, given the broad range of activities planned under the project. Teachers and staff who voluntarily joined the PIU have remained unchanged since its formation, ensuring stability and continuity. As a result, the members' knowledge, skills, and experience have become well-coordinated, fostering strong teamwork and the effective exchange of expertise.

Child-focused activities and trainings are designed around children's rights, consistently ensuring and supporting their participation. For

хүүхдүүд үе тэнгийн найзууддаа дамжуулан түүчээлж, сэтгэлийн зовууртай байгаа найзуудаа яаж дэмжин туслах вэ, эрхийн зөрчил гарахад хаана, хэрхэн хандах вэ гэдэг ойлголт, мэдлэг түгээжээ. “Сургагч хүүхдүүдийн үзэл бодлоо илэрхийлэх, ярих илтгэх, бусадтай харьцах чадвар эрс нэмэгдсэн. Энэхүү төсөл хэрэгжсэнээр хүүхдийн оролцоо, идэвх маш их сайжирсан. Хүүхэд хүүхдэдээ нөлөөлөх, зөвлөн туслах, дэмжих болсноор өнгөрсөн жил манай сургуульд хүүхдийн оролцооны 13 клуб шинээр байгуулагдаж, сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулж байна” хэмээн төслийн багийн гишүүн, багш Ш.Баасансүрэн ярих.

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс зарласан бичил төслийн уралдаанд тус сургуулийн сургагч хүүхдүүд дөрвөн ч төсөл бичсэн нь шалгарчээ. Тэд “Би найзаа дэмжинэ” сургалтаас олж авсан мэдлэгтээ тулгуурлан сургуулийнхаа дунд, ахлах

example, knowledge and information gained through the “I Support My Friends” peer support program is shared among students, helping them learn how to support friends experiencing emotional difficulties and how to respond appropriately in cases of rights violations.

“The peer educators have significantly improved their ability to express their opinions, speak publicly, and interact with others. Since the project’s implementation, children’s participation has greatly increased. By influencing, advising, and supporting their peers, 13 new student clubs were established at our school last year, and these clubs have been organizing various volunteer activities,” said teacher Baasansuren.

Under the Save the Children’s micro-project initiative, four project proposals from the school’s peer educators were selected. Building on the knowledge gained from the “I Support My Friends” program, they conducted sessions about “Healthy Friendships” for secondary and high school students, “Let’s Value Positive Re-



ангийнханд “Эрүүл найзын харилцаа”, дунд ангид “Эерэг харилцааг эрхэмлэе”, бага ангид “Хүнлэг хүүхэд нас” гэсэн сэдвээр тус тус сургалт явуулсан байна. Мөн сурагчид “Мэддэг байя-Мэдээлдэг байя” өдөрлөг зохион байгуулан сургуулийнхаа 2000 гаруй хүүхдийг хамруулсан тухай сэтгэл зүйч Г.Нацаг-Юм онцлов.

Түүх, нийгмийн ухааны багш С.Нажидмаа мөн сургагч багш нарын нэг юм. Тэрээр “Багш хүн өөрийгөө хэрхэн халамжлах вэ? гэсэн арга зүйд суралцсан байна. Уур бухимдалгүй байх, хүүхдүүдтэй зөв зохистой харьцах, хувийн амьдралд болсон элдэв бэрхшээлтэй асуудлыг ажлын байран дээр ил гаргахгүй байх, сэтгэл зүйн хувьд мэргэжил нэгтнээ халамжлах аргуудыг хэрэгжүүлж байна” гэж өгүүлэв.

Түүнчлэн багш Р.Буянхишиг ч мөн сургагчаар бэлтгэгдсэн юм. Тэрээр өнгөрсөн жил дөрөв дэх бага ангиа төгсгөжээ. “Миний хувьд “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс их зүйлийг суралцлаа. 25 жил ажилласан туршлагатайгаа уялдуулж, маш сайхан мэдлэг, мэдээлэл авлаа. Хийдэг байсан ч ач холбогдол өгдөггүй байсан олон зүйлийг мэдлэг болгосон. Орчин цагт суралцахуй, багшлахуйд нас, бие, сэтгэл зүйн тулгамдсан ямар асуудал байгааг анзаарч, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар ойлголттой болсон. Багш нар сэтгэл судлаач байх ёстой юм байна гэдгийг ухаарч мэдсэн” гэж өгүүлэв.

Тэгвэл тус сургуулийн бага ангийн багш, төслийн багийн гишүүн, сургагч багш Г.Оюун-Эрдэнэ хэлэхдээ, “Сурагчид, ялангуяа, бага ангийн сурагчид өөрийгөө хэрхэн халамжлах вэ гэсэн энгийн аргуудад суралцсан. Ус тогтмол ууна, хөгжим сонсоно, шим тэжээлтэй хоол идэх юм байна, уншсан номоо ангийнхандаа ярьж өгнө гэдэг нь энгийн хэрнээ ач холбогдолтой аргуудыг “Хүнлэг байя” аяны хүрээнд мэдэж, дадал хэвшил болгохын төлөө суралцаж байна. Манай ангийнхан хичээл эхлэхийн өмнө

relationships” for secondary classes, and “A Compassionate Childhood” for primary classes. . The peer educators also organized a “Let’s Inform and Be Informed” event, which reached more than 2,000 students.

Najidmaa, a history and social studies teacher, and a project trainer shared, *“I learned methods teachers can use to take care of themselves. I now apply strategies to stay calm, interact appropriately with children, avoid bringing personal challenges into the workplace, and provide psychological support to my colleagues.”*

Teacher Buyankhishig also became a trainer. Last year, she successfully guided her fourth group of primary students through graduation. *“I learned a great deal from the ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project. Combined with my 25 years of teaching experience, it provided very valuable insights. Many things I used to do without understanding their significance have now become meaningful practices. I have become more aware of the current challenges in the teaching and learning environment related to students’ age, physical development, and psychological needs, and I now understand how to address them. I realized that teachers also need to act as psychologists.”* Oyun-Erdene, a primary school teacher, project team member, and trainer, shared, *“Students, especially in the lower grades, have learned simple ways to take care of themselves. They are learning to drink water regularly, listen to music, eat nutritious meals, and share what they read with their classmates. These simple yet meaningful practices are taught through the ‘Let’s Be Humane’ campaign, helping students develop healthy habits. My students have even started doing meditation exercises before lessons begin.”*

Teaching first-grade students, Oyun-Erdene, explained that classroom rules were created with student participation and used pictures for easy understanding. Even though the students are not yet proficient readers, they can recognize and follow the rules through the illustrations. *“They learn to listen to others and greet their teacher and classmates,” she explained, emphasizing how*

анхаарал төвлөрүүлэх дасгал хийж хэвшсэн гэлээ. Г.Оюун-Эрдэнэ багш энэ жил нэгдүгээр ангитай. “Ангийн дүрэм”-ийг сурагчдын оролцоонд тулгуурлан гаргаж, тэдгээрийг зурагжуулж тайлбарласан учир хүүхдүүд хэдий сайн уншиж сураагүй ч тэмдэгжүүлсэн дүрэм бүрийг зургаар нь таньж, даган мөрдөж байна. “Би бусдыгаа сонсох ёстой юм байна, багштайгаа болон найзуудтайгаа мэндлэх ёстой юм байна” гэхчлэн цаашид тухайн хүүхдэд нэн шаардлагатай зөв дадал хэвшлийг бага ангиас нь олгож байна. Г.Оюун-Эрдэнэ багш төсөл хэрэгжсэн гурван жилд тавдугаар анги төгсгөсөн бөгөөд “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс олж авсан мэдлэг, мэдээллийг ашиглан, үр бүтээлтэй ажилласан гэж ярьсан юм.

Төслийн хүрээнд үүнээс гадна эцэг эхчүүд хоёр ч бичил төсөл хэрэгжүүлсэн юм. Нэгт, тус сургуулийн Эцэг эхийн зөвлөлөөс ахлах ангийнханд зориулан “Ирээдүйгээ хүчирхэгжүүлье”, хоёрт, зургадугаар ангийн эцэг эхчүүдэд зориулан “Эвсэг 33-Хайр бэлэглэе” сургалтуудыг зохион байгуулж, гарын авлага, материалаар хангасан байна. Энэ сургуульд “Би найзаа дэмжинэ”, “Сайн эцэг, эх”, “Сурагчдын сурч хөгжих үйл явцыг эрхэд суурилсан хандлагаар дэмжих нь”, “Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтууд амжилттай зохион байгуулагдсанаас гадна “Хүнлэг байя” нөлөөллийн аян амжилттай өрнөсөн билээ.

Хүүхэд хамгааллын мэдээллийн хэлхээ бий болж, сургалт, сурталчилгааны үр дүнд хүүхдийн эрхийн зөрчлийг мэдээлэх нь сайжирсан. Өмнө нь эрхийн зөрчил далд хэлбэртэй байсан, эрх нь зөрчигдсөн хүүхэд хэнд хандахаа мэдэхгүй, буруу алхам хийдэг байсан бол Хүүхдийг Ивээх Сангийн төсөлд хамрагдсанаар хүүхдүүд маань хэрэв эрх нь зөрчигдвөл заавал мэдэгдэх ёстой юм байна, насанд хүрэгчдийн дэмжлэг, туслалцааг авах нь зайлшгүй юм гэдгийг ойлгосон нь ач холбогдолтой байлаа гэж нийгмийн ажилтан Н.Цэнд яриу.

the project helps children acquire essential habits from an early age. Over the three years of the project, Oyun-Erdene guided consistently applied the knowledge and skills she gained from the project in her teaching.

Within the framework of the project, parents also implemented two micro-projects. The school's Parent Council organized “Empowering Our Future” for senior students, while parents of sixth-grade students organized “Unity 33 - Let's Give Love,” providing participants with manuals and materials.

The school successfully implemented trainings such as “I Support My Friends,” “Safe Families,” “Supporting Students’ Learning and Development Through a Rights-Based Approach,” and “Preventing Children from Experiencing Violence.” The “Let's Be Humane” campaign was also effectively carried out.

A workflow chart for child protection services was established, and, thanks to trainings and awareness activities, the reporting of children's rights violations has improved. Previously, such violations often went unreported, and affected children did not know whom to turn to or how to respond, which sometimes led to poor decisions. Through participation in the Save the Children project, children have learned when their rights are violated, it is essential to report it and seek support and assistance from adults. This has been a particularly important achievement, explained social worker Tsend.

Over the past two years, the administration of School No. 33 has implemented significant measures to enhance child protection and support parents. One major initiative was the renovation and expansion of the school entrance area. Previously, the waiting hall was cramped and cold, which caused difficulties during the winter months-especially for parents of younger students. Now, parents can wait in a warm and comfortable environment while accessing information on children's relationships and behavior from the wall-mounted boards. The school has made it a regular practice to display campaign posters, advice, and information for parents.

33 дугаар сургуулийн захиргаа өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хүүхэд хамгаалал, эцэг эхчүүдийг дэмжих чиглэлээр томоохон хийсэн ажил нь, сургуулийн үүдний хэсгийг тохижуулж, өргөтгөн томруулсан байна. Хүлээлгийн танхим урьд нь зай багатай, хүйтэн байсан учир ялангуяа, бага ангийн сурагчдын эцэг эхчүүд хүүхдээ хүргэж өгч, авахдаа багталцахгүй, өвлийн улиралд даарах гэх мэт асуудлууд гарч байжээ. Тэгвэл одоо дулаан, тохитой орчинд эцэг эхчүүд хүүхдээ хүлээнгээ, ханын самбараас хүүхдийн харилцаа, хандлагатай холбоотой мэдлэг, мэдээлэл авдаг болжээ. Сургуульд хэрэгжсэн нөлөөллийн аяны сурталчилгааны хуудсууд, эцэг эхэд зориулсан зөвлөгөө, мэдээллийг байршуулж хэвшсэн байна.

Сургуулийн захиргаа эрсдэлийн үнэлгээг эцэг эх, сурагчидтайгаа хамтран хийж хэвшүүлсэн тухай нийгмийн ажилтан Ш.Болор-Эрдэнэ онцлов. Эрсдэлийн үнэлгээг хийсний үр дүнд гуравдугаар давхрын бүх цонхонд

Risk assessments in collaboration with parents and students have been prioritized, highlighted by social worker Sh. Bolor-Erdene. Based on these assessments, protective nets were installed on all the third-floor windows, which had no window sills. Cleaning and maintenance staff now use yellow triangular warning signs to reduce the risk of accidents. Student restrooms were renovated to be well-lit and equipped with mirrors. Outside the school, a bicycle parking area was created, and during the busy periods when school shifts change, the flow of students entering and exiting is managed separately. These and other measures guided by the risk assessment findings have created a safer and more child-friendly environment.

School No. 33 has also established a visitor registration system: all parents and guests entering the school are issued a "Visitor" ID card before being allowed inside. According to social worker Tsend this has been a major step forward in ensuring children's safety.



хамгаалалтын тор хийжээ. Энэ нь хүүхдэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж чаджээ. Түүнээс гадна цэвэрлэгээ, үйлчилгээний ажилтнууд ажлын байрандаа шар өнгийн, гурвалжин тэмдэг хэрэглэдэг болсон нь сурагчдыг унаж бэртэхээс сэргийлж чадсан байна. Мөн сурагчдын үйлчлүүлдэг ариун цэврийн өрөөг засварлан тохижуулж, гэрэл гэгээтэй, тольтой болгожээ. Сургуулийн гадна орчинд дугуйн зогсоолтой болсон, хичээлийн ээлж солигдох их ачааллын үеэр сургуулиас гарах, орох урсгалыг тусад нь зохицуулсан зэргээр олон ажил, арга хэмжээг эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан хийжээ.

33-р сургууль руу гаднаас нэвтрэн орж буй эцэг эх, зочдыг бүртгэн “Зочин тэмдэг” зүүлгэж хэвшүүлсэн байна. Энэ нь хүүхдийн аюулгүй байдлыг хангахад томоохон түлхэц болсон талаар нийгмийн ажилтан Н.Цэнд өгүүллээ.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжиж буй хот, хөдөөгийн 14 сургуулийн төлөөлөл тус сургуульд айлчлан, туршлага солилцсон байна. Түүнчлэн төслийн донор байгууллагаас албаны хүмүүс зочлон ирж үйл ажиллагаатай нь танилцсанаас гадна Англи улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд мөн тус сургуульд айлчлан, төслийн үр дүнтэй танилцсан нь тэдний ажилд урам нэмжээ.

Сургагч багш нарын онцолсноор, тэд “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн арга зүйг авч үлдэхийн тулд, цаашид тогтвортой ажиллаж, амжилт гаргах зорилгоор “Мэргэжлийн хөгжлийн бүлэг” байгуулжээ. Мэргэжлийн хөгжлийн энэ бүлгээр дамжуулан төслөөс үлдсэн өргөн хүрээтэй мэдлэг, шинэлэг арга зүй үе үед уламжлагдан түгэх боломжтой болжээ.

Representatives from 14 other urban and rural schools participating in the project have visited School No. 33 to exchange experiences. Officials from the donor organization and the UK Ambassador to Mongolia toured the school to observe its activities and outcomes, providing further motivation for the school team.

To sustain and expand the methodology of the project, the trainers have established a “Professional Development Group.” Through this group, the extensive knowledge and innovative practices from the project can be shared across generations, ensuring long-term impact and continuity.

МӨРӨӨДЛИЙН 130-Р СУРГУУЛЬ

DREAM SCHOOL NO. 130

Нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургуулийн захирал Ө.Болормаа нь боловсролын байгууллагын удирдах албан тушаалд нийтдээ 17 жил, мөн тус сургуулийг удирдаад таван жил ажиллаж байгаа туршлагатай хүн юм. Тэрээр өгүүлэхдээ,

130 дугаар сургууль нь 2015 онд бага сургуулийн статустайгаар байгуулагдсан. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар орчин үеийн, шинэ, тохилог байр баригдаж, 2021 оны намраас бүрэн дунд сургууль болон өргөжиж, сургалтын үйл ажиллагаагаа явуулах болсон. Шинэ хамт олон бүрэлдэж, бүхнийг шинээр эхэлж байх тэр үед “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэн нь нүдээ олсон хэрэг байв. Бага сургууль байхдаа 5 бүлэгт, 150 гаруй хүүхэдтэй байсан бол дунд сургууль болсноор 178 багш, ажилтантай, 4000 гаруй суралцагчтайгаар, хоёр ээлжээр хичээллэж байна. Нийт багш, сурагчдын 90 орчим хувь нь шинээр бүрдсэн юм.

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл 2023-2025 онд, гурван ч хичээлийн жил дамнан амжилттай хэрэгжиж байна. Төслийн ач холбогдол үнэхээр их.

- **Нэгдүгээрт**, багш нар маань чадваржсан. Тэд хүүхэд хамгааллын чиглэлээр олон сургалтад хамрагдсан. Төслийн хүрээнд

Bolormaa, principal of General Education School No. 130 in Ulaanbaatar, has 17 years of experience in leadership positions within educational institutions and has led this school for the past five years. She shared:

School No. 130 was established in 2015 as a primary school. With a grant from the Government of the People's Republic of China, a modern, new, and comfortable building was constructed. From the fall of 2021, the school expanded into a full secondary school and began offering educational programs. When the new staff joined and everything was starting from scratch, the implementation of the “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project arrived at the perfect time.

As a primary school, it had five classes with more than 150 students. Now, as a secondary school, it has 178 teachers and staff, over 4,000 students, and operates in two shifts. Approximately 90 percent of the teachers and students are newly enrolled.

The project by Save the Children has been successfully implemented over three academic years, from 2023 to 2025, and continues to run, making a significant and lasting impact.

- **First**, our teachers became more skilled. They participated in multiple trainings on child protection. Under the project, teachers trained to become trainers shared their knowledge with students,

сургагчаар бэлтгэгдсэн багш нар хүүхэд, эцэг эх, бусад мэргэжил нэгтнүүддээ эерэг харилцаа хандлага, хүмүүжил, төлөвшлийн талаар мэдээлэл өгч, мэдлэг дамжуулсан.

- **Хоёрдугаарт**, шинэ сургуульд энэ тэндээс ирсэн хүүхдүүд нэгэн анги, хамт олон болно гэдэг ялангуяа, дунд, ахлах ангид амаргүй байсан. Гэвч төсөл хэрэгжсэнээр өнөөдөр сурагчид маань хоёр биш, хорин жил болчихсон юм шиг ижилдэн дасаж, нөхөрлөн суралцаж, анги хамт олон бүр нэгэн цул болж чадсан байна. Энэ бол “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн ач тус мөн.
- **Гуравдугаарт**, багш, сурагч, эцэг эхэд зориулсан маш олон сайхан гарын авлага, материалаар хангасан. “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар” гарын авлагын дагуу хүүхэд хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болж байлаа. Дараа нь, “Би найзаа дэмжинэ” үе тэнгийнхэнд чиглэсэн хөтөлбөрийн сургалтын гарын авлага гарч, мэдлэг, хэрэглээ болгосон. “Би найзаа дэмжинэ” сургалтын сурагчдад зориулсан ажлын дэвтэр”, “Багшийн ажлын дэвтэр”, “Сайн эцэг эх” сургалтын гарын авлага,” “Сургуульд баримтлах ёс зүйн дүрэм” гэх мэт нийт 14 орчим гарын авлага материалуудыг төслийн хүрээнд бидэнд өгсөн байна. Бүгд л шинэ арга зүйг нутагшуулахад өгүүлшгүй ач тустай байсан.
- **Дөрөвдүгээрт**, төслийн хүрээнд эцэг эх, асран хамгаалагчид маань хандлагаа өөрчилж, суралцсан. Бид 800 гаруй эцэг эх, асран хамгаалагчдад “Сайн эцэг эх” сургалтыг үе шаттай явуулсан. Сургалт эхэлж байхад бүхмидэх нь цөөнгүй байсан ч сургалтын төгсгөлд бүгд

parents, and colleagues on positive relationships, behavior, and personal development.

- **Second**, in a new school, it was not easy for children from different places to come together as one class and one community, especially in the middle and high grades. However, with the project's implementation, our students have now bonded so well that it feels as if they have been together not for two years, but for twenty. They have learned, grown, and built friendships, and each class has become a truly united community. This is a key benefit of the project.
- **Third**, the project provided a wide range of excellent manuals and materials for teachers, students, and parents. Following the “Exemplary Model of Child Protection Mechanism in General Education Schools” manual, we were able to develop a child protection action plan. Later, the “I Support My Friends” peer-focused program training handbook helped us turn knowledge into practical application. Within the framework of the project, we received around 14 different manuals and materials, including the “I Support My Friends” training participant's workbook, the “Teacher's Workbook,” the “Safe Families” training manual, and the “School Code of Conduct.” All of these resources were invaluable in helping us adopt new methods effectively.
- **Fourth**, parents and caregivers changed their attitudes and learned new skills through the project. We conducted the “Safe Families” training for over 800 parents and caregivers in stages. While some were initially reluctant or frustrat-



инээсэн, баяссан, сэтгэл дүүрэн байсан. “Маш ихийг мэдэж авлаа. Хүүхэдтэйгээ ингэж харилцах ёстой юм байна” гэдгийг ойлгосон.

- **Тавдугаарт**, сургууль маань шинэ тулгар учир эцэг эхчүүд биесээ танихгүй, “шуудайд хийсэн үхрийн эвэр” шиг л байлаа. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд харин “Ерөнхий боловсролын сургуулийн эцэг эх, асран хамгаалагчдын зөвлөлийн ажиллах жишиг удирдамж” гарын авлагын дагуу төслийн хүрээнд бид сургуулийн Эцэг эхийн зөвлөлийг байгуулж чадсан. Тус төслөөс зарласан бичил төслийн шалгаруулалтад сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн

ed, by the end of the training, everyone was smiling, happy, and satisfied. They realized, “We have learned so much. This is how we should interact with our children.”

- **Fifth**, because our school was new, parents did not know each other, and the community felt disconnected, like “horns in a sack.” Following the “Exemplary Guidelines for School Parents’ Council” manual, the project helped us establish the school’s Parents’ Council. Micro-project proposal initiated by the Parents’ Council to improve the school’s restroom facilities was selected and funded. Through this micro-project, a total of 46 toilets across the school’s wings and floors were renovated.

санаачилсан ариун цэврийн өрөөний тохижилтыг сайжруулах төсөл шалгарч, санхүүжилт авсан. Бичил төслөөр сургуулийн жигүүр, давхар бүрд нийт 46 суултуурыг шинэчилсэн юм.

Багш, ажилчдын хүүхэд хамгааллын баг давхар ажилладаг

130 дугаар сургуульд Сургуулийн хүүхэд хамгааллын багаас гадна байгууллагын багш, ажилчдын хүүхэд хамгааллын баг давхар ажилладаг байна. Багш, ажилчдын хүүхэд ч бас эрхтэй.

Номын санч Солонго гэхэд хоёр хүүхдээ дагуулж холоос ирдэг. Нэгдүгээр ангийн бага хүүхэд нь өглөө, тавдугаар ангийн том нь үдээс хойш хичээлтэй. Тэд тусгайлан тохижуулсан өрөөнд гэртээ байгаа мэт тав тухтай байж, хооллож ундлан, даалгавраа хийж, хичээлдээ сууж, унтаж амарч, ээжийгээ тарахад орой цуг харьдаг байна. Байгууллага дотоод зохион байгуулалт, нөөц бололцоогоо ашиглан ийм баг байгуулж ажиллуулснаар багш, ажилчдын хүүхдийн эрх хамгаалагдаж, тухайн багш, ажилтан ар тийшээ санаа зовохгүйгээр ажлаа сайн хийж гүйцэтгэх нөхцөл бүрджээ.

Сургуулийн захиргаанаас хүүхэд хамгаалалтай холбоотойгоор бүх багш, ажилтантайгаа нууцлалын гэрээ байгуулжээ. Жижүүр, үйлчлэгчээс эхлээд бүх хүн хүүхдийн нууцлалыг хадгалах, эрхийг нь хамгаалах үүрэгтэй.

Барилгын газрыг чөлөөлж, спортын талбай байгуулав.

130 дугаар сургуулийн гадна орчинд эргэн тойронд нь өндөр барилгууд баригдаж, олон кран сургуулийн дээгүүр эргэлдэж байгаа нь гадаад орчны эрсдэл өндөртэй байсаар байгааг онцлон ярилаа.

Child Protection Team for Teachers and Staff Operates in Parallel

At School No. 130, in addition to the School's Child Protection Team, there is a separate Child Protection Team for teachers and staff, recognizing that the children of school employees also have rights.

For example, the school librarian, Solongo, brings her two children from afar. Her younger child in Grade 1 attends classes in the morning, while her older child in Grade 5 attends in the afternoon. They stay in a specially arranged room where they feel as comfortable as at home they eat, drink, do homework, attend lessons, rest, and sleep. In the evening, they return home together when their mother finishes work.

By organizing and operating this team using its internal resources and capacities, the school ensures the rights and protection of teachers' and staff's children, allowing staff members to focus on their work without worry.

Additionally, the school administration has signed confidentiality agreements with all teachers and staff regarding child protection. Everyone from guards to cleaners is responsible for maintaining children's confidentiality and safeguarding their rights.

Cleared the construction site and built a sports field

Bolormaa noted that the area around School No.130 is surrounded by tall buildings, and with 32 cranes operating above the school, the external environment posed significant risks to children.

In a positive development, the school reached an agreement with a company that had planned to build on the adjacent land. The school took control of the site and, with an investment of 235 million MNT last year, established a football field

Харин нэг олзуурхууштай нь, тус сургуультай хаяа нийлэн хашаа барьж, барилга барихаар ээхэж байсан компанитай тохиролцож, тухайн газрыг сургууль мэдэлдээ авч, өнгөрсөн жил 235 сая төгрөгөөр хөл бөмбөгийн болон 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулсан нь үр дүнтэй, хүүхэд хамгаалал, хөгжлийн томоохон ажил болжээ.

Захирал Ө.Болормаа “Хүүхдийг Ивээх Сангийн хамт олон, төслийн багийн нийт бүрэлдэхүүнд хувиасаа болон хамт олон, багш, ажилчид, сурагчид, эцэг эх, асран хамгаалагчдынхаа нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье!” гэлээ.

and a 3x3 basketball court. This initiative proved highly effective, representing a major step forward in both child protection and student development.

“I want to express deep gratitude on behalf of myself, the school staff, students, parents, and guardians to the entire team of Save the Children and the project team for their contributions,” said Bolormaa, principal of School No. 130.



ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ӨНӨӨДӨР

TODAY FOR A BETTER FUTURE

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Х.Азбаяр 2019 оноос энэ албан тушаалд ажиллаж байна. Уг хэлтэс нь хүүхдийн тусламжийн 108 дугаар болон 102, 107 утсаар ирсэн дуудлага мэдээлэлд шуурхай тусламжийн хариу үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэн, үндсэн гурван чиглэлээр ажилладаг. Хэлтсийн харьяанд гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв бий. 24 цагаар жилийн турш тасралтгүй үйл ажиллагаатай энэ төв өнгөрсөн жил 202 хүүхэд, 24 насанд хүрсэн иргэнд үйлчилжээ.

Эдүгээ энэ хамт олон 52 орон тоотой, эндэхийн хамгааллын багийн нэг мэргэжилтэн жилд дунджаар 22-25 кейсийн тохиолдол дээр хэрэг хариуцан хууль ёсны төлөөлөгчөөр ажилладаг байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд цагдаагийн байгууллагад очихоороо сүрддэг, айж эмээдэг, анхны мэдүүлгээсээ буцдаг тохиолдол бий учир хувь хүний нууцлалыг хангасан, хүүхдийн сэтгэл зүйд нөлөө үзүүлэхгүй өрөө тасалгаанд ярилцах нь чухал тул хүүхдээс мэдүүлэг авах өрөө

How District-Level Coordination Strengthened Child Protection in Chingeltei

Chingeltei District, Ulaanbaatar is home to more than 47,000 households with over 67,000 children. Each year, the district receives more than 700 calls related to family and child rights violations, a stark reminder of the urgent need for comprehensive, coordinated child protection services. Behind each of those calls is a child in need, a family in crisis, and a system that must respond quickly and effectively.

Azbayar has been serving as the Head of the Child and Family Development and Protection Department since 2019. His department, which evolved from the “Child Development Center” established in 2014, now employs 52 staff members working across three main areas: providing rapid response services through the child helpline 108 and hotlines 102 and 107; offering protection and rehabilitation services; and implementing preventive programs for children and families.

The scale of their work is immense. Each protection officer handles an average of 22–25 cases per year, serving as a child's legal representative

ашиглалтад оруулахаар зэхжээ.

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл Чингэлтэй дүүрэгт амжилттай хэрэгжихэд тус хэлтсийн үүрэг оролцоо багагүй байсан юм. Өнөөдөр энэ дүүрэгт төрийн болон хувийн хэвшлийн 25 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Хэлтсийн дарга Х.Азбаяр “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн үр дүн, ач холбогдлыг хэд хэдэн чиглэлээр тодорхойлон ярих. Үүнд,

Нэгдүгээрт, тус төсөл нь тус тусдаа, саланги ажиллаж байсан сургуулийн хүүхэд хамгааллын баг болон хорооны Хамтарсан багийг нэгтгэн, чадавхжуулсан. Ижил зорилготой энэ хоёр бүтэц хамтын ажиллагааны гэрээ байгуулж, жилийн ажлаа төлөвлөдөг болсон. Гэрээг даган хариуцлага ирж байгаа юм. Гэрээний биелэлт болон төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэн, цааш илүү үр дүнтэй ажиллах боломжтой болсон. Төслийн ажилтнууд сургуулийн ажлын хэсгийн гишүүд болон хорооны Хамтарсан багт сардаа 1 удаа биечлэн очиж, ажлын байран дээр нь зөвлөгөө өгч, туслан дэмжиж ажиллаж байсан.

Хоёрдугаарт, хүүхэд сургууль дээр өдрийн дийлэнх цагийг өнгөрөөдөг. Тэгвэл сургуулийн орчинд хүүхэд хамгааллыг төслийн хүрээнд сайжруулснаар хүүхдийн эрх зөрчигдөхгүй, цаашлаад гэр бүлийн хүрээн дэх гэмт хэрэг, зөрчлийн тоо багасах, урьдчилан сэргийлэх боломж бүрдүүлсэн.

Гуравдугаарт, Төслийн хүрээнд ганц хүүхэд гэлтгүй, эцэг эх нь ойлголт, мэдлэгтэй болж, хандлагаа өөрчилж, оролцоо нь нэмэгдсэн сайн тал ажиглагдаж байна. Хүүхдийг Ивээх Сан төслөөрөө дамжуулан тухайн сургуульд Эцэг эхийн зөвлөлийг яаж байгуулж, яаж ажиллуулах талаар жишиг тогтоож өгсөн. “Сайн эцэг эх” сургалтад Чингэлтэй дүүргийн төсөл хэрэгжсэн 17 болон 50 дугаар сургуулийн 1600 гаруй эцэг эх хамрагдаж, хүүхдийн насны онцлогт тохируулан хэрхэн

through complex, often traumatic situations. Under the department’s supervision a One-Stop Service Center operates, which supports witnesses and victims of domestic violence. Open 24 hours a day throughout the year, the center assisted 202 children and 24 adults last year alone.

Yet despite the department’s dedication and resources, a critical gap remained: schools and community-level protection teams were working in parallel rather than in partnership.

The Challenge: Breaking Down Silos

In Chingeltei District, 25 public and private schools that serve thousands of children had a Child Protection Team responsible for identifying and responding to issues within the school environment. Simultaneously, Multi-Disciplinary Teams (MDTs) at the khoroo (sub-district) level worked to address child protection concerns in the broader community.

The problem was simple but significant: these two groups worked separately and independently. Schools focused on what happened within their walls. Community teams focussed on what happened outside. A child experiencing violence at home brings that trauma to school, and school-based interventions often require family and community support to succeed.

“Since they share the same goals,” Azbayar explains, “they needed to work together.” But creating that collaboration required more than good intentions—it required a systematic approach, clear protocols, and ongoing support.

Another challenge emerged from the nature of child protection work itself. Because children who experience violence often feel scared, intimidated, or may retract their statements when speaking with police. The department recognized the need for a special interview room, a dedicated space that would ensure confidentiality and provide a safe, psychologically supportive environment for children to share their experiences.

яаж, зөв харилцах вэ гэдгийг мэдэж авсан. Тус үйл ажиллагааны үеэр хамтарсан багийн гишүүд ирж танилцуулга мэдээлэл өгч урьдчилан сэргийлэх ажлыг хамтран хийж ажиллажээ.

Дөрөвдүгээрт, сургуулийн төсөл хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулж, багш нарыг хүүхэд хамгааллын чиглэлээр шат дараатайгаар сургаж, сургагч багшаар бэлтгэсэн. Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийлэл гэж юуг хэлэх вэ, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хэрхэн таньж мэдэх вэ гэсэн агуулгаар багш нар маань мэдлэг, мэдээлэлтэй болж, бусад багш нарт энэ мэдлэгээ дамжуулан түгээсэн. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд зөвхөн багш нарт зориулан 6 төрлийн сургалт болжээ. Хүүхэд хамгааллын бүтцийг сайжруулж, уялдаа холбоог хангасанд уг төслийн ач холбогдол оршиж байна.

Тавдугаарт, ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үлгэрчилсэн загварыг гаргаж, нутагшуулсан. Тэр дагуу зөвхөн багш төдийгүй сургуулийн үйлчлэгч, жижүүр, тогоочоос эхлээд хүүхэд хамгааллын ажилд хэн нь ямар үүрэгтэй байхыг тодорхойлсон нь үнэхээр сайн үлгэр дуурайлал боллоо.

Зургадугаарт, сургуульд баримтлах ёс зүйн дүрэм буюу ээлтэй сургууль байхын тулд ямар зарчим мөрдөх ёстой вэ? Энэ чиглэлээр олон улсын гарын авлага, материалыг Монголын хөрсөнд буулгаж, ном, товхимол болгон хэвлэж түгээсэн байна. Жишээ нь:

- “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэн сургуулиудад хүүхэд хамгааллын “Мэдээллийн хэлхээ” бий болж, хүүхдүүд энэ хэлхээгээр дамжуулан хэрэв эрх зөрчигдвөл хаана, хэнд хандахаа нарийн тодорхой мэдэж авсан.
- “Би найзаа дэмжинэ” сургалт нь үе тэнгийн дээрлэхэлтийг таслан зогсооход чухал нөлөөтэй байлаа. Нэг сургуулиас гэхэд 125 хүүхэд энэ сургалтад

The Solution: Systematic Coordination and Capacity Building

When Save the Children’s “Establishing School-Based Child Protection Mechanisms in Mongolia,” project came to Chingeltei District, it provided exactly what was needed: a framework for bringing schools and community protection teams together, along with the training and resources to make that coordination effective.

The department played a key role in implementing the projects within the district, working with Schools No. 17 and No. 50 as pilot sites.

Creating Formal Partnerships

The project brought together and strengthened the capacity of the Child Protection Teams in district schools and the Multi-Disciplinary Teams at the khoroo level. Most importantly, it formalized their relationship through cooperation agreements. These agreements ensure that schools and MDTs now plan their annual activities together, creating a unified approach to child protection.

The agreements also created accountability. Implementation of the work plans is reviewed and evaluated, providing opportunities for more effective collaboration and ensuring that coordination isn’t just aspirational but operational. Project staff visited the schools’ project implementation units and the MDTs once a month, providing on-the-job consultations and support that kept the coordination functioning smoothly.

Building Capacity at Every Level

The project established implementation units in Schools No. 17 and No. 50, with teachers receiving systematic training in child protection. These teachers became project trainers, learning what constitutes a violation of children’s rights or violence, and how to identify children who may have experienced such harm. They then shared this knowledge with their colleagues through six different training programs specifically designed for educators.

хамрагдаж, олж авсан мэдлэгээ амьдралд бүтээлчээр хэрэглэх зорилгоор хоёр ч удаа төсөл бичиж, уралдаант шалгаруулалтад орсон байна.

- Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн бас нэг онцлог нь, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдэд зориулсан өөрийгөө хайрлах заавар зөвлөмж гаргасан явдал юм.

Энэ төслийн үр дүн цаашид бусад сургуулиудад дамжин нутагшаасай, гэр бүл, үр хүүхдүүд бүгд аз жаргалтай амьдраасай гэж хүсье. Хамтран ажилласан Хүүхдийг Ивээх Сангийн төслийн баг хамт олонд ажлын амжилт, сайн сайхныг ерөөе! гэж Чингэлтэй дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Х.Азбаяр эцэст нь өгүүлсэн билээ.

Тодруулга:

Чингэлтэй дүүрэгт эдүгээ 47 мянга гаруй өрхөд 67.000 гаруй хүүхэд амьдарч байна. Гэр бүл, хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой жилдээ 700 гаруй дуудлага мэдээлэл ирдэг аж. Чингэлтэй дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс нь анх Засгийн газрын шийдвэрээр 2014 онд “Хүүхэд хөгжлийн төв” нэртэйгээр байгуулагдаж байсан. 2017 онд орон тоо нь нэмэгдэж, хэлтэс болон өргөжиж, өнөөгийн бүтцээр ажиллах болжээ.

But the project went further than training teachers. An ‘Exemplary Model of Child Protection Mechanism in General Education Schools’ was developed and adapted to the local context. Under this model, not only teachers but also school staff such as cleaners, guards, and cooks were assigned specific roles in child protection. This comprehensive approach ensured that every adult in a school understood their responsibility to protect children, creating a practical model for others to follow.

Empowering Parents as Partners

More than 1,600 parents from the two schools, attended the ‘Safe Families’ training, where they learned effective communication methods tailored to their children’s age and developmental needs. The impact extended beyond knowledge—parents gained greater understanding, shifted their attitudes, and became more actively involved in supporting their children.

Significantly, members of the Multi-Disciplinary Teams also participated in these parent training. This integrated approach meant that parents weren’t just learning theory—they were connecting directly with the professionals who could support their families if problems arose.

Creating Child-Friendly Systems

To establish ethical rules and create child-friendly schools, the project adapted international guidelines and materials to the Mongolian context and published books and brochures for distribution.

In schools where the project was implemented, a workflow chart for Child Protection Services was created. This chart helped children understand exactly where and to whom they should report if their rights were violated. The visible, accessible system ensured that every student knew how to get help.

The “I Support My Friends” school-based peer support training program had a significant impact on preventing bullying among students. In one school alone, 125 children participated in

the training. To apply what they had learned creatively, the students wrote two successful project proposals and submitted them for approval.

Another notable achievement of the project was the development of a self-care guide for child protection professionals, recognizing that those who work with trauma and crisis daily need support for their own wellbeing.

The Impact: A Coordinated System That Works

The transformation in Chingeltei District extends across multiple dimensions, each reinforcing the others to create a comprehensive child protection system.

Prevention Through Presence

Since children spend most of their day at school, strengthening child protection within the school environment through the project has helped create conditions that prevent violations of children's rights. When teachers are trained to recognize early warning signs, when every staff member understands their role, and when children know how to report concerns, problems can be identified and addressed before they escalate. This school-based prevention has had ripple effects beyond the classroom. This initiative has also played a role in reducing and preventing crimes and offences within families, as parents who understand child development and positive communication create safer home environments.

Strengthening the Entire System

The cooperation agreements between schools and MDTs have transformed how child protection cases are handled. When a school identifies a child at risk, they can immediately coordinate with the khoroo MDT for family support, counseling, or intervention. When the MDT learns of a family situation affecting a child's wellbeing, they can connect directly with the school to ensure appropriate support during the school day. The project's significance lies in strengthening

the child protection system and improving coordination among all stakeholders.

Looking to the Future

"I hope the results of this project will continue to expand to other schools, and that all families and children may live happy lives. I wish success and all the best to the Save the Children project team who collaborated with us," concluded Azbayar,



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАГВАР НУТАГШИН ҮЛДЛЭЭ

A MODEL OF COLLABORATION TAKES ROOT

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны нийгмийн ажилтан, тус хорооны хүүхэд хамгааллын Хамтарсан багийн гишүүн Ц.Ариундарь,

-Би 2012 оноос Хорооны нийгмийн ажилтнаар ажиллаж байна. Өмнө нь дүүргээс зохион байгуулсан зарим сургалтад Хүүхдийг Ивээх Сангаас багш нар ирж хичээл заахад нь хэд хэдэн удаа таарч байсан. Хүүхдийг Ивээх Сан нь хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, мэргэшсэн баг хамт олон, багш нартай, олон төрлийн сургалт зохион байгуулдаг гэдгийг мэддэг байсан. 2023 оноос бүр илүү мэдэж, тэр байтугай, Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж, мэргэжлээрээ ахиж хөгжих боломж олдсон юм.

Түүнчлэн Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг

Ariundari, a social worker in Khoroo No.3 of Bayanzurkh District in Ulaanbaatar and a member of the khoroo’s Multi-Disciplinary Team (MDT), shared her experience. I have been working as a khoroo social worker since 2012. In the past, I occasionally attended district-level trainings facilitated by Save the Children. I knew that Save the Children is a professional organization specializing in child protection, with experienced staff and trainers who organize a wide range of educational programs.

Since 2023, I have gained a much deeper understanding of their work and even became part of Save the Children’s ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project. This involvement has provided me with valuable opportunities to grow and develop professionally in my field.

Under this project, the khoroo’s MDT and the School Child Protection Team have, for the first time, signed a three-year collaboration agree-

сайжруулах нь төслийн хүрээнд: Хорооны хамтарсан баг, сургуулийн хүүхэд хамгааллын баг хоёр хамтран ажиллах 3 жилийн гэрээг анх удаа байгуулж, хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд маш олон сайн туршлагууд бидэнд үлдэж байгаад талархаж байна. Төслийн баг хамт олонд үнэхээр их баярлалаа гэж яриагаа эхлэв.

Төсөл хэрэгжсэн өнгөрсөн хоёр жил гаруйн хугацаанд олон зүйл сайжран өөрчлөгдсөн байна. Нэгдүгээрт, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлууд идэвхижсэн. Хоёрдугаарт, хорооны Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулснаар тогтвор суурьшилтай, санаачилгатай ажиллах боломж бүрдсэн. Дурдвал үр дүн их байна. “Хүүхэд хамгаалал” гэхээр л нийгмийн ажилтан л мэднэ. Нийгмийн ажилтны л хийх ажил” гэх хандлага түгээмэл байсан. Төсөл хэрэгжиж, чадавх бэхжүүлэх олон сургалтад хамрагдсанаар үзэл хандлага өөрчлөгдөж байна. “Хүүхэд хамгаалал бол ганц нэг албан тушаалтны үүрэг биш багш, эцэг эх, хүүхэд, Хамтарсан баг, аль алиных нь оролцоо, идэвх, санаачилгын нэгдэл юм” гэдгийг ойлгож, хамтдаа хамтран ажиллах ёстой юм байна гэдэг хандлага тогтож байгаад талархаж байна.

Манай хорооны хүүхэд хамгааллын Хамтарсан баг 8 гишүүнтэй. Хорооны Засаг дарга ахалдаг. Хүүхэд хамгааллын тухай шинэчилсэн хуулийн дагуу энэ оны 2 дугаар сараас “Хүүхэд хамгааллын нийгмийн ажилтан” гэсэн шинэ орон тоо бий болсон. Хамгааллын нийгмийн ажилтан маань хамтарсан багийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна. Хорооны хөгжлийн, халамжийн, өрхийн, сургуулийн нийгмийн ажилтнууд, хэсгийн байцаагч нар Хамтарсан багийн гишүүнээр ажилладаг. Хамтарсан баг нь тухайн кейсийн асуудлаар тухайн хүүхдэд ямар үйлчилгээ шаардлагатай гэдгийг нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтэд үндэслэн үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө гаргаж, ажиллаж байна. Энэ бүхэн “Сургуультай

ment to work together. I am very grateful for this partnership, which has resulted in numerous valuable best practices.

Transforming Mindsets and Practices

Over the past two years, since the project's implementation, many improvements and positive changes have taken place. First, training, awareness-raising, and advocacy activities in child protection have become more active and consistent. Second, by strengthening the capacity of the Multi-Disciplinary Team, its members are now able to work in a more stable, proactive, and initiative-driven manner.

The results have been remarkable. Previously, the common perception was that “*child protection is only the responsibility of social workers*” or “*it's the social worker's job.*” Through the project and participation in numerous capacity-building trainings, this mindset has begun to change. There is now a growing understanding that child protection is a collective effort that requires the involvement, initiative, and active participation of teachers, parents, children, and the MDT. I am grateful that this collaborative mindset has taken root and that we are learning to work together.

Strengthening The Multi-Disciplinary Team

Our khoroo's Multi-Disciplinary Team consists of eight members and is led by the Khoroo Governor. In line with the updated Child Protection Law, a new position *Social Worker for Family and Children* was established in February 2025. This social worker now serves as the secretary of the Multi-Disciplinary Team.

The MDT includes social workers serving in various roles, including development, welfare, family and children, and school, as well as khoroo inspectors. The Multi-Disciplinary Team develops and implements individualized service plans for each child based on the findings of situational assessments, identifying what support each child needs.

хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд ажлын байран дахь зөвлөгөөг тогтмол авснаар хүрсэн үр дүн юм. Хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, нөхөн сэргээх, хариу арга хэмжээ аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь нэн чухал юм.

Төслийн хүрээнд Улаанбаатар хотын 10 сургууль, 10 хороо хамтран улирал бүр кейс хэлэлцүүлэгт оролцож, Хүүхдийг Ивээх Сангийн мэргэжилтнүүдээс арга зүйн дэмжлэг авч ажилласан. Энэ туршлагадаа тулгуурлан бид сургуулийн хүүхэд хамгааллын багтайгаа хамтран кейс хэлэлцүүлгийг бие даан зохион байгуулж, ажиллахад хүндрэлтэй кейсийн асуудалд мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж хэвшүүлсэн.

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд ажиллахад хүндрэлтэй гурван кейсээр 10-аад кейс хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Эдгээр хэлэлцүүлгийн үр дүнд бид Баянзүрх дүүргийн Гэр бүл, хөгжлийн хэлтсийн хүүхэд хамгааллын зардлаас 3 кейсийн асуудалд сэтгэл заслын үйлчилгээ, хууль эрх зүй, өмгөөллийн үйлчилгээ, хичээлээс гадуурх хөгжүүлэх үйлчилгээ зэрэгт дэмжлэг авч шийдвэрлүүлж чадсан байна.

Мөн хорооны Хамтарсан багаас хүүхдийн эрхийг хангахтай холбоотой богино хэмжээний видео рийл зэргийг санаачлан бэлтгэж, 33 дугаар сургуулийн бүх ангийн группэд байршуулж сурталчилсан. Бага, дунд, ахлах ангиар сургуулийн нийгмийн ажилтантай хамтран орж, хүүхдийн эрхийг нь таниулан хүүхдийн эрхийн асуудал зөрчил гарсан тохиолдолд хэнд, хаана, хэрхэн хандах талаар тайлбарлан ойлгуулах ажлыг тогтмол зохион байгуулан Хорооны хамтарсан баг, сургуулийн хүүхэд хамгааллын багийг сурталчлан таниулах ажлыг хийж хэвшүүлээ.

Хүүхдийн эрхийн зөрчил бүрийг илрүүлж чадаж байна уу гэвэл, мэдээж, бид илрүүлэхийн төлөө л ажиллаж байна. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэнээр

Achieving Results Through Collaboration

All these achievements are the result of regular on-the-job consultation and support provided through the ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project. Detecting violations of children's rights, providing rehabilitation, responding appropriately, and preventing potential risks are all essential.

Within the project, ten schools and ten khoroos in Ulaanbaatar participated in quarterly child conference/case conference, receiving methodological support from Save the Children specialists. Building on this experience, we successfully organized joint child conference/case conference between the School Child Protection Teams and the Multi-Disciplinary Team. This approach has allowed us to provide professional social work services for children with complex needs and formalised these practices.

In addition, we have begun regularly organizing child conferences in collaboration with the School Child Protection Team. Over the past two years, we have held around ten conferences, addressing the needs of three children who were particularly challenging

As a result of these discussions, the MDT received support for these children from the Child Protection Fund/budget of the Family Development Department of Bayanzurkh District to cover the costs of services for the three children, including psychological counseling, legal advice and advocacy, and extracurricular development programs..

Raising Awareness and Building Trust

The khoroo's MDThas also took the initiative to create short video reels on children's rights, which have been shared with all class groups at School No. 33. Together with the school social worker, the team regularly visits primary, secondary, and high school classes to raise awareness about children's rights. They explain to students what to do, to whom and where to turn if a child's rights are violated. These activities have

сургуулийн багш нар, эцэг, эх, асран хамгаалагчид, сурагчид, аль аль нь хүүхэд хамгааллын чиглэлээр ойлголт, мэдлэгтэй болсон тул би энэ асуултад “Тийм” гэж хариулна.

Мөн ерөнхий боловсролын 33 дугаар сургуулийн үүдний хүлээлгийн танхимд Хамтарсан багийн мэдээллийн самбарыг шинээр байршуулсан. 14 хоног тутамд мэдээллийг шинэчлэн ажилладаг. Уг самбарт эцэг эхэд зориулсан зөвлөгөө мэдээлэл, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх зөвлөгөө мэдээлэл байршуулдаг болсон зэрэг сайн туршлагууд бий болсон.

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл үр дүнтэй хэрэгжиж дуусаж байна. Үр дүнд нь Хамтарсан багийн маань гишүүд чадавхиж, идэвх сайжирч, үүрэг оролцоо нь маш сайн нэмэгдлээ. Хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийг эрт илрүүлэх, шуурхай тусламж үзүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх зэрэг үйлчилгээ, хамтын ажиллагааны загвар нутагшин үлдэж байгаад баяртай байна.

Хүүхдийг Ивээх Сангийн төслийн багийнхандаа баярлалаа.

become a routine part of the school's program, helping to introduce both the Multi-Disciplinary Team and the school's Child Protection Team to students and staff.

We are often asked whether we are able to identify every case of children's rights violations. *Of course, we work diligently to detect and address them. Thanks to the “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project, teachers, parents, caregivers, and students at the school have all gained knowledge and understanding of child protection. Therefore, my answer to this question is “Yes.”*

A new information board for the Multi-Disciplinary Team has been installed in the lobby of General Education School No. 33. The board is updated every two weeks and provides guidance and advice for parents, along with information on preventing domestic violence and protecting children from abuse. These practices have now been successfully established in the 3rd khoroo.

A Sustainable Model for the Future

The Save the Children project has now been successfully completed. As a result, the members of our Multi-Disciplinary Team have become more capable, proactive, and engaged, taking on greater responsibilities and participating more actively. We are pleased that a sustainable collaborative model has been established to deliver professional child protection services, including the early identification of child abuse and rights violations, timely assistance, protection and rehabilitation services, and preventive measures.

We sincerely thank the Save the Children project team for their invaluable support.



“НҮД НЭЭСЭН” ТӨСӨЛ THE “EYE-OPENING” PROJECT

Говь-Алтай аймгийн Дарив сумын ерөнхий боловсролын сургуулийн нийгэм, иргэний ёс зүйн боловсролын багш Б.Бүтэнжаргал мэргэжлээрээ 6 дахь жилдээ ажиллаж байна. Тэрээр, Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллын сайжруулах нь” төслийн сургууль дахь ажлын хэсгийн гишүүн, сургагч багш юм.

Б.Бүтэнжаргал “Уг төсөл хэрэгжсэнээр багш нарын төдийгүй сургуулийн нийт ажилтнуудын, цаашлаад сурагчид, эцэг эх, асран хамгаалагчдын хүүхэд хамгааллын талаарх мэдлэг сайжирч, хандлага өөрчлөгдсөн. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэхэд ахиц дэвшил гарсан. Багш нарын арга зүй сайжирч, хүүхдүүдийн идэвх, оролцоо нэмэгдсэн. Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг эрт илрүүлэх, зөрчлийн тохиолдолд хариу арга хэмжээ авах арга зүй, үр чадварт суралцсан” хэмээн ярилаа.

How Child Protection Training Transformed a Rural School Community

In a remote community of Dariv soum, Govi-Altai province, a comprehensive approach to child protection has taken root, transforming not just a school but an entire community's understanding of their responsibility to children. B. Butenjargal, a social studies and civic education teacher at the General Education School of Darivi soum, Govi-Altai province, has been at the heart of the transformation.

With six years of teaching experience, Butenjargal serves as both a member of the school's Project Implementation Unit and a trainer under Save the Children's “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project. His journey with the project reflects how rural educators, when equipped with the right knowledge and tools, can catalyze change far beyond their classroom walls.

Дарив сумын сургуулийн эцэг эх, асран хамгаалагчид “Сайн эцэг эх” сургалтад сууснаар хамтын оролцоо нь эрс нэмэгджээ. Сургуулийн Эцэг эхийн зөвлөл шинэчлэгдэн байгуулагдаж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна. Төслөөс хүүхдүүд болон сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн дунд хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх бичил төслийн уралдаан зарласан. Эцэг эхчүүд, сургуулийн дотуур байрны тохижилтыг шийдвэрлэх бичил төсөл бичсэн нь уралдаанд шалгарсан юм. Бичил төсөл хэрэгжсэнээр дотуур байрны хүүхдүүд хичээл давах тохилог орчин бүхий өрөөг тохижуулжээ. Говь-Алтай аймгийн Дарив сумын сургуульд нийт 340 хүүхэд суралцаж байгаагаас дотуур байранд 78 сурагч амьдардаг. 2023 онд төслийн хүрээний сургалт, үйл ажиллагаанд хамрагдсаны дараагаар, сургуулийн захиргаа улирлын амралтын үеэр хүүхдийг хөдөө гэрт нь хариулахдаа гараас гарт буюу заавал эцэг эх, асран хамгаалагчдад нь хүлээлгэж өгөх журам мөрдүүлжээ. Төсөл эхлэх үед ахлах ангийн ах нар нь дүүгээ сундлан, мотоциклоор зорчдог байжээ. Үүнийг таслан зогсоохын тулд зорчих эрхийн үнэмлэхгүй, насанд хүрээгүй иргэнийг тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглох тухай Дарив сумын Засаг даргын А/50 тоот захирамж гарсан нь насанд хүрээгүй хүүхэд мотоцикл унаж хөдөлгөөнд оролцох байдлыг бууруулж чадсан байна. Энэ захирамжийн талаар анги удирдсан багш нар сурагчдад мэдээлэл өгч, хүүхдийн аюулгүй байдлыг хангахаас гадна, болзошгүй эрсдэлээс сэргийлж чаджээ. Энэ нь сум орон нутаг, ерөнхий боловсролын сургууль гээд холбогдох талууд хүүхэд хамгааллын мэдлэгтэй болсны үр дүн билээ. Б.Бүтэнжаргал эцэг эхчүүд “Хүүхэд байгаа газар хамгаалал байх ёстой. Хүн бүр хүүхдээ хамгаалах үүрэгтэй” гэдгийг ойлгож байгаад талархаж байна гэв.

Түүнчлэн “Би найзаа дэмжинэ” үе тэнгийнхэнд чиглэсэн сургалт, хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд баг болон нэгдэж, “Хайр түгээе” сургалт нөлөөллийн бичил

Building a Foundation of Understanding

According to Butenjargal, the project has enhanced the knowledge and changed the attitudes of not only teachers but also all school staff, students, parents, and caregivers regarding child protection. The transformation began with comprehensive training that provided skills and approaches for preventing violence against children, identifying risks early, and responding appropriately when violations occur.

“Every training under the ‘project was practical, highly relevant, and valuable for real-life situations,” Butenjargal explains. The impact extended beyond his own professional development. As part of the teacher exchange program, he visited other schools to share what he had learned from the project, exchange experiences, and collaborate with his own school’s teachers and parents from different communities.

The results became evident across the school community. Teachers’ methods have improved, and students’ participation and engagement have increased. Significant progress has been made in preventing risks and creating a safe environment for children

Engaging Parents as Partners

The parents and caregivers of Dariv soum school have significantly increased their participation after attending the “Safe Families” training. The school’s Parents’ Council was reorganized and has since begun operating on a regular basis, marking a shift from passive observers to active partners in child protection. As part of the project micro-project initiatives, focused on child protection was announced among students and the Parents’ Council. One proposal, submitted by the parents, aimed to improve the dormitory facilities. This initiative held particular significance for the school, which serves 340 students, 78 of whom live in the dormitory.

Through this parent-led micro-project, a comfortable study room was created for dormitory students, allowing them to review lessons. The

төсөл хэрэгжүүлжээ. Сургагч хүүхдүүд үе тэнгийнхэндээ төдийгүй эцэг эхчүүдэд сурсан мэдсэнээ сонирхолтой арга хэлбэрээр дамжуулан түгээсэн билээ. Түүгээр зогсохгүй цэцэрлэгийн багш ажилчид, сумын ЗДТГ-ын албан хаагчдад нөлөөллийн ажил зохион байгуулжээ.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн өөр нэг хүрсэн үр дүн нь, анги бүр “Ангийн дүрэм”-тэй болжээ. Сургагчдын оролцоонд тулгуурлан боловсруулсан ангийн дүрмийг тодорхой давтамжтайгаар хэлэлцэн, засан сайжруулж, даган мөрдөж байна. Мөн сургуульд хүүхэд хамгааллын “Мэдээллийн хэлхээ” бий болж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, зөрчил гарсан бол хаана, хэнд, ямар арга замаар хандах тухай тодорхой мэдээллийг анги бүрд байршуулжээ. Сумын ЗДТГ-аас эрсдэлийн үнэлгээнд үндэслэн, сургуулийн орчинд хяналтын камер суурилуулсан байна.

Б.Бүтэнжаргал багш “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн сургалт бүр амьдралд ойр, нэн хэрэгцээтэй, ач холбогдолтой байсныг онцолсон. Тэрээр, багш солилцоо хөтөлбөрийн хүрээнд бусад сургуулиудад очиж төслөөс сурч мэдсэнээ түгээн дэлгэрүүлж, туршлага солилцоноос гадна сургуулийнхаа багш нар, эцэг эхчүүдтэй хамтран ажилласан юм.

-Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл өнгөрсөн гурван жилийн хугацаанд оюуны болон материаллаг олон төрлийн хөрөнгө оруулсан, хөдөөгийн багш бидний “нүдийг нээж” өгсөн төсөл байлаа. Төслийн багийн хамт олонд баярлаж талархсанаа илэрхийлье гэж Б.Бүтэнжаргал багш хэллээ.

project demonstrated that parents, when given the opportunity and support, could identify and address critical needs affecting their children's wellbeing and education.

Creating Systems for Student Safety

The project's impact extended beyond training to create concrete safety measures tailored to the community's specific needs. In 2023, following participation in the project's training and activities, the school administration introduced a new procedure requiring that during seasonal breaks, dormitory students be handed over directly to their parents or caregivers in person. This seemingly simple change ensured accountability and prevented children from traveling unsafely during school breaks.

Another critical safety issue emerged through the project's risk assessment process. Before the project began, senior students often gave rides to younger ones on motorcycles. Working collaboratively, the school and local government took action. The Governor of Dariv soum issued Order No. A/50, prohibiting underage citizens without driving licenses from operating vehicles.

This measure successfully reduced the number of minors riding motorcycles and participating in traffic. Class teachers also informed students about the regulation, ensuring their safety and helping prevent potential risks. The initiative demonstrated how child protection training could lead to policy changes that extend beyond the school gates.

Based on a risk assessment, the soum governor's office installed surveillance cameras in the school environment to further enhance safety, showing government commitment to creating secure spaces for children.

Empowering Student Voices

Children who participated in the “I Support My Friends” peer-focused training formed a group and implemented the “Spread Love” micro-project. The peer educators shared what they had learned with their classmates and parents in engaging and interactive ways, proving that children themselves could be powerful advocates for their own protection.

Another achievement of the project is that each class now has its own set of classroom rules. Developed with active student participation, these rules are regularly reviewed, updated, and consistently followed. This participatory approach ensured that children had ownership over their learning environment and understood the reasoning behind safety measures.

Building Sustainable Systems

The school established a child protection workflow chart, providing clear guidance in each classroom on how, where, and to whom to report in order to prevent risks, detect issues early, or respond to incidents. This visible, accessible

system ensured that every student, teacher, and staff member knew exactly what steps to take if they witnessed or experienced a violation of children's rights.

These systems and procedures, developed through the project, created a lasting infrastructure for child protection that would continue to function beyond the project's timeline.

A Rural Teacher's Gratitude

Reflecting on the project's impact Butenjargal, emphasizes how it has changed fundamental understanding in his community. *“Parents have come to understand that where there are children, there must be protection, and that everyone has a duty to protect their child,”* he said.

For Butenjargal and other rural educators, the project represented more than professional development. *“The ‘project by Save the Children has, over the past three years, provided both intellectual and material support, and has truly opened the eyes of rural teachers like us. I would like to express my gratitude and appreciation to the project team,”* he said .

БАГИЙН АМЖИЛТ, МЭДЛЭГ, ТУРШЛАГА

TEAM ACHIEVEMENTS, KNOWLEDGE, AND EXPERIENCE

Нийслэлийн 130 дугаар сургуулийн төслийн ажлын хэсгийн 4 багштай төлөөлөл болгон ярилцлаа.

Нийслэлийн 130 дугаар сургуулийн сэтгэл зүйч Б.Номиндарь хоёр дахь жилдээ ажиллаж байна. Тэрээр, 2024 онд сэтгэл зүйч мэргэжлээр төгсөж, ажил, амьдралын гараагаа энэ сургуулиас эхэлсэн юм. “Намайг анх ажилд ороход Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжээд жил орчим болж байсан. Ажлын үүрэгтэй шууд хамааралтай төсөл учир ихэд олзуурхсан. Өмнөх нэг жилийн хугацаанд ямар сургалтууд болсон, тэр бүрийг нөхөн суралцаж, төслийн зорилготой хөл нийлүүлэн, хичээн ажиллаж байна. Би бусад сургуулийн мэргэжил нэгтнүүдтэйгээ байнга холбоотой байдаг юм. Хүүхдийг Ивээх Сангийн төслийн талаар сонирхуулах үед тэд маань бахдан шагширч, бид ч бас ийм шинэ арга зүйгээс суралцах сан гэж ярьдаг. Тийм ээ, энэ бол их том, тэр хэрээрээ ач холбогдолтой төсөл юм. Би ийм төслийн “эд эс” болсноороо бахархдаг. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл бол зөвхөн хүүхэд, эцэг эхэд биш, багш нарт ч бас үр өгөөжтэй байсан гэдгийг онцлон тэмдэглэмээр байна. “Хүнлэг байя” аяны хүрээнд хэрэгтэй постер, видео, аудио гээд олон контент бүтээсэн нь ажил дээр шууд ашиглаж болохуйц бөгөөд хүн байх, хүнлэг байх тухай агуулгыг багтаасан. Мөн контентууд нь сурагчид, эцэг эх, асран хамгаалагчид, багш нарт өөрийгөө хэрхэн халамжлах тухай мэдлэг, ойлголт өгч байгаа нь маш шинэлэг болсон. Мөн тус аяны

How a Collaborative Approach Transformed Child Protection at School No. 130

School No. 130 in Ulaanbaatar exemplifies how effective child protection requires the coordinated efforts of an entire school community. Through the “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project, the school’s Project Implementation Unit (PIU) has developed comprehensive systems and built strong capacity across all staff levels. We spoke with four teachers from the PIU, a psychologist, a teacher, and two social workers whose diverse perspectives reveal how collaborative teamwork creates lasting change for children.

Building Professional Capacity Through Training Learning New Approaches

School psychologist Nomindari, joined School No. 130 in 2024, shortly after graduating with a degree in psychology. When she first started working, the Save the Children project, had already been active for about a year. “Since the project closely aligns with my professional responsibilities, I was excited to join,” she recalls. “I took time to review the previous year’s trainings and activities, making sure my work aligned with the project’s goals.”

Teacher Surenkhoo, another PIU member participated in all the training conducted under the project and became a project trainer. “Together with my colleagues, I organized and delivered the training at our school,” she explains. “Personally, I was trained as a facilitator for the “I Support My Friends” school-based peer support training

хүрээнд багшийн ажлын хавтас, эцэг эхийн дэвтэр, сурагчдад “Хүнлэг байя” гэсэн стикер наалтууд гэх мэт гарын авлага материал нийлүүлсэн юм. Багшид өгөх зөвлөмжид, багш хүн өөрийгөө хэрхэн халамжлах талаар өгүүлсэн нь их таалагдсан” хэмээн сэтгэл зүйч Б.Номиндарь ярилаа.

Нийслэлийн 130 дугаар сургуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн, багш Х.Сүрэнхүү “Би төслийн хүрээнд хийгдсэн бүхий л сургалтад хамрагдаж, чиглүүлэгч багш болон сургууль дээрээ тус сургалтаа бусад багш нартайгаа хамтран заасан. Миний хувьд “Би найзаа дэмжинэ” үе тэнгийнхэнд чиглэсэн хөтөлбөрийн чиглүүлэгч багшаар бэлтгэгдэж, хүүхдийн бүлэгтэй ажилласан нь их таалагдсан. Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд тус сургуулийн “Би найзаа дэмжинэ” хөтөлбөрт хамрагдсан 15 сургагч хүүхдүүд баг болон нэгдэж, хүүхдийн эрхийн талаар сургалт, сурталчилгаа явуулах бичил төсөл бичихэд нь дэмжсэн, чиглүүлж ажилласан” гэлээ. Бичил төслийн хүрээнд сурагчид, эцэг эхэд зориулан нөлөөллийн ажил хийж, өдөрлөг зохион байгуулсан байна. “Өөрийгөө хайрлая”, “Сэтгэлээ тэвэрье” уриан дор энэ өдөрлөг амжилттай болсон нь,

- **Нэгдүгээрт,** хүүхдүүд “Би найзаа дэмжинэ” хөтөлбөрөөс олж авсан мэдлэгээрээ сургуулийн орчинд сурагчдын өмнө тулгамдсан асуудлыг өөрсдөө илрүүлж, тус асуудлыг шийдэхийн тулд анх удаа төсөл бичиж, өөрсдөө хэрэгжүүлж үзсэн нь чухал байлаа.
- **Хоёрдугаарт,** үе тэнгийн найзууд нь бие даан үйл ажиллагаа зохион байгуулан ярьж, илтгэх нь хүүхдэд насанд хүрэгчдээс илүү хүрдэг сайн талтай гэж бичил төслийн чиглүүлэгч багш онцлон ярьж байна.

Х.Сүрэнхүү багшийн нэмж хэлснээр, Хүүхдийг

program, and I truly enjoyed working with the students.”

For Surenkhuu, who was early in her teaching career, the project offered an excellent opportunity for professional development. *“As a young teacher, it was an excellent opportunity for professional growth. I learned new methods for working not only with students but also with parents. I am truly happy that the project helped me improve as a teacher. I also learned to communicate my ideas clearly, report on activities, and share knowledge with my colleagues.”*I was very enthusiastic”.

Nomindari maintained regular contact with psychologists from other schools. When I describe the Save the Children project to them, they are always impressed and express a wish to learn from these new methods as well. It is indeed a major and highly meaningful initiative, and I am proud to be part of it.

The project has benefited not only students and parents but also teachers. Under the “Let’s Be Humane” campaign, a wide range of resources including posters, videos, and audio content—were developed. These materials can be directly applied in daily work and promote values such as kindness and empathy. They also provide students, parents, caregivers, and teachers with practical guidance on self-care, which is a very innovative approach.

As part of the campaign, additional resources were distributed, including folders for teachers to organize their documents, notebooks for parents, and “Let’s Be Kind” stickers for students. I especially appreciated the recommendations for teachers, which included guidance on how to take care of their own well-being.”

The project trained about 45 teachers as project trainers through 10 different training programs, and 125 students participated in the “I Support My Friends” peer support training program. Teachers, staff, students, parents, and caregivers all appreciated the variety of training sessions and the practical materials and resources provided.

Ивээх Сангийн сургалтад хамрагдсан хүүхдүүд өөрийн үзэл бодлыг чөлөөтэй ярьж, илтгэж сурснаас гадна өөртөө итгэлтэй болж, бусад хүүхдүүдтэйгээ хамтран багаар ажиллахад суралцаж, анх удаа төслийн санаа гаргах, төсөл бичих, хэрэгжүүлэх, тайлан бичих гэх мэт ажлыг хийснээр аливаа зүйлд оролцох идэвх санаачилга нь нэмэгдсэн байна.

Тэрээр “Төсөл хэрэгжихэд маш их олзуурхан хүлээж авсан. Шинэ залуу багш учир мэргэжлээрээ өсөж дэвших таатай боломж байсан юм. Сурагч төдийгүй эцэг эхтэй харилцах шинэ арга зүйд суралцаж, багшийн хувьд чадваржсандаа үнэхээр их баярлаж байгаа. Түүнчлэн бусад багш нартай харилцахдаа санаагаа зөв илэрхийлж ойлгуулах, илтгэх, мэдлэгээ бусдад түгээх үр чадварт суралцсан” гэж ярилаа. “Х.Сүрэнхүү багшийн ангийн хүүхдүүд бусад ангитай харьцуулахад арай л өөр шүү. Соёлтой, ухаалаг, үлгэр жишээч, суралцах чадвартай, биеэ даасан, өөрийгөө илэрхийлэх чадвартай болсон шүү” гэж нийгмийн ажилтан Д.Төгсмаа ярианд оролцов.

Нийслэлийн 130 дугаар сургуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн, нийгмийн ажилтан Д.Төгсмаагийн хувьд боловсролын салбарт 18, 130 дугаар сургуульд гурав дахь жилдээ ажиллаж байгаа билээ. Шинэ тулгар байгуулагдсан сургууль, шинэ хамт олон, шинэ сурагчид, бүгд л өөр өөр үзэл бодол, хандлагатай байх тэр үед Д.Төгсмаа Хүүхдийг Ивээх Сангийн энэ төсөл зайлшгүй шаардлагатайг нотолж чадсан юм. Өөрөөр хэлбэл, “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл энэ сургуульд хэрэгжих боломжийг авчирсан хүн юм. Тэрээр “Төслийн ажилтнууд, ажлын байран дээр хүрэлцэн ирж сургуулийн орчинд хүүхэд хамгааллыг сайжруулах, хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар хэрхэн ажиллах, кейс менежментийн үйлчилгээг хэрхэн үзүүлэх, хамтарсан багтай хэрхэн хамтран ажиллах гэх мэт маш олон сэдвийн хүрээнд зөвлөн тусалж байсан. Үүний үр

Developing Comprehensive Child Protection Systems

Creating Clear Procedures and Workflows

Social worker Ganzorig explains how the project have strengthened the entire team's capacity. The members of the Child Protection Team have strengthened their knowledge and capacity. Each member now clearly understands their roles and responsibilities. Previously, there was a misconception that child protection was solely the responsibility of the social worker, but this project helped everyone realize that child protection involves all teachers and staff, including security guards and cleaning personnel. Our school's service staff have also gained knowledge and information on this topic and now follow the provided guidelines in their daily work.

Social worker Tugsmaa who has 18 years of experience in the education sector and has been working at School No.130 for three years, played a crucial role in bringing the project to the school.

At a time when the school was newly established, with a new team and new students, Tugsmaa demonstrated the essential need for the Save the Children project, and made it possible for the project to be implemented at the school.

During the project, Save the Children staff regularly visited the school to provide on-the-job consultation on a wide range of topics, including improving child protection within the school environment, responding to cases of child rights violations, delivering case management services, and collaborating effectively with the Multi-Disciplinary Team (MDT). As a result, the school now has a comprehensive, school-level workflow chart for identifying violations of children's rights, responding to them, providing rehabilitation, and preventing future incidents.

The school has also displayed the Child Protection Workflow Chart, outlining clearly to whom, where, and how to report cases of child rights violations, around the school. The phone numbers of the Child Protection Team members, as well as

дүнд сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажлын зураглал схемтэй болсон. Төслийн хугацаанд “Багшийн ажлын дэвтэр”, “Сайн эцэг эх” “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар” гэхчлэн шаардлагатай гарын авлага, материалаар хангасан нь үр дүнтэй байлаа. Төслийн эхэн үеийнхээс эцэг эх, сурагчдын хандлага өөрчлөгдсөн. Төслийн ач холбогдлыг ойлгож, урам зориг, идэвх санаачилгатай болсон. Олон талт харилцаа эерэг болсон нь төслийн үр шим юм” хэмээн ярьсан юм.

Харин төслийн багийн гишүүн, 130 дугаар сургуулийн нийгмийн ажилтан Э.Ганзориг “Төслийн хүрээнд сургуулийн Хүүхэд хамгааллын багийн гишүүд чадавхижсан. Тус багийн гишүүн бүр үүрэг хариуцлагаа ухамсарласан. Өмнө нь хүүхэд хамгаалал гэхээр л бүхнийг нийгмийн ажилтны нуруун дээр тохох гэдэг байсан хандлага учир

the approved focal points listed in the workflow chart, are available to everyone.

Ensuring Confidentiality and Professional Standards

The administration of School No. 130 signed confidentiality agreements with all teachers and staff, requiring them to protect the privacy of children during every stage of identifying, reporting, responding to, recovering from, and preventing child rights violations. Through this, all staff members are committed to maintaining confidentiality and working together at a professional level to eliminate child rights violations.

The school has also established a “Trust phone” at the entrance, allowing children, parents, and caregivers to report cases of child rights violations. Children can use this phone to call their parents or any member of the school’s Child Protection Team for up to two minutes free of charge to report concerns. This initiative is one of the school’s unique achievements.



дутагдалтай байсныг хаа хаанаа ойлгосон. Хүүхэд хамгаалалд сургуулийн бүх багш, ажилтнууд, жижүүр, үйлчлэгч хүртэл оролцоотой юм гэдгийг төслөөс маш сайн ойлгуулсан. Манай сургуулийн үйлчилгээний ажилтнууд ч энэ талаар мэдлэг, мэдээлэлтэй болж, заавар зөвлөмжийг дагаж ажилладаг болсон” гэлээ.

130 дугаар сургуулийн захиргаа бүх багш, ажилчидтайгаа хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой асуудлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх бүхий л үйл явцад хүүхдийн нууцыг хадгалах гэрээ байгуулжээ. Ингэснээр тухайн багш, ажилтан болсон үйл явдлын талаар гадагш задруулахгүй байж, хүүхдийн эрхийн зөрчлийг арилгахын тулд зөвхөн мэргэжлийн төвшинд хамтарч ажиллах үүрэг хүлээж байна. Сургуулийн үүдний хэсэгт хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчаас хүүхдийн эрхийн зөрчлийн мэдээллийг хүлээн авах “Итгэлтэй утас” бий болгосон нь энэ сургуулийн хувьд онцлог байлаа. Тухайн хүүхэд тус утсаар эцэг эх рүүгээ болон сургуулийн Хүүхэд хамгааллын багийн хэн рүү нь ч нэг удаадаа хоёр минут хүртэл үнэ төлбөргүй ярьж, тухайн зөрчлийн талаар мэдээлэх боломжтой ажээ.

Тус сургуульд үе тэнгийн дээрэлхэлт, үл хайхрах хэлбэрийн зөрчил хэд хэд гарсан ч тухай бүрд нь сургуулийн хүүхэд хамгааллын баг шуурхай ажиллаж шийдвэрлэжээ. 2023-2025 онд нийт гурван кейс гарсныг хорооны хүүхэд хамгааллын Хамтарсан багтайгаа хамтран ажиллаж, хоёрыг нь хааж, нэг кейсийг шийдвэрлэх шатандаа явж байгаа аж.

130 дугаар сургуулийн хүүхэд хамгааллын баг сургуулийн гадна болон дотор орчинд эрсдэлийн үнэлгээг хийн ажиллаж байна. Сургуулийн хүүхэд хамгааллын багийн гишүүд тодорхой давтамжтайгаар сургуулийн гадна, дотно орчинд үнэлгээ хийж, хүнд нөхцөл тодорхойлбол сургуулийн Хүүхэд хамгааллын баг болон удирдлагад

Implementing Risk Assessment and Safety Measures

The Child Protection Team at School No. 130 conducts risk assessments both inside and outside the school. Members of the team regularly carry out these assessments, and when they identify high-risk situations, they inform the school's Child Protection Team and management. If the risks are manageable, they work together with the class teacher and parents to address and resolve the issue promptly.

As part of the project, the school has implemented measures to ensure a safer environment for students. Security guards and duty teachers now register all visitors who enter or leave the school and issue “Visitor” ID cards to control access and improve safety. The school's service staff have also gained knowledge and information on child protection and follow the provided guidelines in their daily work.

Providing Practical Resources and Support Materials That Make a Difference

During the project, providing essential manuals and materials. Tugsmaa noted that manuals such as “Teacher’s Workbook,” “Safe Families,” and the “Exemplary Model of Child Protection Mechanism in General Education Schools” proved to be highly effective. Compared to the early stages of the project, the attitudes of parents and students had changed. They began to understand the significance of the project and became more motivated and proactive. Tugsmaa emphasized that the development of positive, multi-faceted relationships was one of the key benefits of the project.

Empowering Student Leadership and Participation

The “I Support My Friends” Micro-Project

Under the project, 15 peer educators from our school who participated in the “I Support My Friends” program came together as a team to

мэдээлж, хөнгөвтөр бол анги удирдсан багш, эцэг эхтэй хамтран тухайн эрсдэлийг цаг тухайд нь арилгаж хэвшжээ. Сургуулийн орчин хүүхдийн хувьд аюулгүй байх ёстой тул сургуулийн жижүүр болон жижүүр багш нар сургууль руу орж, гарч буй хүмүүсийг бүртгэх, зочин үнэмлэхээр нэвтрүүлэх, гаргах гэх мэтээр илүү аюулгүй орчин бүрдүүлж ажилладаг болсон гэж Э.Ганзориг нийгмийн ажилтан ярьж байлаа.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд 10 орчим сургалтад 45 сургагч багш бэлтгэгджээ. “Би найзаа дэмжинэ” үе тэнгийнхэнд чиглэсэн хөтөлбөрт 125 хүүхэд хамрагдсан байна. Төслөөс олон төрлийн сургалт зохион байгуулж, гарын авлага, материалаар хангасанд тус сургуулийн багш, ажилтнууд болон, хүүхдүүд, эцэг эх асран хамгаалагчид ам сайтай байсан. Мөн тус сургуульд хүүхдийн эрхийн зөрчил гарсан тохиолдолд хэнд, хаана, хэрхэн хандах талаар тодорхой өгүүлсэн мэдээллийн хэлхээг нүдэнд өртөхүйц газруудад байршуулсан байна.

plan and implement a children-initiated micro-project focused on promoting child rights. Teacher Surenkhuu supported and guided them throughout the process.

Within the framework of the micro-project, students organized advocacy activities and an event for their peers and parents. Under the themes “Love Yourself” and “Embrace Your Feelings,” the event was successfully carried out, achieving several important outcomes:

- First, using the knowledge gained from the “I Support My Friends” program, the students themselves identified issues faced by their peers in the school environment. For the first time, they wrote a project proposal to address these issues and implemented it on their own, which was a significant achievement.
- Second, as project trainers highlighted when peers lead activities, speak, and present, the message resonates more strongly with children than when delivered by adults. This peer to peer approach proved to be highly effective.

Building Confidence and Skills

Surenkhuu observes that the children who participated through the Save the Children training gained more than just knowledge about child protection. In addition to learning to freely express and present their own opinions, the children became more confident, learned to work collaboratively with other children, and, for the first time, engaged in activities such as generating project ideas, writing and implementing projects, and preparing reports, which increased their initiative and motivation to participate in various activities.

Social worker Tugsmay noted the visible impact on students *“The students in teacher Surenkhuu’s class stand out compared to other classes. They are well-mannered, intelligent, exemplary, independent, and confident in expressing themselves.”*

Responding to Cases with Professionalism

Several cases of peer bullying and neglect have been reported at the School No.130. Each time, the school's Child Protection Team responded promptly and effectively. Between 2023 and 2025, three cases were identified, two of which were resolved in cooperation with the khoroo's Multi-Disciplinary Team, while one case remains under review.

The comprehensive systems, clear procedures, and well-trained team at School No. 130 have created an environment where children's rights are protected, violations are addressed promptly, and every member of the school community understands their role in keeping children safe.

A Model of Collaborative Excellence

The success of the “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” proj-

ect at School No. 130 demonstrates that effective child protection requires more than policies and procedures—it requires a committed team working together across different roles and perspectives. From the psychologist providing emotional support, to the teachers empowering student leadership, to the social workers coordinating comprehensive responses, each member of the PIU contributes essential expertise.

Together, they have created a model that other schools can learn from: one where every staff member understands their responsibility, where students are active participants in their own protection, where parents are engaged partners, and where clear systems ensure that no child's concern goes unheard. This is the foundation upon which lasting child protection is built.

ЗАЛУУ БАГШИЙН ГАРАА САЙН

A YOUNG TEACHER OFF TO A STRONG START

Нийслэлийн 75 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш Батсүхийн Цэвэлмаа мэргэжлээрээ дөрөв дэх жилдээ ажиллаж байна. Тэрээр, Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн сургуулийнхаа төсөл хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүн, сургагч багш юм.

-Төслөөс зохион байгуулсан олон төрлийн сургалт, кейс хэлэлцүүлгийн үр дүнд маш ихийг сурч мэдлээ. Би ажилд орсон жилээ л ийм ач холбогдолтой төсөлд хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгдсэн азтай багш гэж боддог. Мэргэжлийн арга зүйгээ сайжруулж, эцэг эх, сурагчидтай харилцах харилцаагаа шинэ шатанд гаргалаа гэж Б.Цэвэлмаа багш сэтгэл дүүрэн өгүүлж байна.

75 дугаар сургуулийн төслийн ажлын хэсэгт нийт 9 сургагч багш бий. Тэд мэдлэгээ бусад багш нар, сурагчид, эцэг эхэд дамжуулан түгээсэн юм. Сургуулийн бүх анги “Ангийн дүрэм”-ээ сурагчдын оролцоонд тулгуурлан олонхоор хэлэлцэн баталсан аж. Ингэснээр сурагчид үүрэг хариуцлагаа ухамсарлаж, ангийн, цаашлаад сургуулийн хэмжээнд сурлагын төвшин ахих, дэг журам тогтох, эерэг уур амьсгал бүрдэхэд нөлөөлсөн байна. Б.Цэвэлмаа багшийн хариуцан ажилладаг 8 дугаар ангийн сурагчид ангийн дүрмээ ноднин баталжээ. Энэ жил дахин хэлэлцэж, ямар заалт нь биелсэн, ямар нь биелээгүйг шүүн тунгааж, дүрмээ засан сайжруулжээ. Жишээ дурдвал, ангийн дүрэмд сургууль дээр гар утас хэрэглэхийг хориглосон байна. Хичээлийн эхэнд ангийн даргад утсаа хураалгаж, тарахдаа авч явдаг. Гэтэл нэгэн бэрхшээл тулгарчээ. Хүүхдүүд

Tsevelmaa, a Mongolian language and literature teacher at School No.75 in Ulaanbaatar, is now in her fourth year of teaching. She also serves as a member of her school's project implementation unit and works as a trainer for the Save the Children project, 'Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia'.

Born and raised in Khovd province, Tsevelmaa completed both her secondary and higher education there, earning her professional qualifications. However, as she explains, “by destiny,” she moved to Ulaanbaatar to continue her career. She respects and admires her secondary school Mongolian language and literature teacher, Bulgan, and credits her teacher with having a significant influence on her decision to pursue this profession.

A Transformative Beginning

“Through the various trainings and child discussions organized by the project, I have learned an immense amount. I consider myself fortunate to have participated in such a meaningful initiative during my first year of teaching and to have been trained as a trainer. This experience has enhanced my professional skills and also helped me elevate my relationships with both parents and students to a new level,” says teacher Tsevelmaa with heartfelt enthusiasm.

The project implementation unit at School No. 75 includes nine trainers. They shared their knowledge with other teachers, students, and parents, creating a ripple effect throughout the school community. Every class developed its own Classroom Rules through student participation and a majority vote. This process encouraged students to take responsibility, improved

их завсарлагаар ундалж, утаснаасаа мөнгө шилжүүлэх хэрэгцээ шаардлага байсан тул багшийн зүгээс эцэг эхчүүдэд хандаж, хүүхдэд зориулсан банкны карттай болгосноор энэ бэрхшээлийг шийдэж чаджээ. Хүүхдүүд бэлэн мөнгөөр, эсвэл цахим картаар үйлчлүүлэх болов. Түүнээс гадна утсаа алдах эрсдэлгүй болжээ. Биеийн тамирын зааланд, ариун цэврийн өрөөнд, сургуулийн хонгилд, энд тэнд утсаа мартаад явчихдаг тохиолдол цөөнгүй, тэр хэрээр хүүхэд хохирдог асуудал ангийн дүрмийн ганцхан заалтаар ийнхүү бүрэн шийдэгдсэн байна.

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах” нь төсөл хэрэгжсэнээр ийнхүү анги бүр хүүхдийн оролцоонд тулгуурласан ангийн дүрэмтэй болсноос гадна сургуулийн хүүхэд хамгааллын “Мэдээллийн хэлхээ” бий болсон нь бас нэгэн үр дүн юм. Тодруулбал, хүүхдүүд эрхтэй нь холбоотой зөрчил гарвал хаана, хэнд, хэрхэн хандах талаар мэдээллийн хэлхээгээр дамжуулан мэдэж авчээ. “Мэдээллийн хэлхээ”-г схем зургаар зураглаж, анги бүрд байршуулсан байна.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн “Сайн эцэг эх” сургалтын үр дүнд тус сургуулийн Эцэг эхийн зөвлөл идэвхжиж, эцэг эхчүүдийн хандлага өөрчлөгдөж, оролцоо нэмэгджээ. Тухайлбал, эцэг эхчүүдийн санаачилсан бага ангийн сурагчдын ариун цэврийн өрөөг тохижуулах бичил төсөл нь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн үрэлдээнд тэнцэж, санхүүжилт авсан байна. Түүгээр зогсохгүй, 75 дугаар сургуулийн Эцэг эхийн зөвлөл бас нэгэн төсөл бичсэн нь мөн л тэнцсэн юм. Тодруулбал, эцэг эхчүүдийн хоёр дахь төсөл нь анги бүрд “Талархлын хайрцаг” бий болгох байсан билээ. Суралцагчид хэн нэгэнд хаягласан захидлыг уг хайрцагт хийх бөгөөд тухайн ангийн багш 7 хоногт нэг удаа хайрцгийг задалж, дотор нь байх захидлуудыг хаягласан эзэнд нь хүргэж өгдөг байна. Сурагчид хэнд ч бичиж болно. Найз нөхдөдөө, эцэг, эхдээ, сургуулийн үйлчлэгч,

academic performance, strengthened discipline, and fostered a positive learning environment at both the classroom and school levels.

Empowering Students Through Classroom Rules

The 8th-grade students, guided by teacher B. Tsevelmaa, initially established their classroom rules last year through student participation and a majority vote. This year, they revisited the rules, examining which provisions had been followed and which had not, and then revised and improved them. For example, the rules prohibit the use of mobile phones at school. At the start of lessons, students hand their phones to the class president and retrieve them at the end of the day.

A challenge arose during the lunch break, when students needed to buy snacks and transfer money from their phones. To address this, the teacher coordinated with parents to provide each child with a bank card, which solved the problem. Students could then make transactions using either cash or electronic cards, without needing to use their phones during the day. Previously, students often left their phones in the gym, bathrooms, or school corridors, resulting in losses. This single provision in the classroom rules now effectively resolved that problem.

As a result of the project, the school also created workflow chart for child protection. This chart informs students where, to whom, and how to report any violations of their rights. The workflow chart has been displayed in every classroom.

Active Parent Engagement

As a result of the ‘Safe Families’ training under the project, the school’s Parents’ Council became more active, and parents’ attitudes shifted, leading to greater involvement. For example, a micro-project initiated by parents to renovate the primary students’ restrooms was selected and funded through a competition organized by the project.



цэвэрлэгч, багшдаа, хэнд ч талархсан сэтгэлээ илэрхийлж болдог. Мөн уучлалт гуйсан ч болно.

Хүүхэд хамгаалал энгийн зүйлээс эхэлдгийн нэгэн том жишээ бол энэ ангийн эцэг эхчүүд багш Б.Цэвэлмаагийн зөвлөснөөр 14 хоногт нэг удаа хүүхдийнхээ цүнхийг шалгаж, дэвтрийн үйл ажиллагаатай танилцдаг байна. Энэ нь хүүхдийн хэрэглээнд анхаарал тавих эерэг зөв арга төдийгүй сурлагын байдлыг мэдэх боломж юм. Эцэг эхчүүд багштай мэдээлэл солилцож, хүүхдэд нь ямар зөрчил дутагдал байгаа, түүнийг хэрхэн засан сайжруулах боломжтой талаар ярилцаж, хүүхэдтэйгээ эерэг аргаар хэрхэн харилцах тухай зөвлөгөө авдаг байна.

“Би эцэг эхчүүдийг сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулахыг хичээдэг. Яагаад гэвэл, тухайн хүүхдийн сурлагын чанар, ахиц, хүмүүжил, төлөвшилд эцэг эхийн оролцоо их шүү дээ. Манай ангийн эцэг эхчүүд улиралд нэг удаа ямар нэг ажил, арга хэмжээ зохион байгуулдаг. Хүүхдийн хөгжил, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, эсвэл

In addition, the Parents' Council at School No.75 submitted another project proposal, which was also approved. This second project involved creating a “Gratitude Box” in each classroom. Students could place letters addressed to anyone in the box, and the class teacher would open it once a week and deliver the letters to the intended recipients. Students could write to anyone—friends, parents, school staff, cleaners, teacher—and express their appreciation or to apologize if needed.

A notable example of how child protection begins with simple actions is that the parents of this class, following teacher Tsevelmaa's guidance, check their children's school bags and review their notebooks and assignments once every two weeks. This practice not only helps parents monitor their children's daily habits in a positive way, but also provides insight into their academic progress. Parents exchange information with the teacher, discuss any gaps or issues their child may have, and receive guidance on how to address them. They also learn constructive ways to communicate with their child.

цахим халдлагад өртөхөөс сэргийлсэн ч байдаг уу, арга хэмжээ бүр үр дүнтэй болдог. Энэ улирлын тухайд бид эцэг эхийнхээ дэмжлэгтэйгээр номын дэлгүүрт ангиараа зочлохоор бэлтгэж байна. Унших дуртай номууд маань ямар замаар бидний гар дээр ирдэг юм бэ гэдгийг хүүхдүүд маань танин мэдэх юм” гэж багш Б.Цэвэлмаа ярилаа. “Таны ойрын ирээдүйн зорилго юу вэ?” гэсэн асуултад тэрээр,

-Би багшийн мэргэжлийг дурлаж сонирхсон. Ойрын зорилго гэвэл, дааж авсан ангиа сайн сургаж, хүүхдүүдээ амжилттай төгсгөж, хийж буй ажлынхаа үр дүнг харах сан гэж хүсэж байна. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс олж авсан мэдлэгтээ тулгуурлан, энэ мэдлэг, арга зүйгээ улам хөгжүүлж, шилдэг багш болно” гэж итгэлтэй өгүүллээ. Б.Цэвэлмаа багш Ховд аймагт төрж, өссөн, нутагтаа дунд болон их сургуульд суралцан төгсөж, мэргэжил эзэмшсэн ч өөрийнх нь хэлснээр “хувь тавилангийн эрхээр” Улаанбаатарт шилжин ирж ажиллаж байгаа юм. Б.Цэвэлмаа дунд сургуулийнхаа монгол хэл, уран зохиолын Булган багшийг хүндэлж, авгайлдаг бөгөөд энэ мэргэжлийг эзэмшихэд багшийнх нь нөлөө их байсан гэнэ билээ.

“Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс олж авсан мэдлэг, шинэ арга зүй багшид, цаашлаад сургуульд үнэлж барамгүй өв болон үлдэж байна. Уг төслийн ачаар “мэдээллийн хэлхээ”, “ангийн дүрэм”, “хамтарсан баг”, “хүүхдийн эрх”, “хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх” гэхчлэн олон шинэ ойлголт нутагшиж байна” хэмээн Б.Цэвэлмаа багш эцэст нь өгүүлсэн.

“Гараа сайн бол бариа сайн” гэж, залуу багшийн ажил хөдөлмөрийн замнал гэрэл гэгээтэй, амжилт бүтээлээр дүүрэн байх болтугай!

“I make an effort to actively involve parents in the learning process because parental engagement has a significant impact on a child's academic performance, progress, behavior, and overall development. In our class, parents organize an activity or event once each term. These activities not only support children's growth and emotional well-being but can also help prevent issues such as exposure to online risks. Each activity is designed to be meaningful and effective. For this term, with the support of our parents, we are preparing a class visit to a bookstore so that our students can understand how their favorite books actually reach readers,” said B. Tsevelmaa.

Looking to the Future

When asked about her future goals Tsevelmaa replied, “I chose the teaching profession because I genuinely love it. I want to teach my class well, help my students graduate successfully, and see the results of my work. Building on the knowledge I gained from the ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project, I aim to further develop these skills and methodologies to become an outstanding teacher,” she said confidently.

Tsevelmaa emphasized that the knowledge and new methodologies she gained from the project have become an invaluable legacy for both herself and the school. Thanks to the project, many new concepts have taken root, including the ‘workflow chart,’ ‘classroom rules,’ ‘multi-disciplinary teams,’ ‘children's rights,’ and ‘positive discipline methods.’

As the saying goes, “A good start leads to a strong finish” may this young teacher's career continue to flourish with achievements and impact!

ОРГИЛЫН ӨНДӨР БЭЛИЙН НАМААС ЭХЭЛДЭГ

THE HEIGHT OF THE PEAK BEGINS FROM THE FOOT OF THE HILL

Хүүхэд хамгааллын тэргүүн эгнээнд...

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжиж буй Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны хамгааллын Хамтарсан баг нь сургуулийн Хүүхэд хамгааллын багтай хамтарч гурван талт гэрээний үндсэн дээр ажлын төлөвлөгөө гарган амжилттай ажиллаж байна. Төслийн үр дүнд Хамтарсан багийн гишүүд чадавхжиж, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, гарсан эрхийн зөрчил бүрийг эрт шатанд илрүүлэн, таслан зогсоосноор хүүхдийн тусгай дуудлагын 108 дугаарын утсанд ирж буй дуудлага мэдээллийн тоо эрс цөөрчээ. Өмнө нь энэ тоо жилд 30-аас дээш байсан бол төсөл хэрэгжсэн жилүүдэд тогтвортой буурсаар, энэ жил 18 дуудлага мэдээлэл бүртгэгджээ.

-Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой дуудлагын олонх нь гэр бүлийн хүрээнд архидаг согтуурсантай холбоотой байна. Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд сургуулийн багш, эцэг эх, хүүхдүүд, Хамтарсан багийн гишүүдэд олон төрлийн сургалт явуулж, нөлөөллийн хэд хэдэн аян зохион байгуулсан нь зөрчил мэдээллийн тоо буурахад голлон нөлөөлсөн гэж нийслэлийн Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны Засаг дарга, Хамтарсан багийн ахлагч Г.Энхтөгс ярилаа.

Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны нийгмийн ажилтан Т.Энх-Амгалан “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн сургагч багшаар бэлтгэгджээ.

How Khoroo No.13's Multi-Disciplinary Team Became a Model for Child Protection.....

In Mongolian tradition, there's a saying: “The height of the peak begins from the foot of the hill.” It means that great achievements start with solid foundations, built step by step from the ground up. For khoroo No.13 of Chingeltei District, this wisdom has proven true in an unexpected realm—child protection.

Khoroo 13 is entirely composed of ger districts, traditional residential areas that face unique challenges in providing services and maintaining safety. In this community setting, the Multi-Disciplinary Team (MDT) responsible for child protection faced a daunting reality: more than 30 calls per year to the 108 child helpline, most related to alcohol-related incidents within families and violations of children's rights. Yet through patient, systematic collaboration starting at the grassroots level khoroo No. 13 MDT has transformed into a model unit ranked third in the district and second in the capital city based on its performance. Teams from provinces across Mongolia now visit to learn from their approach. The foundation they built, step by step, has indeed reached impressive heights.

Understanding the Multi-Disciplinary Team's Mission

The khoroo's Multi-Disciplinary Team aims to “restore the rights of children who are neglected, physically punished, engaged in labor, exposed to psychological stress, victims of sexual violence, involved in crime, or have dropped out of school, and to prevent such violations of



Түүний онцолсноор, уг төсөл амжилттай хэрэгжихэд 17 дугаар сургуулийн Хүүхэд хамгааллын баг болон хорооны Хамтарсан баг хамтын ажиллагааны гэрээ байгуулан, урьдчилан сэргийлэх ажлыг хамтран зохион байгуулсан болон Хамтарсан багийн гишүүд тогтвор суурьшилтай ажилласан нь чухал хүчин зүйл болжээ. Энэ хорооны хувьд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх зориулалтын өрөө тасалгаатай болсон билээ.

-Хамтарсан багийн гишүүд болон сургуулийн Хүүхэд хамгааллын баг нь эрх нь зөрчигдсөн хүүхдийг илрүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрхэд суурилсан хандлагаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүүхдийг Ивээх Сангийн төслийн ажилтнууд сар бүр ажлын байран дээр ирж хүүхэд хамгааллын үйлчилгээг сургуультай хамтран үзүүлэхэд тогтмол зөвлөн тусалдаг. Бид мэдэхгүйгээ мэдэж, үр дүнтэй ажиллаж байна гэж нийгмийн ажилтан Т.Энх-Амгалан ярих. Хамтарсан багийн гишүүд тогтвор суурьшилтай ажиллахаас гадна шаардлагатай тохиолдолд төслийн хүрээнд нэг нь нөгөөгөө нөхөн ажиллах бүрэн чадвартай болсон

children's rights". The team not only identifies rights violations at an early stage and responds promptly to stop them but also provides health and psychological support to children who have experienced violence.

Enkh-Amgalan, social worker in khoroo 13, has been central to the team's work. When Save the Children "Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia," project came to the khoroo, she became a project trainer, helping to bridge the gap between community-based services and school-based protection.

Building the Foundation: Formal Collaboration

The Save the Children project provided the framework for systematic collaboration.

The MDT and School No. 17's Child Protection Team signed a cooperation agreement, a formal commitment to work together toward shared goals. Most importantly, they began jointly developing and implementing work plans, meeting regularly to coordinate their efforts.

"A major factor in the project's success was the collaboration between the Child Protection Team of School No. 17 and the khoroo's Multi-Disciplinary Team. The two teams signed a cooperation agreement and jointly organized preventive activities," Enkh-Amgalan explained

The cooperation agreement created accountability and structure. Save the Children project staff visit the schools and khoroo offices every month to guide child protection services, ensuring the collaboration remains active and effective.

The khoroo also established a dedicated room for providing child protection services a physical space where children and families could receive support in a confidential, professional setting. This room became a tangible symbol of the khoroo's commitment to child protection.

ажээ. Тухайлбал, тус хорооны халамжийн мэргэжилтэн Мөнхзул өмнө нь хорооны нийгмийн ажилтан байсан туршлагатай. Мөн зарим тохиолдолд сургуулийн нийгмийн ажилтан нь хорооны нийгмийн ажилтныг орлон шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллах чадвартай, тэр хэрээр ажил цалгардахгүй сайн талтай юм.

Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны Хамтарсан баг нь ажлын үзүүлэлтээр дүүрэгтээ 3-р байрт, нийслэлд 2-р байрт шалгарч байсан туршлагатай юм. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд “Хүнлэг байя”, “Би найзаа дэмжинэ”, “Сайн эцэг, эх” сургалт, үйл ажилаагаагаар, мөн Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг олон улсын өдрийг угтсан аян өрнүүлж, багш, нийгмийн ажилтан, эцэг эхийг сургагч багшаар бэлтгэж, сургагч багш нар шат шатандаа мэдлэгийг бусдад дамжуулан түгээн дэлгэрүүлэн ажилласан юм.

13 дугаар хороо нь 100 хувь гэр хороолол юм. Өнгөрсөн жил 25 байршилд 125 камер шинээр суурилуулжээ. Үүнээс 17 дугаар сургуулийн эргэн тойронд сургуультайгаа ярилцаж, эрсдэлийн үнэлгээ хийснээр 9 камер байрлуулан ажиллаж байна. Энд чиглэлийн нийтийн тээврийн хэрэгсэл огтлолцдог гол буудал байдаг учир хөл хөдөлгөөн ихтэй, хүүхдүүд гар утсаа алдах нь олонтаа байжээ. Харин бүрэн камержуулснаар хүүхдүүд хулгайд эд зүйлээ алдаж хохирох зөрчлийн тоо эрс багассан байна.

-Архангай, Орхон, Говь-Алтай, Ховд аймгийн зарим хороодын Хамтарсан багийн гишүүд биднээс туршлага судалж ирсэн. Мөн нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй дүүргийн 9 хорооны Хамтарсан багийн гишүүд хүрэлцэн ирж бидний үйл ажиллагаатай танилцсан. Бусдад үлгэр дуурайл болох хэмжээнд үнэлэгдэх болсонд Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн үр нөлөө маш их юм шүү. Нийгмийн

Strengthening Capacity and Flexibility

The project organized various training programs including the “Let’s Be Humane,” “I Support My Friends,” and “Safe Families” training, as well as a campaign held ahead of the International Day Against Corporal Punishment of Children. Teachers, social workers, and parents were trained as project trainers and then shared their knowledge with others at different levels.

Through this training, MDT members have strengthened their skills in prevention of violations of children’s rights, and identified and addressed any rights violations at an early stage. *“We have learned what we didn’t know before and are now working effectively,”* Enkh-Amgalan says simply.

The stable and consistent work of the MDT member have played an important role in the project’s success. Through the project, the team developed the ability to effectively substitute for one another when needed. For example, Munkh-zul, a welfare specialist in the khoroo, previously worked as a khoroo social worker, bringing valuable experience. In some cases, the school social worker can also step in for the khoroo social worker and provide prompt services, helping ensure that work continues smoothly without interruption.

This flexibility means that child protection services are never paused due to someone’s absence—a crucial capability when working with vulnerable children who need consistent support.

Collaboration in Action: Early Identification and Prevention

The real power of MDT-school collaboration became evident in daily practice. By working together with the school’s Child Protection Team within the project framework, the Multi-Disciplinary Team regularly conducted preventive activities, awareness campaigns, and advocacy efforts.

ажилтан маань сургагч багшаар бэлтгэгдсэн, Хамтарсан багийн гишүүд чадавхижсан нь бидний амжилтад сайнаар нөлөөлж байна гэж 13 дугаар хорооны Засаг дарга, тус хорооны Хамтарсан багийн ахлагч Г.Энхтөгс сэтгэл дүүрэн өгүүлж байна.

Бид төслийн хүрээнд сургуулийн Хүүхэд хамгааллын багтайгаа хамтран урьдчилан сэргийлэх болон олон нийтэд мэдлэг, мэдээлэл түгээх, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж ажилласан. Хүчирхийлэл дарамтад өртөж байж болзошгүй хүүхдийг таньж мэдэх багшийн ур чадвар нэмэгдсэнээр эрт илрүүлэн Хамтарсан багт мэдээлж, хүүхэд хамгааллын үйлчилгээг шуурхай, илүү чанартай үзүүлэх, эргээд сургуулийн орчинд хүүхдийн боловсролыг тасалдуулахгүй байх зэрэг олон ач холбогдолтой гэж нийгмийн ажилтан Т.Энх-Амгалан ярилаа.

Тодруулга:

Хорооны хүүхэд хамгааллын Хамтарсан баг нь, “Үл хайхрагдсан, бие махбодын хувьд шийтгэгдсэн, хөдөлмөр эрхэлж байгаа, сэтгэл санааны дарамтад өртсөн, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон, гэмт хэрэгт холбогдсон, сургууль завсардсан зэргээр зөрчигдсөн хүүхдийн эрхийг нөхөн сэргээх, ийм төрлийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой” юм. Хүүхдийн эрхийн зөрчлийг эрт шатанд илрүүлж, шуурхай таслан зогсоохоос гадна хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрүүл мэнд, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэн ажилладаг байна.

As teachers improved their ability to identify children who might be exposed to violence or harassment, through project training, they gained confidence in recognizing early warning signs. When they identified concerns, they could immediately report them to the MDT, and collaborate to provide timely, high-quality child protection services. The two teams would then collaborate to provide timely, high-quality child protection services.

This, helped ensure that children’s education in the school environment was not disrupted. The collaboration extended beyond individual cases to environmental safety. A risk assessment conducted in consultation with School No.17, identified concerns around the school area, at a major bus stop where several public transport routes intersect. The area is always crowded, and cases of children losing belongings or facing other risks was frequent.

Following the assessment, nine security cameras were installed around the school. As part of a broader effort, 125 new cameras were installed in 25 locations throughout the ger district. After the installation, incidents involving children declined significantly—a practical example of how risk assessment and coordinated action create safer environments for children.

Measurable Impact: From Data to Hope

The results of this systematic collaboration are evident in the numbers. Previously, the 108 child helpline, received more than 30 calls per year. During the project period, the number steadily decreased, with only 18 calls recorded this year a reduction of 40 percent.

According to Governor Enkhugs, Head of the Multi-Disciplinary Team, the training session and awareness campaigns conducted for teachers, parents, children, and MDT members have been a key factor in reducing the number of reported violations. When families understand child development and positive parenting, when teachers can identify and respond to concerns

early, and when community services work seamlessly with schools, fewer children reach crisis points that require helpline intervention

Becoming a Model: Sharing the Foundation

The transformation of khoroo 13's approach to child protection has not gone unnoticed. The Multi-Disciplinary Team's ranking—third in the district and second in the capital city based on performance—reflects the effectiveness of their collaborative model.

More significantly, their work has become a learning site for others. Members of Multi-Disciplinary Teams from Arkhangai, Orkhon, Govi-Altai, and Khovd provinces have visited khoroo 13 to learn from their experience. Additionally, members of MDTs from nine khoroots in Songinokhairkhan, Bayangol, and Chingeltei districts of Ulaanbaatar have visited to observe the project's activities.

"The fact that the project has become a model for others reflects the significant impact of the 'Estab-

lishing School-Based Child Protection Mechanism in Mongolia' project," Governor Enkh-tugs observes. The training of social workers to become trainers, along with the improved capacity of the Multi-Disciplinary Team, has played a key role in our success"

The success of khoroo 13's Multi-Disciplinary Team demonstrates that effective child protection doesn't require perfect resources or ideal conditions. It requires what the Mongolian proverb teaches: building a solid foundation, step by step, from the ground up.

For social worker Enkh-Amgalan, Governor Enkh-tugs, and all the members of the MDT and school protection team, the work continues. But they now work from a position of strength, with proven systems, trained personnel, and the knowledge that their collaborative approach makes a real difference in children's lives. The peak's height, after all, is not a destination but a vantage point from which to see new horizons and continue the work of protecting every child.



“ҮЛГЭР ЖИШЭЭ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ”

EXEMPLARY PARENTS' COUNCIL

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэн нийслэлийн ерөнхий боловсролын 58 дугаар сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн сайн жишээ, туршлагыг онцлон танилцуулъя. Сайн дураараа, ашгийн бүс, зөвхөн хүүхдийн сайн сайхны төлөө үлгэр жишээ ажиллаж буй тус сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн дарга М.Лхагвасүрэн 2019 онд энэ албанд сонгогджээ.

М.Лхагвасүрэнгийн хэлснээр, тэрээр 2023 он хүртэл нэр төдий албан тушаалд, ёс төдий ажиллаж байсан гэнэ. Гэтэл мөн онд тус сургууль нь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөлд хамрагдсанаар урьдын байдал нэн хурдан хувирч өөрчлөгдсөн байна. Тэрээр, уг төслийн хүрээнд “Сайн эцэг эх” сургалтад сууснаар “нүд нээгдэх” шиг болсон гэж ярьж байна. Эцэг эхийн зөвлөлийн дарга М.Лхагвасүрэн “Сайн эцэг эх” сургалтын сургагч багшаар бэлтгэгдэж, бусад сургагч багш нарын хамтаар сургуулийн нийт 800 эцэг эхэд заан түгээжээ.

This story highlights the good practices and experiences of the Parents' Council at General Education School No.58 in Ulaanbaatar, which participated in the Save the Children's “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project . Operating on a voluntary, non-profit basis, the council works solely for the well-being of children. The council's chair, M. Lkhagvasuren, was elected to this position in 2019.

According to Lkhagvasuren, until 2023, his work as chair had been rather routine. However, when the school joined the ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project, everything changed rapidly and dramatically. He described his participation in the “Safe Families” training as an eye-opening experience. As Chair of the Parents' Council, he became a “Safe Families” trainer and, together with other trainers, provided training and shared knowledge with 800 parents at the school.

“Parents who attended the ‘Safe families’ training have gained a deeper understanding of how to communicate and interact with their children.

-“Сайн эцэг эх” сургалтад суусан эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хэрхэн харьцах талаарх мэдлэгээ нэг шат ахиулсан шүү. “Дахиад сургалт байна уу?” гэж асуудаг болсон. Хүүхдээ ойлгодоггүй байж, одоо яаж харилцахаа сурч мэдлээ гэж ам сайтай байсан гэж М.Лхагвасүрэн ярих.

Энэ бол зөвхөн эхлэл байлаа. Сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа урд хожид байгаагүйгээр идэвхжив. Эцэг эхийн зөвлөлд тус сургуулийн 1-12 дугаар анги бүрээс нэг, нэг эцэг, эх төлөөлөл болон сонгогдож, даргатайгаа хамт, нийт 13 гишүүнтэй болон, орон тоо, бүтэц нь шинэчлэгдэв. Шинээр зохион байгуулагдсан Эцэг эхийн зөвлөл маань “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн арга зүй, удирдамжийн дагуу ажиллаж эхлэв. Тэд зөвхөн сургалт явуулж, эцэг эхчүүдэд нөлөөлөөд зогссонгүй, бодит ажил зохион байгуулж, төсөл хэрэгжүүлсэн юм. 58 дугаар сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн санаачилсан “Дээрэлхэлтгүй сургууль-Дээрэлхэлтгүй анги” төсөл нь Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд зарласан бичил төслийн шалгаруулалтад тэнцжээ. “Дээрэлхэлтгүй сургууль-Дээрэлхэлтгүй анги” төслийн хүрээнд сургуулийн ахлах ангийнхны дунд видео контентын, дунд ангийн сурагчдын дунд ханын самбарын, бага ангийнхны дунд гар зургийн уралдаан зарлаж дүгнэсэн байна.

-Төсөл маань амжилттай хэрэгжихэд ангийн багшийн оролцоо чухал байлаа. Ангийн багш хүүхдүүдээ сэдэлжүүлж, гурван ангилалтай уралдаанд идэвхтэй оролцуулсан. Уралдаанд ирсэн бүтээлүүд бүгд агуулга сайтай, нээрэн л дээрэлхэлт ийм муухай юм байна шүү



They often ask, ‘Will there be more training?’ said Lkhagvasuren. “Many parents used to struggle to understand their children, but now they have learned how to relate and communicate effectively with them.”

This was just the beginning. The activities of the Parents’ Council became more dynamic than ever before. One parent representative from each grade, 1 through 12, was elected to the council, which, together with the chair, now consists of 13 members. The council’s structure and roles were reorganized and operated in accordance with the methodology and guidelines of the ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project. Rather than limiting themselves to training and members also organized practical initiatives and implemented project activities.

One micro-project initiated by the Parents’ Council, ‘Bullying-Free School – Bullying-Free Class,’ was funded by Save the Children. As part of the project, various competitions were held: a video contest for high school students, a poster contest for secondary students, and a drawing contest for primary students.

“The participation of class teachers was crucial to the success of our project. Teachers motivated their students and encourage active participation in the three competitions. The submitted works were rich in content, allowing both children and adults to truly feel and understand the harm caused by bullying,” said M. Lkhagvasuren. He added that the main goal of the project was to demonstrate that every child deserves to learn and grow in an environment free from peer bullying.

Entries were evaluated collaboratively by members of the Parents’ Council and the school’s so-

гэдгийг хүүхдүүд төдийгүй томчууд хүртэл зүрх сэтгэлдээ мэдэрч ойлгох хэмжээнд туурвисан нь олзуурхууштай байлаа. Хүүхэд бүр үе тэнгийн дээрлэхэлтгүй орчинд сурч, хөгжих ёстой гэдгийг харуулах гол зорилготой байсан гэж Эцэг эхийн зөвлөлийн дарга М.Лхагвасүрэн ярьсан юм.

Уралдаанд ирсэн бүтээлүүдийг Эцэг эхийн зөвлөлийн гишүүд болон сургуулийн нийгмийн ажилтнууд хамтран шалгаруулсан байна. Шалгарсан бүтээлүүдээр сургууль дээр хоёр ч удаа үзэсгэлэн гаргаж сурталчилжээ. 58 дугаар сургуулийн Эцэг эхийн зөвлөлөөс өөр нэгэн чухал ажил санаачлан хэрэгжүүлсэн нь, “Хүүхэд хүүхдэдээ тусалъя” аян байжээ. Хүнд нөхцөлд суралцаж буй, ар гэрийн боломж тааруу нэгэндээ хүүхдүүд чин сэтгэлээсээ, хичээнгүйлэн тусалсан юм. Тэдний зорилтот бүлгийн найзууддаа илгээсэн тусламжийн бэлэг дотор хичээлийн хэрэгсэл, хоол хүнс, хувцас хунар байлаа. Эцэг эхийн зөвлөлийн гишүүд сургуулийн нийгмийн ажилтан, багш нарын тусламжтайгаар хэрэгцээт өрхийн судалгаа хийж, “Хүүхэд хүүхдэдээ тусалъя” аяны хүрээнд цугласан тусламжийг эздэд нь хүргэж өгчээ.

58 дугаар сургуульд Сүхбаатар дүүргийн 15, 16 дугаар хорооны 3800 орчим сурагч суралцаж байна. Хичээлийн 3 байртай ч анги дүүргэлт ихтэй байдаг байна. Эцэг эхийн зөвлөл хүүхдийн эрхийг хамгаалах талаар энэ мэт бодит ажил, арга хэмжээ зохион байгуулснаас гадна ирээдүйд хийх ажлаа төлөвлөн “завгүй” байх болжээ. Ажлын төлөвлөгөөгөө жилээр гаргаж, улирал тутам нэг удаа, шаардлагатай тохиолдолд хугацаа хамаарахгүй хуралддаг болжээ. Тухайлбал, тэд удахгүй сургуулийн эргэн тойронд эцэг, эхийн хяналтыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэ нь “School police”-гоос тусдаа, зэрэгцсэн хяналт юм. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс Эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд таних тэмдэг бүхий хантааз хийж өгчээ.

Мөн тус Эцэг эхийн зөвлөлийн ажлын

cial workers. The selected works were exhibited twice at the school to showcase and promote them.

Another important initiative led by the Parents' Council was the 'Children Helping Children' campaign. Through this activity, students supported their peers from disadvantaged families by preparing and donating aid packages that included school supplies, food, and clothing. With the assistance of the school's social workers and teachers, Parents' Council members identified households in need and personally delivered the collected support to the targeted children.

School No. 58 serves approximately 3,800 students enrolled from Khoroo 15 and 16 of Sukhbaatar district. Although the school has three classroom buildings, classes are often overcrowded. The Parents' Council has become highly active, prepared an annual work plan and scheduled meetings once each quarter, or more frequently if necessary. For example, the council is planning to organize parent supervision around the school, complementing the School Police. As part of the project, council members were provided with jackets marked with identification for this purpose.

The Parents' Council's work plan also included organizing traditional games and competitions such as chess, checkers, anklebone picking and flicking. These activities aim to reduce children's screen time and foster warm, family-centered activities. In addition, the council plans to launch a campaign called 'Respect Begins with Greetings' and to establish a gratitude board and box to encourage direct, meaningful interaction between children and their parents.

Lkhagvasuren also works as a manager for family finance and character education training at the non-governmental organization (NGO) MINA. Four of his children attend School No. 58, from grades 2 to 10.

Speaking as the chair of the Parents' Council, he shared: “*Although the 'Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia' project is*

төлөвлөгөөнд уламжлалт тоглоом наадгай, шатар, даам, шагай шүүрэх, няслах тэмцээн зохион байгуулахаар тусгагджээ. Энэ нь дэлгэцийн хэт хамаарлаас хүүхдийг холдуулж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг мэдрүүлэх ач холбогдолтой юм. Түүнээс гадна “Хүндлэх нь мэндлэхээс эхэлнэ” аян өрнүүлэхээр бэлтгэл хангаж байгаа аж. Талархлын самбар, хайрцаг бий болгож, хүүхэд, эцэг эхийн амьд харилцааг дэмжих нь ч төлөвлөгөөний нэгэн заалт болон дурайж байна.

М.Лхагвасүрэн “МИНА” төрийн бус байгууллагын өрхийн санхүү, зан чанарын сургалтын менежер ажилтай хүн юм. 58 дугаар сургуульд түүний дөрвөн хүүхэд 2-10 дугаар ангид суралцдаг. Эцэг эхийн зөвлөлийн дарга М.Лхагвасүрэн хэлэхдээ,

-Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэдий дуусаж байгаа ч хүрсэн ололт амжилтыг цааш тасалдалгүй үргэлжлүүлээсэй, яам, агентлаг санаачилж, улсын хэмжээний бүх сургуульд энэ арга зүйг нэвтрүүлээсэй гэж хүсэж байна. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг санаачилж, Монгол Улсад хэрэгжүүлсэн, ингэхдээ маш нарийн судалгаатай, үл суурьтай хандаж, цаашид өвлөгдөхүйц үнэт зүйл бий болгосон донор байгууллага, Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн хамт олон, хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүст сургуулийнхаа Эцэг эхийн зөвлөлийн нэрийн өмнөөс болон нийт эцэг эхчүүдийнхээ өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлж, цаашдын ажилд нь амжилт хүсэн ерөөе! гэв.

ending, I hope that the achievements will continue without interruption. I also hope that relevant ministries and agencies will take the initiative to introduce this methodology to all schools nationwide. On behalf of the Parents' Council of our school and all parents, I would like to sincerely thank the donor organization, Save the Children in Mongolia, as well as all partner organizations and individuals who initiated and implemented the project in Mongolia. Their approach was grounded in research and a strong foundation, creating enduring values that can be passed on. We wish them continued success in all their future endeavors!”

ЧАДВАРЛАГ БАГ-АМЖИЛТЫН ҮНДЭС

A COMPETENT TEAM — THE FOUNDATION OF SUCCESS

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжиж буй газруудын нэг нь нийслэлийн ерөнхий боловсролын 48 дугаар сургууль билээ. Аливаа төсөл амжилттай хэрэгжих үндэс суурь нь төслийн ажлын хэсэг. Ажлын хэсэг буюу баг бүрдсэнээр төсөл үр дүнтэй, хуваарийн дагуу явагдах, гишүүдийн хариуцлага тодорхой болох, бүтээлч санаа, шинэ шийдэл гарах, хамтдаа зорилгодоо хүрэх боломж бүрдэнэ. Тиймээс тус сургуулийн төслийн ажлын хэсгийг онцолж байна.

Сайн баг бүрдүүлэх чухал учраас...

Нийслэлийн ерөнхий боловсролын 48 дугаар сургуульд Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг хэрэгжүүлэх ажлын хэсэг нь захирал Б.Эрдэнэчимэг, нийгмийн ажилтан П.Оюун-Эрдэнэ, Б.Оюунчимэг, бага ангийн багш Л.Даваасүрэн, Ж.Болор-Эрдэнэ, ахлах ангийн багш Т.Хоролсүрэн, Т.Мөнгөнтуяа, дунд ангийн багш Б.Оюунбилэг, А.Өнөрзаяа, сэтгэл зүйч Г.Ганцэцэг, Дүрслэх урлагийн багш Э.Батхишиг гэсэн 11 гишүүнтэй. Тус багийг анх байгуулахдаа хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас хамааран сургуулийн 149 багшаас бусдад нөлөөлөх чадвартай, манлайлагч шалгуураар бага, дунд, ахлах ангийн багш нарын төлөөлөл болгон сонгосон байна. Гэхдээ өөрсдийн саналаар төслийн ажлын хэсэгт оролцох боломжтой багш ажилтнууд багт нэгдсэнээс хойш ердөө хоёр удаа солигдож, дөрвөн гишүүн шинээр нэмэгджээ. Тиймээс багийн гишүүдийн

General Education School No.48 in the capital city is one of the schools implementing Save the Children’s ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project. The foundation of any successful project lies in its Project Implementation Unit (PIU). A well-established project team ensures effective and timely implementation, clearly defined responsibilities among members, the generation of creative ideas and innovative solutions, and the ability to achieve shared goals collaboratively. For these reasons, we highlight the Project Implementation Unit of this school.

Because Forming a Strong Team Matters...

The PIU responsible for implementing the project at General Education School No. 48 consists of 11 members: School Principal Erdenechimeg; social workers Oyun-Erdene and Oyunchimeg; primary school teachers Davaasuren and Bolor-Erdene; high school teachers Khorolsuren and Munguntuya; secondary school teachers. Oyunbileg and Unurzaya; school psychologist Gantsetseg; and art teacher Batkhishig.

When the unit was first formed, representatives from the primary, secondary, and high school levels were selected from among the school’s 149 teachers based on their leadership qualities and ability to positively influence others, with consideration of the activities planned under the project. In addition, some teachers and staff who expressed interest in joining the PIU were selected. Since its establishment, the team has changed only twice, with four new members added. As a result, the PIU’s collective knowledge, skills, and experience are well balanced, built on a foundation of positive attitudes, mutual trust, and consistent leadership. Each mem-

мэдлэг, чадвар, туршлага хоорондоо уялдаж, зөв хандлага, харилцан итгэлцэл, тууштай манлайлал дээр тогтож байгаа юм. Өөрөөр хэлбэл гишүүн бүрд давуу талаа ашиглах боломж бүрджээ. Мэдлэг, ур чадвар, арга барилын хувьд харилцан хамааралтай, нийтлэг зорилгодоо хүрэхийн тулд хүчин чармайлтаа нэгтгэн ажиллаж буй хүмүүсийг баг гэдэг. Харин төслийн багийн хувьд тодорхой хугацаанд, тодорхой зорилгоор үйл ажиллагаагаа хамтдаа хэрэгжүүлдэг билээ.

Ажлын хуваарь чухал учраас...

Тухайн ажлаа боломжтой хугацаанд, бодитоор гүйцэтгэхийн тулд багийн гишүүдээ зөв хуваарилах нь нэн чухал. Нийслэлийн 48 дугаар сургуулийн төслийн ажлын хэсгийнхэн өөрсдийн ажлыг үүргийнхээ дагуу хуваарилан авч, ахлан хариуцан ажилладаг болжээ. Тухайлбал, бага ангийн хүүхдүүдийн эцэг эхийн сургалтыг бага ангийн нийгмийн ажилтан Б.Оюунчимэг ахлан хоёр багшийн хамт зохион байгуулдаг. Харин дунд ангийн сурагчдын эцэг эх асран хамгаалагч нарт “Сайн эцэг эх” сургалтыг А.Өнөрзаяа багш

ber can contribute their unique strengths to the team.

A team is a group of people who are interdependent in terms of knowledge, skills, and methods, combining their efforts to achieve a shared goal. In a project context, the team works together for a defined period toward clearly established objectives.

Because a Clear Division of Responsibilities Matters...

To carry out their work effectively within the available time, it is essential to assign responsibilities appropriately among team members. At School No. 48, members of the PIU implement tasks according to their defined roles. For example, the training for parents of primary school students is led by primary school social worker Oyunchimeg, and two teachers. The ‘Safe Families’ training for parents and caregivers of secondary school students is led by teacher Unurzaya, with Oyunbileg and Batkhishig working together as a team. Similarly, activities for parents of high school students are organized by school psychologist Gantsetseg, in collaboration with teachers Munguntuya and Khorloo.





ахлаад Б.Оюунбилэг, Э.Батхишиг нар хамтдаа баг болон заасан байна. Түүнчлэн ахлах ангийн сурагчдын эцэг эхчүүдэд зориулсан үйл ажиллагааг сэтгэл зүйч Г.Ганцэцэг ахлан, Мөнгөнтуяа, Хорлоо багш нар хамтран зохион байгуулах жишээтэй. Төслийн нэг томоохон ажил бол “Сайн эцэг эх” сургалт юм. Өнөөдөр хүмүүс цаг завгүй болсон үе. Тиймээс тус сургуулийн багийнхан сургалтаа зохион байгуулахаас өмнө эцэг эхчүүдийг идэвхжүүлэхийн тулд зар урилгыг хамт хүргүүлдэг байна. Эхний үед хүмүүс идэвх муутай байсан ч явц дунд хандлага нь өөрчлөгдөж, хэрэгцээ шаардлагыг нь ойлгож сургалтад хамрагдах сонирхол нь нэмэгджээ. Мөн албан байгууллагууд руу нийгмийн хариуцлагын хүрээнд ажилтнуудаа сургалтад хамруулах зөвшөөрөл өгөхийг хүссэн захидал илгээсэн нь үр дүнтэй болжээ. Эцэг эхчүүдэд байгууллагынх нь дэмжлэг чухал байдаг. Төсөл эхлэх үеэр эцэг эхчүүд ойлголт багатай “Сургалт явуулдаг юм уу, зүгээр цуглуулаад байдаг юм уу” гэх мэтийн асуултууд түгээмэл ирдэг байв. Харин төслийн явцад хүүхэд хамгааллын сургалтууд энгийн, шинэлэг аргаар ойлгуулж, олон арга зүй өгсөн хэмээн сэтгэл хангалуун байдаг аж. Хүүхдийнх нь нас сэтгэхүйд тохирсон сургалтуудыг эцэг эхчүүд таатай хүлээн авч, стрессээ даван туулах, хүүхэдтэйгээ ярилцах, ойлголцох гэх мэтийн

Because project implementation matters... Engaging Parents: The ‘Safe Families’ Training

One of the major components of the project is the ‘Safe Families’ training. Today, people are busier than ever. Therefore, before organizing the training, the school’s PIU delivered invitations and announcements together to encourage parents’ participation. Initially, parents’ engagement was low, but over time their attitudes changed as they began to understand the importance and relevance of the training, and their interest in joining increased. The school also sent official letters to organizations, requesting them to allow their employees to participate in the training as part of their corporate social responsibility, which proved effective.

Support from employers is important for parents’ participation. At the beginning of the project, many parents had limited understanding and often asked, “Is this a proper training or just a meeting?” As the project progressed, however, parents expressed satisfaction, noting that the child protection training was simple, innovative, and offered many practical methods. They appreciated that the content was appropriate for their children’s age and development and that it helped them cope with stress, communicate with their children, and improved mutual understanding. Over time, their attitudes shifted as their knowledge broadened. A total of 1,200 parents have participated in the training.

олон талын мэдлэгтэй болж, хандлага нь өөрчлөгджээ. Нийт 1200 эцэг эхийг сургалтад хамруулсан байна.

Төслийн гүйцэтгэл чухал учраас...

Ажлын хэсгийн гишүүд багш, ажилтнуудад зориулсан сургалтыг ээлж солигдох боломжит цаг, хуваарийг тооцон явуулдаг байна. Төсөл хэрэгжих хугацаанд Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны “Иргэний танхим”, сургуулийнхаа анги танхимыг ашиглаж, боломж нөөцдөө тулгуурлан сургалтуудаа зохион байгуулж байгаа аж. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл 48 дугаар сургуульд хэрэгжиж эхэлснээр 110 бүлгийн 13 төлөөллөөс бүрдсэн Эцэг эхийн зөвлөл албан ёсоор байгуулж, өнгөрсөн хугацаанд хоёр төсөл амжилттай хэрэгжүүлсэн байна. Өнгөрсөн хавар “Галт шувуу” төсөл зургаан чиглэлээр үйл ажиллагаа явуулжээ. Үүгээр 3500 гаруй эцэг эхийг хамруулан, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, “Мэргэжлээ сурталчилъя”, “Тэврэлт илгээ” гэх мэтийн сургуулийн орчинд сурагчдад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан байна. Сургуулийн Эцэг эхийн зөвлөл үүрэг оролцоотой байж, хүртээмжтэй, бодитой, хүүхдүүдэд хүрэх ажлууд санаачилсан ажээ. 48 дугаар сургуулийн багш А.Өнөрзаяа “Би найзаа дэмжинэ” хөтөлбөрийн үетэнгийн сургагчдын чиглүүлэгчээр ажиллажээ. Тэрээр эдгээр сурагчдыг сургалтад хамрагдсан байдал, өөрсдийнх нь хүсэл эрмэлзэл, эцэг эхийн зөвшөөрлийн дагуу сонгосон байна. 9-11 дүгээр ангийн 125 хүүхдийг хамруулан бүлэг үүсгэжээ. “Эдгээр хүүхдүүдийг багаар хувааж, заах сэдвийг нь хуваарилж өгсөн. Бага, дунд, ахлах зэрэг бүх ангид “Би найзаа дэмжинэ” сургалтаа хүргэсэн” хэмээн багш А.Өнөрзаяа ярилаа. Энэ сургалтаар хүүхдүүдэд хүүхэд хамгааллын мэдлэгийг энгийн байдлаар ойлгуулж, эерэг өөрчлөлт авчирсан байна. Түүнчлэн бага ангийн хүүхдүүдийн дунд оролцооны клуб шинээр байгуулж, хүүхэд хүүхдэдээ эерэгээр нөлөөлөх үйл ажиллагаа

Members of the PIU organize training for teachers and staff by coordinating schedules and available time slots to ensure maximum participation. Throughout the project, they conducted sessions in the “Citizen Hall” of Bayanzurkh District’s 1st khoroo, as well as classrooms within their own school, making full use of available resources.

Building on the success of parent engagement, a Parents’ Council consisting of 13 representatives from 110 classes has been officially established. The council has successfully implemented two projects to date. Last spring, the “Firebird” project carried out activities across six focus areas, reaching more than 3,500 parents, organizing an open day event, and implementing school-based student activities such as “Promote Your Profession” and “Send a Hug.” The school’s Parents’ Council played an active role, initiating practical, inclusive activities that directly benefited the students.

Empowering Students: Peer Education and Participation

Teacher Unurzaya from School No.48 served as a project facilitator for the peer educators in the “I Support My Friends” program. She explained we selected students based on their participation in the training, their motivation, and with their parents’ consent. A total of 125 students from grades 9–11 participated in this program. We divided them into smaller teams and assigned topics for them to teach. The “I Support My Friends” training was delivered across all grade levels — primary, secondary, and high school.” Through this training, children were introduced to child-protection concepts in a simple and accessible way, which brought about positive changes.

A new participation club was established among primary school students, allowing children to positively influence one another. Currently, School No. 48 has more than 4,400 students, with over 520 participating in 17 participation clubs. The newest club was formed by students from Grade 5.

Students at this school, with the support of the ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project, implemented

явуулдаг болжээ. Өнөөдрийн байдлаар 48 дугаар сургууль 4400 гаруй сурагчтай бөгөөд эдгээрээс 520 гаруй нь 17 оролцооны клубт хамрагддаг аж. Хамгийн отгон нь 5 дугаар ангийн сурагчдын байгуулсан оролцооны клуб юм.

Тус сургуулийн сурагчид “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн дэмжлэгээр “Оргил ба түүний найзууд X team ” төсөл хэрэгжүүлж, “Stop bullying” аян өрнүүлжээ. Хүүхдүүд долоо хоног үргэлжилсэн аяныг эергээр хүлээн авсан байна. Төсөл хэрэгжих хугацаанд тус сургуульд нутагшсан зүйл бол хүүхэд хамгааллын мэдээллийн хэлхээ юм. Үүн дээр сургуулийн нийгмийн ажилтан, хороо, дүүргийн цагдаа, Хамтарсан багийн утасны дугаар, мөн итгэлтэй утасны дугаарыг ч байршуулжээ. Хүүхдүүд эрх нь зөрчигдвөл хаана, хэнд хандахаа мэддэг болж, нээлттэй болж чадсан байна.

Ажлын хэсгийнхэн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн сургалтын “Гарын авлагуудын агуулга нь тодорхой, ойлгомжтой, өнгө загварын хувьд шинэлэг байдаг. Эцэг эхийн зөвлөлийн гарын авлага бол сургуулийн баримталж байгаа эрх зүйн баримт бичиг. “Сайн эцэг эх” сургалтын гарын авлагын агуулга арга зүйгээр сургалтаа явуулахад хэлэх гэсэн санаа, асуудлуудаа гаргаж чаддаг” хэмээн дүгнэж байлаа.

Нийслэлийн ерөнхий боловсролын 48 дугаар сургуульд хэрэгжиж буй Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн ажлын хэсэг нэгэн зорилгын төлөө, сэтгэл зүтгэлээ нэгтгэн ажилласны үр дүнд гарсан амжилтуудаас өгүүлэхэд ийм. Энэ амжилтууд бол төслийн төгсгөл биш, харин ирээдүйд гарах олон шинэ санаа, өөрчлөлтийн эхлэл юм.

the “Orgil and His Friends X Team” project and carried out a “Stop Bullying” campaign. The students responded positively to the week-long campaign.

With support from the project, students at the school also implemented the “Orgil and His Friends X Team” project and carried out a “Stop Bullying” campaign. The students responded positively to the week-long campaign.

Establishing Clear Systems and Procedures

During the project, one of the school's key achievements was the development of a child protection workflow chart. This chart includes the contact information of the school social worker, the local khoroo and district police, the Multi-Disciplinary Teams, as well as the trusted phone line. As a result, students now know where and to whom to report if their rights are violated, and they have become more open and confident in seeking help.

Members of the PIU noted that the training manuals developed under the project are clear, easy to understand, and visually innovative. They also highlighted that the Parents' Council manual reflects the legal documents that the school follows, and the content and methodology of the “Safe Families” training manual enable participants to clearly and effectively convey the ideas and issues they wish to address.

Looking Forward

The achievements described above reflect the results of the PIU at School No. 48, which has worked with dedication and a shared sense of purpose. These successes demonstrate how a competent, well-coordinated team serves as the true foundation of meaningful change. The work continues- not as an ending, but rather the beginning of many new ideas and positive changes to come in the future.

ХҮҮХДЭЭ ХАЙРЛАХ УХААРАЛ ӨГСӨН “ГЭРЭЛТ САМБАР”

THE LIGHT BOARD THAT INSPIRED PARENTS TO LOVE THEIR CHILDREN MORE

Нийслэлийн 73 дугаар сургууль бол Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжиж буй газруудын нэг. Тус сургуулийн Эцэг, эхийн зөвлөлийнхөн төслийн хүрээнд нэгэн ажил зохион байгуулсан нь “Гэрэлт самбар” төсөл байлаа.

Төслийн санаагаа хэрхэн олсон талаараа тус сургуулийн Эцэг, эхийн зөвлөлийн гишүүн, 5-р ангийн эцэг, эхийн зөвлөлийн дарга Б.Нямдаваа ийнхүү ярилаа. Тэрээр “Манай бага охин сургуулийнхаа волейболын секцэд явдаг. Өглөө 6.00 цагт бэлэн байх учраас 5 цаг 50 минутад очих ёстой. Өвлийн улиралд өглөө харанхуй байдаг. Сургуулийн үүдний хэсэгт гэрэл илүү нэмэх хүсэлтэй явдаг байсан юм. Энэ үед төсөлд оролцох боломж гарснаар санаагаа бодит ажил болголоо. 2024-2025 оны хичээлийн жилд манай сургуулийн эцэг эхийн зөвлөл шинэчлэгдэн 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан юм. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд сургууль дахь төслийн ажлын хэсэгтэй Эцэг эхийн зөвлөл маань нягт хамтран ажилласан. Төслийн нийт 14 сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн дунд зарласан бичил төслийн уралдаанд оролцож, хоёр удаа санхүүжилтийн дэмжлэг авсан. Төслөө сайн бичиж, санхүүжилт аваад сургуульдаа заавал хэрэгжүүлнэ гэж зорьсон” хэмээн өгүүлэв.

“Гэрэлт самбар” төслийн баг зургаан гишүүнтэй, нас насны хүмүүсийн төлөөллөөс бүрдэнэ. Тэдний хувьд сургуулийнхаа хүүхдүүд, эцэг, эхчүүдэд үр бүтээлтэй, шинэлэг зүйл бүтээж өгөх зорилготой байлаа. Тиймээс самбараа хүмүүст өдөр тутамдаа дадал болгох хүүхдээ “Өдөр бүр тэвэрье”, “Үргэлж сонсье”, “Дандаа ярилцъя”

School No. 73 in Ulaanbaatar is one of the locations where Save the Children’s ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project is being implemented. Through the project, the school’s Parents’ Council has undertaken initiatives that address both practical needs and emotional connections between parents and children. The Light Board Project

Nyamdavaa, a member of the school’s Parents’ Council and chair of the 5th-grade Parents’ Council, shared how one project began with a simple observation from daily life.

“Our younger daughter attends the school’s volleyball club. She needs to be ready by 6:00 a.m., which means we have to arrive at 5:50. In winter, it is still dark at that time, and I had always wished for better lighting at the school entrance. When the opportunity to participate in the project arose, we were able to turn this idea into a real initiative.”

In the 2024–2025 academic year, School No. 73’s Parents’ Council was restructured and now consists of 13 members. Through the project, the Council worked closely with the school’s Project Implementation Unit (PIU). They participated in the micro-project initiative held among the Parents’ Councils from 14 schools and received financial support twice. *“Our goal was to prepare a strong proposal, secure funding, and ensure that our micro-project was successfully implemented at our school,”* she said.

The “Light Board” project team consisted of six members representing different age groups. Their goal was to create something both useful and innovative for the students and parents at their school. They printed the board with three motivational messages promoting positive daily habits for parents: ‘Hug your child every day,’ ‘Always listen,’ and ‘Let’s always talk.’ They also produced smaller versions of the board as refrig-

гэсэн гурван уриа үгтэй хэвлэж, мөн жижиг хувилбараар хөргөгчийн наалт болгожээ. Эцэг эх, асран хамгаалагчид тэдний ажлыг сайнаар хүлээн авч, талархлаа илэрхийлэн, амжилт хүсэж байв.

Б.Нямдаваагийн хувьд “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэнд баяртай байгаа бөгөөд “Сайн эцэг эх” сургалтын чиглүүлэгч болж, бусад эцэг эхчүүдэд сургалт мэдээлэл өгч ажиллажээ. Эдгээр сургалтуудад нийт 800 эцэг, эх хамрагджээ. Эцэг эхчүүдэд сургуулиас зохион байгуулж буй сургалт, үйл ажиллагаанд дахин оролцох хүсэл төрүүлдэг хэмээлээ. Сургалтуудаас хүүхэдтэйгээ хэрхэн харилцах, санаа бодлыг сонсох, ойлгох, мэдрэх болон өөрийгөө ойлгуулах гээд олон зүйлийг мэдэж авсандаа баяртай байна” гэж тодотгосон юм.

Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын нэг хэрэглэгдэхүүн нь “Тэнцвэрийн хүрд” тест юм. Түүнийгээ 5 дугаар ангийн хүүхдүүд, эцэг, эхчүүдэд танилцуулж, хүүхдүүдээ хэр сайн мэддэг вэ, хүүхдүүд эцэг, эхчүүдийг юу гэж дүгнэдэг, тэднээс юу хүсэж байгааг олж мэдсэн байна. Ингэснээр гарц гаргалгаа бий болгож, ойлголцолд хүрэх хамгийн зөв арга замаа олжээ. Хүүхдийг Ивээх Сангаас анги, бүлэг бүрийн Эцэг, эхийн зөвлөлийн дарга нарт сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг аж. 73 дугаар сургуулийн сэтгэл зүйч Р.Гэрэлчимэг хэлэхдээ

erator magnets. Parents and caregivers responded very positively, expressing their gratitude and wishing the team continued success.

Beyond the Light Board: Building Parenting Skills

Nyamdavaa expressed her satisfaction with the implementation of the project. She has also served as a project facilitator for the 'Safe Families' training, providing guidance and information to other parents. A total of 800 parents participated in these sessions. She noted that the training inspire parents to continue engaging in school-organized activities and programs.

“I am very glad that I learned many things, such as how to communicate with my child, how to listen, understand, and empathize with their thoughts and feelings, and how to express myself,” she emphasized.

She also gained valuable insights from the 'Let's Be Humane' campaign's 'Let's Inform and Be Informed' training. One of the most useful tools she learned about was the Parenting Balance Wheel . She introduced this test to 5th-grade students and their parents, helping them discover how well they know their children, how children perceive their parents, and what children expect from them. Through this process, they were able to develop solutions and identify the most effective ways to build mutual understanding.



“Б.Нямдаваа бидэнтэй байнга хамтарч, идэвхтэй ажилладаг Эцэг эхийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүдийн нэг юм. Ямар нэгэн сургалт зөвлөгөөнд маш идэвхтэй оролцож, бусад эцэг эхийг манлайлдаг. Түүний хандлага нь хүүхдийн төлөө, сайн ээж гэдэг нь мэдрэгддэг. Түүнээс хариуцлага, бүтээлч байдлыг олж хардаг” хэмээн ярилаа.

Сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн гишүүд тогтсон өдөр, цагт нийгмийн ажилтны өрөөнд цугларч уулзалдаж, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болсон байна. Аливаа ажилд манлайлал хамгийн чухал. Б.Нямдаваагийн манлайллаар Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа сэргэж, гишүүд нь идэвх, санаачилгатай ажиллаж байгаа юм. Тэдний явуулж байгаа үйл ажиллагаа сургууль, хүүхдүүдэд өгөөжтэй, үлдэцтэй болдог. Эцэг эхчүүд бие биедээ нөлөөлөх нь хамгийн чухал гэдгийг түүний охиныхоо ангид хэрэгжүүлсэн “Тэнцвэрийн хүрд” оношилгооноос харж болохоор. Бас сургуулийн орчинд багш, ажилчдаас илүү хүүхдээ хүргэж өгдөг ээжийн нүдээр асуудлыг олж харан бодит ажил болгож чаддаг юм. Сургуулийн ажилтнуудын хувьд эцэг эхчүүдийн санал, санаачилга маш чухал.

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан 2023 оноос “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр Улаанбаатар хотын Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг болон Говь-Алтай, Ховд аймгийн нийт 14 сургууль, 14 хамтарсан багт хэрэгжүүлж байна. Энэхүү төслөөр зорилтот газруудад сургуулийн багш ажилтнууд, эцэг эх/асран хамгаалагчид, сурагчид болон хамтарсан багуудыг хамруулан сургуульд суурилсан хүүхэд хамгааллын механизмыг хөгжүүлснээр үр дүнтэй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах хамтын ажиллагааны загвар бий болгох зорилготой юм.

Active Leadership in the Parents' Council

Save the Children regularly organizes trainings and advocacy activities for the heads of Parents' Councils in each class.

Gerelchimeg, the psychologist at School No. 73, shared, “*Nyamdavaa is one of our most active core members of the Parents' Council. She participates enthusiastically in every training and consultation, setting an example for other parents. Her dedication to children is evident—she is a truly caring mother. We always see responsibility and creativity in her.*”

The members of the school's Parents' Council meet regularly at the social worker's office on a set day and time to develop their activity plans. Leadership is essential in any work, and under Nyamdavaa's guidance, the Council functions proactively. The activities they carry out benefit both the school and its students. The ‘Balance Wheel’ test conducted in her daughter's class demonstrates the value of parent engagement. The test helps participants see the school environment through the eyes of a parent who brings her child to school—often noticing details that teachers and staff might overlook—and use those insights to take practical action. For school staff, the feedback and initiatives of parents are highly valuable.

Part of a Broader Initiative

Since 2023, Save the Children in Mongolia has been implementing the “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project in 14 schools and 14 Multi-Disciplinary Teams (MDTs) across Ulaanbaatar's Khan-Uul, Bayangol, Chingeltei, Sukhbaatar, and Bayanzurkh districts, as well as in Govi-Altai and Khovd provinces.

The goal is to develop a school-based child protection mechanism in the target areas by engaging teachers and school staff, parents and caregivers, students, and Multi-Disciplinary Teams, and to establish an effective collaborative model for preventing, detecting early, and responding to child protection issues. Through parent leaders like Nyamdavaa and initiatives like the Light Board project, Safe Families training, and Balance Wheel assessments, the project is creating spaces where both practical safety needs and emotional connections are addressed together.



ХҮҮХЭД БҮРИЙГ ХАМГААЛАХ СЭТГЭЛ

A COMMITMENT TO PROTECT EV- ERY CHILD

Нийслэлийн ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 3700 гаруй сурагчтай. Нийт 180 гаруй багш, ажилтантай. Тус сургуульд Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл амжилттай хэрэгжиж байна. Аливаа төсөлд багийн гишүүн бүрийн үүрэг оролцоо, идэвх санаачилга нэн чухал байдаг. Энэ удаа бид төслийн ажлын хэсгийн 11 гишүүний нэг, 2 дугаар сургуулийн нийгмийн ажилтан М.Анхцэцэгийг онцлон танилцуулъя.

-Би анх энэ сургуульд нийгмийн ажилтнаар ирэхэд “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжиж эхлээд хоёр сар өнгөрч байлаа. Миний хувьд энэ нь мэргэжлээрээ амжилттай ажиллах, ажлын гараагаа сайнаар эхлүүлэх том боломж байсан юм. Тиймдээ ч би төслийг олзуурхан хүлээж авсан. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн чиглүүлэх сургалтуудад сууж, маш ихийг сурч мэдсэн. Мэргэжлийн хүний хувьд төслөө сайн ойлгож, хурдан хүлээж авсан. Төслийн сургалтууд надад урагшлах хөшүүрэг болж, би хүүхэд, эцэг эх, багш, ажилтнуудтай ажиллах “тулгуур суурь”-тай болсон юм.

School No. 2 in Ulaanbaatar has over 3,700 students and more than 180 teachers and staff. The school has been successfully implementing Save the Children's 'Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia' project. In any project, the participation, initiative, and dedication of each team member are essential. M. Ankhtsetseg one of the 11 members of the project implementation unit, shares her experience as a social worker.

Finding My Purpose

When I first joined this school as a social worker, the project had already been running for two months. For me, it was a great opportunity to begin my career successfully and make a strong professional start. I enthusiastically welcomed the project.

Just a day after I started my job, I set a goal to become a project trainer and joined the child protection training. I attended the project training and learned a great deal. I quickly understood and embraced the project as a professional opportunity. The project's training became a springboard for my work, providing a solid foundation to engage effectively with children, parents, teachers,

Мэргэжил нэгтнүүд маань энэ тэндээс холбогдож, зөвлөгөө авмаар байна гэдэг. Миний сайных биш, төслийн үр дүнд чадавхжсаны нэг л жишээ юм. Ажилд орсны маргааш нь л сургагч багш болохоор зорьж, хүүхэд хамгааллын сургалтад суусан. Нийгмийн ажилтан хүн юу анхаарах ёстой, хүүхэд хамгааллыг хаанаас эхлэх вэ гэсэн мэргэжлийн чиг баримжааг маань бататгаж, утга агуулгаар баяжуулсанд төслийн нийт хамт олонд баярлаж талархсанаа илэрхийлмээр байна.

Би сургагч багш болж, сургуулийнхаа багш, ажилтнуудад мэдсэн сурсанаа дамжуулан түгээсэн. Багш нараас гадна ажилтнууд сургалтад сууснаар хүүхэд хамгаалалд ямар оролцоотойгоо мэдэж авсан. Манайхан, ялангуяа, анги удирдсан багш нар идэвхтэй хамрагдсан шүү. Сургуулийн Хүүхэд хамгааллын багийн гишүүд зөвлөгөө, мэдээлэл тогтмол авч байна. Эцэг эхчүүд ч сургалтыг минь талархан хүлээж авсан. Бид төслийн хүрээнд сургуулийн Эцэг эхийн зөвлөлтэй хамтран ажиллах гарын авлагатай болсон юм. Гарын авлагын дагуу ажил ундарсан. Сургуульд эцэг эхийн гурван дэд зөвлөл, түүнээс салбарласан зөвлөлүүд байгуулав. Тэдгээр зөвлөлөөр дамжуулан бүх эцэг эхэд мэдээлэл хүргэн, оролцоог нь нэмэгдүүлсэн. Миний хувьд сургуулийнхаа Эцэг эхийн зөвлөлтэй хамтран ажиллаж, 800 гаруй хүнд сургалтаа хүргэсэн байна. Мөн Эцэг эхийн зөвлөл бие даан хариуцаж, багш, ажилтан, сурагч, эцэг эх гэсэн гурван талт сургалт явуулсан. Сургуулийн төслийн ажлын хэсэг 11 гишүүнтэй. Дунд, ахлах, бага ангийн багш нар, сургалтын менежер, захирал, нийгмийн ажилтан гэсэн төлөөлөлтэй юм.

Хүүхэд хамгааллын мэдээллийн хэлхээ ажиллаж байна

Манай сургуульд хүүхэд хамгааллын мэдээллийн хэлхээ ажилладаг. Хүүхэд хамгааллын багийн гишүүд болон мэдээллийн хэлхээний батлагдсан гишүүдийн утасны дугаарыг бүх ангид байршуулсан.

and staff. I am grateful to the entire project team for strengthening my professional guidance on what a social worker should focus on and where to begin in child protection, enriching both the meaning and depth of my work. My colleagues often come to me for advice, which reflects not only my own efforts but also the capacity built through the project's outcomes.

Building Capacity Across the School Community

I became a project trainer and shared what I had learned with the teachers and staff at my school. Through the training, both teachers and staff gained a clearer understanding of their roles in child protection. Class teachers, in particular, actively participated. Members of the School's Child Protection Team now regularly receive advice and information, and parents have welcomed and appreciated the training sessions.

Within the project, we developed a handbook to guide collaboration with the school's Parents' Council and began implementing it. The school established three sub-councils under the Parents' Council, along with additional branch councils, through which information was shared with all parents, increasing their engagement. I worked with the school's Parents' Council to deliver training to over 800 people. Additionally, the Parents' Council independently conducted training for all three groups, including teachers, staff, students, and parents.

The school's project implementation unit consists of 11 members, including teachers from primary, secondary, and high school classes, the training manager, the principal, and me, as the social worker.

Implementing the Child Protection Workflow Chart

One of the most effective tools we introduced was the workflow chart for Child Protection services. The phone numbers of the members of the Child Protection Teams, as well as the approved focal points listed in the workflow chart, are dis-

Мөн “Хүүхдийн тусламжийн 108 утсанд мэдээлээрэй” гэсэн санамж ч бий. Ингэснээр сургуулийн орчинд гарсан хүүхдийн гомдол, санал, хүүхдийн эрхийн зөрчлийн мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай хүлээн авч шийдвэрлэх боломж бүрдсэн. Мэдээллийг санал хүсэлтийн хайрцагар, биечлэн уулзаж, эсвэл цахимаар, утсаар, аль ч хэлбэрээр авч болдог. Эрхийн зөрчилтэй холбоотой тухайн мэдээллийг бүртгэж, хариу арга хэмжээ авч ажиллаж чаддаг болсон.

Хүүхэд хамгааллын багт сургуулийн захирал, сургалтын менежер, эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, дунд, ахлах, бага ангийн багш нарын төлөөлөл багтдаг юм. Мэдээллийн хэлхээг сургуулийн бүх эцэг эх, хүүхдүүдэд анги танхимаар, цахим хэлбэрээр сурталчлан танилцуулсан. Мэдээлэл ч сайн ирж байгаа. Хүүхэд хамгааллын багийн гишүүдэд биечлэн хандахаас илүү мэдээллийн хэлхээ дээрх утасны дугаарт, мессеж хэлбэрээр гомдол санал, зөрчлийн мэдээлэл түлхүү ирж байна. Сургуулийн орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийн мэдээллийн дийлэнх хувь нь багш сурагчдын харилцаа, үе тэнгийн дээрэлхэлт, багш, эцэг эхийн үл ойлголцлын шинжтэй байдаг. Анги удирдсан багш сурагчидтайгаа хэрхэн харилцах талаар зөвлөгөө хүссэн, эсвэл манай ангид сургалт явуулж өгөөч гэсэн хүсэлт ч мессежээр ирэх нь бий.

Би ажилд ороод хүүхдийн оролцооны 7 төрлийн сайн дурын байгууллага байгуулсан. Сургуулийн орчин дахь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг идэвхжүүлэх ач холбогдолтой юм. Хүүхдээс хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа үр дүнтэй байна. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн шугамаар “Хүүхдийн эрхийн зөрчил гарвал хэнд, хаана, хэрхэн хандах вэ?” сэдвээр үе тэнгийн 40 сургагч багш бэлдсэн. “Би найзаа дэмжинэ” сургалтын хүүхдүүд нэмэгдээд манай сургууль үе тэнгийн 165 сургагч багштай боллоо. Хүүхэд хүүхдэдээ мэдээлэл хүргэж, үзэл бодол, дуу хоолойгоо

played in every classroom. There is also a notice encouraging students to “Report to the Children’s Helpline 108.”

This system allows us to receive and respond promptly to complaints, suggestions, or violations of children’s rights that occur within the school. Reports can be submitted through suggestion boxes, in-person meetings, online, or by phone—any method is acceptable. We can now register all reports of rights violations and take timely, appropriate action to address them.

The school’s child protection team includes the principal, training manager, doctor, psychologist, social worker, and teacher representatives from primary, secondary, and high school classes. We have introduced the workflow chart to all parents and students, both in classrooms and online, ensuring that everyone understands how to report concerns and that information flows efficiently.

Rather than approaching team members in person, most complaints, suggestions, and reports are sent as text messages to the numbers listed in the workflow chart. The majority of reports relate to teacher-student interactions, peer bullying, or misunderstandings between teachers and parents.

Class teachers sometimes contact us via text, asking for advice on how to communicate with students or for us to conduct training for their classes.

Empowering Children Through Participation

After I started working, I established seven voluntary organizations to promote children’s participation, which has been key to increasing engagement in the school environment. Activities led by children for children have proven to be highly effective.

Through the “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project, we trained 40 peer educators on the topic “Whom to Address in Case of Violence Against Chil-

сонсох нь маш чухал. Бид хүүхдийн оролцоог хангаснаар зогсох биш, тэдний гаргасан санал, санаачилгыг ажил хэрэг болгон, хамтран шийдвэрлэх нь жинхэнэ бодит оролцоо гэж үздэг. Тиймдээ ч Хүүхдийг Ивээх Сангийн төслийн хүрээнд хүүхдүүдээрээ төсөл бичүүлж, хамтран амжилттай хэрэгжүүлсэн.

Охидын өрөөтэй болов

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд 2 дугаар сургуулийн эцэг, эхчүүд хоёр төсөл хэрэгжүүлсэн. Үүний нэг нь “Охидын өрөө” төсөл юм. “Биеийн тамирын хичээлд орохын өмнө охидын хувцас сольдог өрөөний орчин нөхцөл муу байна” гэсэн 400 гаруй санал хүсэлт сургуульд ирсэн. Тиймээс 2025 оны 6 дугаар сард эцэг эхчүүд ярилцаж, зөвлөлдөөд тус асуудлыг шийдвэрлэх зорилгоор төсөл бичсэн юм. Улмаар “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс санхүүжилт авч, Эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн төлөөлөл, биеийн тамирын багш нартай хамтран, охидын өрөөг тохижуулсан. Энэ бол охидын эрх ашгийг хамгаалсан бодит төсөл байлаа. Охидын өрөөнд анхан шатны тусламжийн болон охидын ариун цэврийн хэрэгслийн хайрцаг байршуулсан. Суух сандал хийж, доор нь гутлын тавиур тавьсан.

Баярлалаа багш аа!...

Би нэг жишээ дурдмаар байна. Архины хамааралтай, өрх толгойлсон эмэгтэй байсан. Хэрэв тэр ээж архиа болихгүй бол хүүхдийн эрх ашиг хохирно. Тэгвэл хүүхдийг нь хамгаалах байранд өгчихье гэхээр ээжийнх нь эрх яригдана. Бид тухайн ээжтэй ойлголцож, эмчлүүлэх гэтэл нийгмийн даатгал нь төлөгдөөгүй байсан. Тухайн үед төсөвгүй байлаа. Менежер, Хүүхэд хамгааллын багийн гишүүдтэйгээ ярилцаад, бүгдээрээ мөнгө нийлүүлж нийгмийн даатгалыг нь хувааж төлсөн. Тэр ээжийг эмнэлэгт хэвтүүлж, гурван удаа давтан эмчилгээнд хамруулсан. Одоо тэр ээж архианаас бүрэн гарч, нөхөртэйгөө эвлэрч, хүүхэд нь хичээлдээ дуртай болж,

dren”. With the “I Support My Friends” program, the number of peer educators at our school has grown to 165 over the last three years. It is very important for children to share information with each other and express their opinions and voices.

We believe that ensuring child participation is not enough; real participation occurs when their suggestions and initiatives are acted upon and decisions are made collaboratively. Within the Save the Children project framework, we guided children to develop their own project proposals and successfully implemented them together.

A Girls' Room Was Renovated

One initiative I was proud to support came directly from student feedback. Over 400 suggestions and complaints were submitted to the school, highlighting that the changing room for girls before physical education classes was in poor condition. In June 2025, parents discussed and developed a project proposal to address this issue. The “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project provided funding, and representatives of the Parents’ Council worked together with the physical education teachers to renovate the girls’ changing room. This successful micro project effectively protected the rights of girls.

In the renovated girls’ room, we placed a box with basic first aid supplies and girls’ hygiene products. We also installed seating and added shoe racks underneath the seats.

Real Stories of Impact Thank you, Teacher!...

Let me share one example that demonstrates the depth of support we provided. A single mother struggling with alcohol dependency, if she did not stop drinking, her child’s rights would have been at risk, while placing the child in protective care would have affected the mother’s rights. We discussed the situation with her and agreed to help her organise treatment, but her social insurance had not been paid, and at that time, no budget was available for this assistance.

сурлагад нь ахиц гарч байна. Аав, ээж, хүүхэд гурвуулаа хамт хүрч ирээд “Багш аа, баярлалаа. Та бүхэн байгаагүй бол бид өдийд ингэж сайн сайхан амьдарч чадахгүй байсан шүү” хэмээн талархсан. Чин сэтгэлийн ийм үг сонсох үнэхээр сайхан шүү.

Өөр нэг жишээ байна. Гэр бүл салаад аав, ээж нь өөр өөр хүнтэй суугаад явчихсан, эрх нь зөрчигдсөн дөрвөн хүүхэд байлаа. Том ах нь хичээлийн бус цагаар ажил хийж, гурван дүүгээ асарна. Ингээд хуулийн хүрээнд орчин нөхцөлийг нь сайжруулах дэмжлэг өгч мөн л сургуулийн Хүүхэд хамгааллын багаараа кейс нээн ажилласан. Одоо нөгөө хүүхдүүд хэнээс ч хараат бус сайхан амьдарч байна. Том нь оюутан болсон. “Миний гурван дүүг өдөр бүр харж, хандаж байсан багшдаа баярлалаа” гэдэг.

After consulting with the manager and members of the Child Protection Team, we all contributed money together to cover her social insurance. She was admitted to the hospital and underwent three rounds of treatment. Now, she has fully recovered from alcohol dependency, reconciled with her husband, and her child enjoys school and has shown improvement in academics.

The father, mother, and child all came together and said, “Teacher, thank you. If it weren’t for you, we wouldn’t be living this well today.” Hearing such sincere words from them was truly heartwarming.

A Family Reunited

I have another example that shows the power of sustained support. There was a separated family, with the father and mother living with different partners, and four children whose rights were being violated. The eldest brother worked after school and took care of his three younger siblings.

We opened a case through the school’s Child Protection Team and provided support to improve their living conditions within the framework of the law. Now, the younger children are well supported. The eldest has become a university student. He said, “*I am grateful to the teacher who took care of and looked after my three younger siblings every day.*”

Looking Forward

These experiences have reinforced my belief that child protection is not just a policy—it’s a commitment that requires the dedication of every member of the school community. Through collaboration with parents, teachers, students, and staff, we have created a safe environment where every child’s voice is heard and every concern is addressed. The project has not only transformed our school but has also transformed me as a professional, giving me the tools and confidence to make a real difference in children’s lives.



ЭЭРЭГ ХАНДЛАГА, ХҮМҮҮЖИЛ БИЙ БОЛЖЭЭ

POSITIVE ATTITUDES AND BEHAVIORS

“Нийгмийн ажилтан”-гүй байсан сургууль хоёр ч орон тоо шинээр батлав-

Нийслэлийн ерөнхий боловсролын 17 дугаар сургуулийн бага ангийн багш Рэнчиндоржийн Сарангэрэл Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн сургагч багш нарын нэг юм. 15 дахь жилдээ багшилж байгаа тэрээр хоёр дахь жилдээ төслийн багийн гишүүн, сургагч багшаар ажиллаж байна.

Р.Сарангэрэл багштай 4а ангийн сурагчид ангийн дүрмээ дараах байдлаар гаргажээ. Чанга дуугарахгүй байх, цаг баримтлах, хогийг зориулалтын саванд хаях гэхчлэн энгийн хэрнээ зайлшгүй шаардлагатай үйлдлийг тусган, зөв дадал хэвшлийг бий болгожээ. Ангийн дүрэм нь жил жилд сайжран өөрчлөгдөх боломжтой бөгөөд энэ жилийн тухайд ангиараа цээж бичиг алдаагүй бичихийг зорьжээ. “Одоогоор ангийн нийт хүүхдийн 80 орчим хувь нь ямар ч алдаагүй бичиж байна. Цаашид энэ үзүүлэлт улам нэмэгдэнэ” гэж Р.Сарангэрэл багш итгэлтэй

Sarangerel, a primary school teacher at General Education School No.17, is a trainer for the project ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’. Currently in her 15th year of teaching, she serves as a project implementation unit member and trainer to transform how her school approaches student wellbeing and child protection..

Creating a Positive Classroom Environment

Sarangerel Grade 4A students created their classroom rules together, establishing simple but essential behaviors such as speaking quietly, being punctual, and throwing trash in designated bins practices that help build positive habits. These rules are reviewed and updated each year to reflect the students’ evolving needs.

This year, the class set a shared goal: to write their dictations without mistakes. “At the moment, about 80 percent of the students can write without any errors. I’m confident that this number will continue to grow,” teacher Sarangerel said proudly. This achievement reflects not just academic progress, but the supportive, collabo-

өгүүллээ.

17 дугаар сургууль төслийн хүрээнд “Мэдээллийн хэлхээ” бий болгосон нь хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрт таслан зогсооход чухал хувь нэмэртэй болжээ. Сургуулийн орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, мэдээллийг хүлээн авах зураглалыг хүүхдүүд төдийгүй эцэг, эх, асран хамгаалагчид ашиглах бүрэн боломжтой юм. Сургууль дээр хүүхдийн эрхтэй холбоотой зөрчил гарсан тохиолдолд уг хэлхээгээр дамжуулан зохих албан тушаалтан, захирал, багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид мэдээлэл цаг алдалгүй хүрэх ажээ. Тодруулбал, асуудлыг хэн, яаж шийдэх юм, хамгааллын үйл ажиллагааг ямар дэс дарааллаар явуулах вэ гэдгийг Мэдээллийн хэлхээнээс мэдэж авах юм.

-Хүүхдийг Ивээх Сангийн төслийн үр дүнд багш, сурагч, эцэг эх, хэн хэнд нь эерэг хандлага, хүмүүжил бий болж байна. Миний хувьд төсөл хэрэгжихээс өмнө байсан хандлага эрс өөрчлөгдсөн. Мэдэхгүйгээ мэдэж, үр чадварын хувьд өссөн. Багшийн, тэр тусам бага ангийн багшийн ажил их шүү дээ. Төсөл хэрэгжих гэж байна, сургагч багшаар бэлтгэгдэнэ гэхээр анхандаа дурамжхан л байлаа. “Өмнөх ажлаа барахгүй байхад бас юу вэ...” гэж төвөгшөөсөн. Харин одоо тэр үеэ санахаар “ичих” шиг болдог. Ер нь энэ төсөл хэрэгжихээс өмнө яаж болж байсан юм бэ гэж боддог гэж Р.Сарангэрэл багш ярив. Тэрээр, сургагч багшийн хувиар сурагчид, эцэг эх, багш нарт сургалтаар олж авсан мэдлэгээ түгээн дэлгэрүүлжээ. “Эерэг хандлагыг цаашид хадгалан авч явна гэдэг амаргүй. Гэсэн ч илүү их үр дүнд хүрч чадна” гэдэгт Р.Сарангэрэл багш итгэлтэй байна.

Төслийн хүрээнд “Би найзаа дэмжинэ” хөтөлбөр тус сургуульд амжилттай хэрэгжжээ. Хүүхдүүд бэрхшээл тулгарсан нэгийгээ сэтгэл санаагаар дэмждэг, хамтдаа санаа тавьж, ярилцаж, сэтгэлийг нь засдаг болжээ. Төслийн сургагч багш Р.Сарангэрэл нар уг хөтөлбөрийн хүрээнд зохих сургалт

rative environment the class has built together.

A Journey of Professional Growth

When Sarangerel first heard she would be trained as a project trainer she had mixed feeling,” I was reluctant. I thought, ‘I can hardly handle my current workload, how am I supposed to take on more?’ I even felt bothered by the idea. But now, when I think back to that moment, I almost feel embarrassed. I wonder how I ever managed before this project,” she reflected.

The training transformed her approach to teaching. “ For me personally, my mindset has completely changed compared to before the project. I’ve learned to recognize what I didn’t know, and I’ve grown professionally. Being a teacher, especially a primary school teacher, there is so much to do,” she reflected.

As trainer, Sarangerel has shared the knowledge she gained through training with students, parents, and fellow teachers. She is confident that, although maintaining positive attitudes over time is not easy, “with commitment, it is possible to achieve even greater results.”

Implementing Student Support Programs

Through the project, Sarangerel and her colleagues have introduced two important initiatives at School No.17.

The ‘I Support My Friends’ program was successfully implemented and students have learned to emotionally support classmates facing difficulties, to look out for one another, talk things through, and help lift each other’s spirits. Sarangerel and her colleagues conducted training to guide children on teamwork, active listening, and how to support their peers. “The program was practical and relatable, and it worked well for both children and parents,” she explained.

Currently, the ‘Let’s Be Human’ campaign is being implemented at the school. “Parents across the school have warmly welcomed this campaign. Today, being humane and compassionate is more important than anything. The campaign plays an important role in shaping children’s character

явуулж, багаар ажиллах, бусдыгаа сонсч, дэмжих талаар зөвлөн тусалсан юм.

Тэгвэл эдүгээ “Хүнлэг байя” аян тус сургуульд өрнөж байна. “Сургуулийн нийт эцэг эхчүүд энэ аянг талархалтай хүлээж авсан. Өнөөгийн нийгэмд хүнлэг, энэрэнгүй байх нь юунаас ч илүү чухал юм. “Би найзаа дэмжинэ” хөтөлбөр хүүхэд, эцэг эхэд хүрсэн, хэрэгжихэд боломжтой, амьдралд ойр байсан. Тэгвэл “Хүнлэг байя” аян маань ч адилхан үр нөлөөтэй байлаа. Хүүхдийг багаас нь төлөвшүүлэх ач холбогдолтой” гэж Р.Сарангэрэл багш ярилаа. Энэ хамт олон сургагч багш нараар дамжуулан төслийн үр шимийг хүртэж байна.

17 дугаар сургууль нийгмийн ажилтангүй байжээ. Харин одоо хоёр ч орон тоо шинээр бий болжээ. Нийгмийн ажилтнууд хүүхэд хамгааллын үйлчилгээг чанартай гүйцэтгэж байгаа нь төслийн үр дүн юм. Тус сургуульд ажиллаж буй Хүүхэд хамгааллын баг эрсдэлийн үнэлгээг жил бүр хийж, зохих арга хэмжээ авдаг байна. Тус багийн гишүүд 14 хоногт нэг удаа, шаардлагатай нөхцөлд хугацаа харгалзахгүй хуралддаг. Мөн хорооны хүүхэд хамгааллын Хамтарсан багтай хамтран ажлын төлөвлөгөө гарган үр бүтээлтэй хамтран ажиллаж байна.

from an early age,” teacher Sarangerel noted.

School-Wide Child Protection Systems

The project has created lasting change. The school introduced a workflow chart that has become an important tool for preventing and responding early to violations of children's rights. This pathway provides a clear illustration of how child protection services are accessed and how concerns are reported within the school. It is easily accessible not only to students but also to parents and caregivers.

If a child protection concern arises at the school, the flow chart ensures that information quickly reaches the appropriate staff such as the principal, teachers, social worker, or school psychologist without delay. In essence, the pathway clearly shows who is responsible, how the issue will be handled, and the step-by-step process for ensuring the child's safety.

The school's Child Protection Team conducts annual risk assessments and takes appropriate actions based on the findings. The team meets every two weeks, and more frequently when needed. They also work closely with the district-level Multi-Disciplinary Team, developing joint work plans and collaborating effectively.

School No.17 previously had no social workers. Now, thanks to the project, two new positions have been created. The social workers are delivering quality child protection services. It is an important outcome of the project.

A Ripple of Change

As a result of the project, teachers, students, and parents have begun to develop more positive attitudes and behaviors. Through trainers like Sarangerel, the entire school community continues to benefit from the project's initiatives, creating a safer, more supportive environment where every child can thrive.

Through trainers, the entire school community continues to benefit from the project's initiatives.

ТЭГШ ОРОЛЦОО, ХАМТЫН АМЖИЛТУУД

EQUAL PARTICIPATION, SHARED SUCCESSES

Нийслэлийн 50 дугаар сургуулийн босго давахуй өөдөөс том дэлгэц нүдэнд содон тусна. Тэр дэлгэцээр хүүхэд хамгаалалтай холбоотой видео, рийл, постерууд ээлжлэн хөвөрнө. Эдгээр контент нь тус сургуульд хэрэгжиж буй Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн “Хүнлэг байя” нөлөөллийн аяны хүрээнд бүтээгдсэн юм. Бидний үүлзсан нийгмийн ажилтан Б.Мөнхцэцэг төслийн ажлын хэсгийн анхны гишүүдийн нэг, сургагч багш бөгөөд сургууль дахь төслийн ажлын хэсгийн ахлагчаар ажилладаг. Б.Мөнхцэцэг мэргэжлээрээ 15, үүнээс 50 дугаар сургуульд дөрөв дэх жилдээ ажиллаж байгаа юм. Тэрээр, “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд гарсан ололт, амжилтаа бидэнтэй хуваалцлаа.

Хандлага өөрчлөгдөв

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн 50 дугаар сургуулийн ажлын хэсэг 10 гишүүнтэй. Гишүүд нь сургагч багш болсны дараа бусад багш нар, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, сурагчдад сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулжээ.

–Сургалт, нөлөөллийн ажлын үр дүнд багш нар, ажилтнуудын хүүхэд хамгааллын мэдлэг нэмэгдэж, хандлага өөрчлөгдсөн. Урьд нь ажилтнууд “Надад хүүхэд хамгааллын ажил хамаагүй” гэсэн ойлголттой байсан бол одоо “Бид ч хүүхэд хамгаалах үүрэг, оролцоотой юм байна” гэдгээ ухаарсан гэж нийгмийн ажилтан Б.Мөнхцэцэг ярьж байна. Сургуулийн хүүхэд хамгааллын багийнхан сурсан мэдсэнээ

As you approach School No. 50 in Ulaanbaatar, a large screen immediately catches your eye. Videos, reels, and posters related to child protection are displayed in rotation. These materials were created as part of the “Let’s Be Humane” advocacy campaign under the Save the Children project, ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’, implemented at the school.

The social worker we met, B. Munkhtsetseg, was one of the first members of the project implementation unit (PIU), a project trainer, and now serves as the head of the school’s PIU. With 15 years of professional experience—four of which have been at School No. 50—Munkhtsetseg shared the achievements and successes achieved through the project.

Changing Attitudes

The PIU consists of 10 members. After becoming project trainers, these members gradually organized training for other teachers, staff, parents, caregivers, and students.

As a result of the training and advocacy activities, teachers and staff not only increased their knowledge of child protection but also shifted their attitudes. “Previously, some staff thought, ‘Child protection is not my responsibility.’ Now, they understand, ‘We also have a role and responsibility in protecting children,’” said Munkhtsetseg.

“The school’s child protection team shares what they have learned, created short videos, and regularly posts them on the school’s website. The project also provided all the essential equipment needed for online conferences, trainings, and meetings,

хуваалцаж, богино хэмжээний видео бүтээж, сургуулийн цахим хаягаар тогтмол түгээдэг болжээ. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс цахим хурал, сургалт, уулзалт зохион байгуулахад нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг иж бүрнээр нь суурилуулж өгсөн нь ач холбогдолтой байв. Эдгээр төхөөрөмжийг багш нар төдийгүй хүүхдүүд ч ашигладаг байна.

Урилгатай сургалт

Хотын амьдралын хэмнэлд эцэг, эхчүүд завгүй байх нь олонтаа. “Сайн эцэг эх” сургалт хоёр өдөр буюу 16 цаг үргэлжилдэг. Тиймээс анхны сургалтын өмнө эцэг, эх, асран хамгаалагчдын ажилладаг албан байгууллагууд руу “Хүүхдийн сайн сайхны төлөө хамтарч ажиллана уу” гэсэн утга бүхий захидал явуулж, чөлөө хүсчээ. Энэ нь ч үр дүнтэй болж, 56 эцэг эх, асран хамгаалагч сургалтаа бүрэн дүүргэв. Үүнээс хойш сургалтын үйл ажиллагаа жигдэрч, оролцоо ч нэмэгдсэн байна. Эхний удаа оролцогчдын олонх нь ээжүүд байсан бол дараа дараагийн сургалтад аавуудын тоо нэмэгджээ. Улмаар тухайн жилдээ 800 гаруй эцэг эхийг “Сайн эцэг эх” сургалтад хамруулан амжилттай ажиллажээ. Сургуулийн Эцэг, эхийн зөвлөлийн идэвх оролцоо нэмэгдэж, тэд хамтдаа хоёр удаа төсөл бичиж, хэрэгжүүлсэн байна. Энэ жил Эцэг, эхчүүд хоёр дахь төслөө амжилттай хэрэгжүүлж, нөлөөллийн ажлаа 500 эцэг эхэд хүргэжээ. Мөн эцэг эхийн зөвлөлөөс жилийн төлөвлөгөө гаргаж, тогтмол уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах болжээ.

Төсөл хэрэгжээгүй бусад сургуульд ч мэдлэг түгээв

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөлд Улаанбаатар хотын Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг болон Говь-Алтай, Ховд аймгийн нийт 14 сургууль, 14 хамтарсан баг хамрагдаж байна. 50 дугаар сургуулийн



which has been particularly valuable. Both teachers and students use this equipment regularly,” added Munkhtsetseg.

Engaging Parents Through Targeted Training

In the busy pace of city life, parents are often occupied with work. The “Safe Families” training is implemented over 16 hours. Before the first session, letters were sent to parents’ workplaces requesting time off to attend the training, with the message: “Let’s Work Together for the Well-being of Children.” This approach proved effective, and 56 caregivers completed the training.

Since then, the training program has become well-organized, and participation has steadily increased. While the majority of participants were mothers in the first session, more fathers joined in subsequent trainings. By the end of that year, over 800 parents had successfully participated in the “Safe Families” training.

The school’s Parents’ Council also became more active, jointly developed and implemented two projects. This year, parents successfully carried

сургагч багш нар төсөлд хамрагдаагүй нийслэлийн 39 дүгээр сургуулийн 40 эцэг эх, асран хамгаалагчид “Сайн эцэг эх” сургалтаа зохион байгуулж, мэдлэгээ хуваалцаж, түгээн дэлгэрүүлсэн байна. Уг сургалтад оролцсон хүмүүс ч талархалтайгаар хүлээн авч, “Их хэрэгцээтэй сургалт байна. Дахин явуулж өгөөч” гэж хүсэж байжээ. Нийслэлийн боловсролын газар, Чингэлтэй дүүргийн ЗДТГ-аас 50 дугаар сургуулийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаатай танилцсан аж. Тус сургууль өнгөрсөн 5 дугаар сарын 2-нд 2024-2025 оны хичээлийн жилийн сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны “Бид хамтдаа” хаалтын арга хэмжээгээ “Хайрхан хөгжлийн төв”-д зохиож, танхимын бус сургалтын 10 өртөө байгуулжээ. “Сургуультай хамтран Хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн ажлын хэсгийнхэн эдгээр өртөөний нэгээр жишээ болгож үйл ажиллагаагаа танилцуулсан байна. Эцэг эхчүүд тэдний өртөөгөөр олноороо зочилж, төслийн үр дүн, хэрэгжилтийн талаар мэдээлэл авч, санал боддоо солилцсон байна.

Сурагчдаа идэвхжүүлж, оролцоог нэмэгдүүллээ

Нийслэлийн 50 дугаар сургууль 2668 сурагчтай. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд 125 хүүхэд үе тэнгийн сургагч болжээ. Хүүхдүүдийг өөрсдийнх нь саналаар сонгосон бөгөөд 9-11 дүгээр ангийнхан юм. Сургагч хүүхдүүд үе тэнгийнхэн болон дүү нартаа “Би найзаа дэмжинэ” сургалт явуулж, сургуулийнхаа бүх хүүхдэд мэдлэгээ дамжуулан түгээсэн байна. Нийгмийн ажилтан Б.Мөнхцэцэг “Хүүхэд хүүхдүүддээ заахад их сайн сурдаг. Хүүхдүүд чөлөөтэй, нээлттэй байж чаддаг. Тэдний оролцоонд тулгуурласнаар үр дүн их гарлаа. Мэдээж, чиглүүлэгч багш сургалтын үеэр хамт байж, арга зүйгээр дэмжиж, зарим үед зөвлөж, тусалдаг” хэмээн тайлбарлав. Төсөл хэрэгжсэнээр хүүхдүүдийн идэвх оролцоо нэмэгдэж, зорилго, чиглэлтэй болжээ. Үүний

out their second project, reaching 500 parents through advocacy activities. The council has developed an annual plan, organized regular meetings, and established ongoing collaboration.

Sharing Knowledge with Schools not involved in the Project

The project currently involves 14 schools and 14 Multi-disciplinary teams from Ulaanbaatar's Khan-Uul, Bayangol, Chingeltei, Sukhbaatar, and Bayanzurkh districts, as well as Gobi-Altai and Khovd provinces. Trainers from School No. 50 organized the “Safe Families” training for 40 parents and caregivers from School No. 39, which had not participated in the project, sharing their knowledge and experiences. The training was warmly received, with participants noting its importance and requesting that it be offered again.

The Metropolitan Education Department of Ulaanbaatar and the Chingeltei District Governor's Office visited School No. 50 to observe the work of the Child Protection Team. On May 2, 2024, the school hosted the “We Are Together” closing event for the 2024–2025 academic year at the Khairkhan Development Center, featuring 10 interactive non-classroom learning stations. Members of the PIU used one of the stations to showcase their activities. Parents attended in large numbers, explored the stations, learned about the project's outcomes and implementation, and shared feedback and ideas.

Increasing Student Engagement and Participation

School No. 50 in Ulaanbaatar serves 2,668 students. As part of the project, 125 students in grades 9–11 voluntarily became peer educators. These students provided training to their classmates and younger students under the “I Support My Friends” program, sharing knowledge and promoting child protection across the school.

Munkhtsetseg explained, “Children learn very well when they teach other children. They feel free and open, and the results are significant because the activities are based on their active participation. The

нэг жишээ бол хүүхдүүд сайн дураараа нэгдэн, сургууль дээрээ 10 клуб байгуулжээ. Үе тэнгийн сургагчдаас 10 сурагч нэгдэн баг болж, сэтгэл зүйн анхны тусламжийн хөлөгт тоглоомын төсөл хэрэгжүүлсэн байна.

Ийнхүү “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл нийслэлийн 50 дугаар сургуульд амжилттай хэрэгжиж байна. Энэхүү амжилтад нийгмийн ажилтан Б.Мөнхцэцэгийн идэвх санаачилга, оролцоо их юм. Сургуулийг нэгэн цогц юм гэвэл энэ нь сурагч, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч гэсэн гурван бүрэлдэхүүнтэй билээ. Талууд бүгдээрээ хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх дээр нэгдэх ёстой. Нийслэлийн 50 дугаар сургуулийнхан эдгээр бүлгүүдээ төсөлд тэгш оролцуулж, үр дүн ч гарч байна.

project facilitator is always present during the training to provide guidance, methodological support, and assistance when needed.”

The project has notably increased student engagement while giving them clear goals and direction. For example, students voluntarily formed 10 school clubs, and a team of 10 peer educators implemented a board game project focused on psychological first aid.

The success of the project at School No. 50 is largely due to the initiative and active involvement of B. Munkhtsetseg. The school functions as a complete system—composed of students, teachers, staff, parents, and caregivers—and all these groups must work together to protect children and uphold their rights. School No. 50 ensures equal participation of these groups in the project, resulting in meaningful outcomes.



“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн 50 дугаар сургуулийн ажлын хэсгийн гишүүд

Members of Project Implementation Unit of “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” at school No.50.



ТУУШТАЙ БАЙДАЛ, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛИЙН ЭЗЭН БАГШ

PERSISTENCE AND DEDICATION OF A COMMITTED TEACHER

Хүүхэд бүрийг хамгаалж, хөгжүүлэх нь багш бидний үүрэг

“Би “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөлд хамрагдахаас өмнө сурагч бүрийг хэрхэн хамгаалах, хөгжүүлэх талаар ойлголт багатай байлаа. Төсөлд хамрагдсанаар энэ талын мэдлэгээ нэмэгдүүлж, үр чадвараа сайжруулсан. Бусад багш нартайгаа зөвлөлдөж, үр дүнтэй хамтран ажиллаж байна” хэмээн нийслэлийн Баянгол дүүргийн 51 дүгээр сургуулийн түүх, нийгэм судлалын багш О.Ууганцэцэг ярьж байна.

“Анх 6 дугаар анги хариуцан ажиллахдаа арга барилаа нэг л сайн олохгүй байв.

Харин одоо сурагчдынхаа сурах сонирхол, идэвх оролцоог нэмэгдүүлэхийн тулд хичээлдээ оролцооны олон аргыг ашигладаг болсон. “Сургуультай хамтран хүүхэд

Protecting and Nurturing Every Child is a Teacher's Responsibility

Uugantsetseg, a history and social studies teacher at School No. 51 in Bayangol District, Ulaanbaatar, represents the dedicated young educators who are transforming Mongolia's classrooms. Her journey with the 'Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia' project has not only enhanced her professional skills but also deepened her understanding of how to protect and support each student's holistic development.

A Foundation Built Through Training

“Before joining the project, my understanding of how to best protect and support each student's was still developing,” teacher Uugantsetseg reflects. “Through the project, I gained valuable knowledge and enhanced my professional skills. I now collabo-

хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт бүр үр өгөөжтэй байлаа. Тэр дундаа “Сайн эцэг эх”, “Сурагчдын сурч, хөгжих үйл явцыг эрхэд суурилсан хандлагаар дэмжих нь”, “Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах арга зүй”, “Би найзаа дэмжинэ”, “Хүүхдийн эрхийн зөрчил гарвал хэнд, хаана, хэрхэн хандах вэ?” сэдэвт сургалтууд илүү үр өгөөжтэй байсан. Би эдгээр сургалтаас эцэг эх, сурагчидтай ажиллах арга барилаа олж авсан юм. Ангийн эцэг, эхчүүд маань надад талархлын захидал өгсөн. “Хүүхдүүд маань өдөр бүр хөгжиж байгааг бид харж байна. Танд маш их баярлалаа” гэсэн чин сэтгэлийн үгтэй талархлын энэ захидал ажиллах эрч хүч, урам зориг өгсөн” хэмээн О.Ууганцэцэг багш өгүүлэв.

Даяаршиж буй өнөөгийн нийгэмд монгол хүн бүр ёс уламжлалаа дээдэлж, суралцах нь чухал. Хүүхдийн хөгжил хамтын ажиллагааны хүрээнд явагддаг. Тиймээс О.Ууганцэцэг багш санаачилгаараа “Бяцхан бизнес эрхлэгч” төслийг ангидаа хоёр үе шаттай хэрэгжүүлжээ. Тус ангийн сурагчид 2023 оны 3 дугаар сараас ангидаа үйдвэрлэл явуулж, дээс томж, тугалын хүзүүвч үйлдвэрлэж, өвөлжилт хүндэрсэн Төв аймгийн Батсүмбэр сумын малчдад хандивласан байна. Мөн нийт 150 ширхэг тугалын хүзүүвч хийж, нэг бүрийг нь малчдад 5000-10000 төгрөгөөр худалджээ. Борлуулалтаас олсон 1 сая гаруй төгрөгийн 20 хувиар “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд сургуулийнхаа хашаанд нарс, гацуур мод худалдан авч тарьж ургуулсан байна. Түүнээс гадна хүүхдүүд ашгийнхаа тодорхой хувиар ангидаа номын сан байгуулжээ. Үүний үр дүнд сурагчдын ном унших сонирхол нэмэгджээ.

51 дүгээр сургуулийн нийгмийн ухааны багш М.Нямдэлгэр хэлэхдээ, “О.Ууганцэцэг сургуулийнхаа хичээл зүтгэлтэй, тууштай залуу багш нарын төлөөлөл юм. Анх ээлжит хичээлээ хэрхэн төлөвлөх, сурагч бүрээс ямар чиглүүлэх асуултууд асуух талаар

rate effectively with other teachers, consulting and working together to achieve better results,”

When she first started teaching sixth grade, she often struggled to find effective teaching methods. The comprehensive training provided through the Save the Children project became a turning point in her career. Sessions on ‘Safe Families,’ ‘Promoting a Rights-Based Approach in Students,’ ‘Learning and Development Processes,’ ‘Prevention, Early Identification, and Response to Violence Against Children,’ ‘I Support My Friends,’ and ‘To Whom, Where, and How to Report Child Rights Violations’ were especially useful. equipped her with practical tools to work more effectively with both parents and students .

“I now incorporate a range of participatory techniques in my lessons to boost students’ interest and engagement,” she explains. Every training organized through the project has been invaluable.”

The impact on her students quickly became evident . The parents of her class sent her a letter of appreciation, saying, “We can see our children growing every day. Thank you so much.” This heartfelt message gave her renewed energy and motivation to continue my work.

Bringing Learning to Life: The Little Entrepreneurs Project

Understanding that child’s development thrives within a framework of collaboration and meaningful engagement, teacher Uugantsetseg applied what she learned from the project to create innovative learning experiences. In today’s globalized society, she recognised the importance of helping every Mongolian to respect their traditions while continuing to learn and grow.

With this vision, she took the initiative to implement the ‘Little Entrepreneurs’ project in her class in two phases starting in March 2023. Her students began production activities in the classroom, making belts and calf collars- protective leather bands used in Mongolian animal husbandry. The students donated their first products to herders in Batsumber soum of Tuv Province,

багш хөгжлийн дэвтэртээ төлөвлөж бичдэг байсан. “Ковид 19”-ийн үеэр хичээлийн агуулгын хоцрогдолтой, сурах сонирхолгүй байгаа сурагчдад зориулан “Идэвхтэй сургалтын аргууд” зохиож, сургалтын үйл ажиллагаандаа хэрэглэн, сурагч бүрийн сурах идэвх, оролцоог нэмэгдүүлж, хоцрогдлыг тодорхой хэмжээгээр арилгасан” гэж онцлов.

51 дүгээр сургуулийн багш О.Ууганцэцэгийн амжилтын түүх урт билээ. Тэрээр, 2022 онд Боловсролын ерөнхий газрын мэргэжилтэн Б.Даваасүрэнгийн хүсэлтээр “Хичээлийн идэвхтэй аргууд болон залуу багшийн үзэл бодол” сэдэвт илтгэлээ тус байгууллагын цахим хуудаст нийтэлж, дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж байгаа мэргэжил нэгтнүүддээ толиулуулжээ. Ингэснээр багш нар хичээлдээ цаг хугацаа, орон зайнаас хамаарахгүй сургалтын идэвхтэй аргууд ашиглах боломж бүрдсэн байна.

О.Ууганцэцэг 2023 оны багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр II түвшинд үнэлэгджээ. 2024 оны 9 дүгээр сарын 1-нээс 6в анги удирдан ажиллаж, “Шилдэг анги удирдсан багш”, тус ондоо “Хөдөлмөрийн аварга багш”- аар шалгарсан, заах аргач зэрэгтэй багш юм. Тэрээр, “Идэвхтэй сургалтын аргууд” сэдэвт сургалтаа 2023-2024 оны хичээлийн жилд Ховд аймгийн Дарви сум болон нийслэлийн 198 багшид урилгаар зохион байгуулжээ.

О.Ууганцэцэг багш илтгэл, эссэ, үр чадварын тэмцээнүүдэд чадвар сорьж, амжилт гаргадаг. Тухайлбал, 2023-2024 оны сургуулийн шилдэг илтгэл, 2024-2025 оны “Интеграцид суурилсан багшлахуй ба суралцахуй” сэдэвт илтгэлийн уралдаанд “Төсөлт ажлын арга зүйгээр интеграци хичээл төлөвлөж, сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нь” илтгэлээр оролцож сургуульдаа “Тэргүүн байр”, дүүрэгт “Гутгаар байр”, нийслэлд “Тусгай байр” эзэлж байв. Мөн 2023 оны 4 дүгээр сард Баянгол дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн багш нарын дунд зохиогдсон “Багш би дүүргийн хөгжилд” сэдэвт эссэ бичлэгийн уралдаанд оролцож

where winter conditions are particularly harsh.

They also produced a total of 150 calf collars, selling each for 5,000–10,000 MNT. From the over 1 million MNT earned, the class decided together, 20% was used to buy and plant pine and fir trees on the school grounds as part of the “One Billion Trees” program and a small amount was allocated to establish a small library in the classroom, sparking greater interest in reading among the students.

This project exemplified the rights-based, participatory approach she had learned through the child protection training—empowering students to make decisions, collaborate, and contribute to their community while developing practical skills.

Innovation During Challenging Times

Social studies teacher M. Nyamdelger from School No. 51 observed the transformation first hand, “*Ugantsetseg represents the diligent and dedicated young teachers at our school. From the beginning, she carefully planned each lesson and recorded in her teacher development journal the guiding questions to ask each student. During the COVID-19 period, when some students had fallen behind and lacked motivation, she developed ‘Active Learning Methods’ and applied them in her lessons. These methods increased student engagement and participation, helping to address learning gaps to a significant extent.*”

Recognition and Impact Beyond the Classroom

Teacher Ugantsetseg commitment to professional excellence has earned recognition at multiple levels. In 2022, at the request of Davaasuren, an expert from the General Authority for Education, she delivered a lecture titled ‘Active Learning Methods and the Opinion of a Young Teacher.’ This presentation was published on the Authority’s website, enabling educators from around the world to learn from her experiences.

In the 2023 teacher performance evaluation, Ugantsetseg was rated at Level II. Since Sep-

195 багшаас “Шилдэг 50”-д шалгарчээ. Үүний зэрэгцээ 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Баянгол дүүргийн хэмжээнд зохиогдсон “Сурагч бүрийн хөгжилд багш миний оролцоо” сэдэвт эссэ бичлэгийн уралдаанд оролцож, 153 багшаас “Шилдэг 15” багшийн нэг болж, БНСУ-ын “Дрим” сургуулийн багш нартай туршлага солилцох эрх авсан байна. Аливаа улсад ерөнхий буюу суурь боловсрол хамгийн чухал байдаг. Тэнд хамгийн шилдэг, хичээл зүтгэлтэй, тууштай багш нар ажиллаж, эх орныхоо ирээдүйн иргэдэд мэдлэг, боловсрол олгох хэрэгцээ шаардлага бий. О.Ууганцэцэг бол тийм шилдэг багш нарын нэг нь билээ.

tember 1, 2024, she has been leading class 6v and was recognized as both ‘Best Class Supervisor’ and ‘Labor Champion Teacher’ in the same year. She also holds the qualification of a teaching method specialist. Her own expertise has been sought beyond her own school. During the 2023–2024 academic year, she was invited to conduct training on “Active Learning Methods” for 198 teachers in Darvi soum of Khovd province and in Ulaanbaatar, spreading her knowledge and approaches gained through the child protection project to educators across Mongolia.

A Track Record of Excellence

Teacher Uugantsetseg consistently demonstrates her skills in professional competitions and presentations. In the 2023–2024 school year, she participated in the “Best School Presentation” competition, and in the 2024–2025 she entered the “Teaching and Learning Based on Integration” presentation contest with her presentation titled “Planning Integrated Lessons Using Project-Based Methods to Develop Students’ Creative Thinking.” She earned first place at the school level, third place at the district level, and received a special recognition award at the capital level.

She also excelled in the professional essay competitions. In April 2023, she participated in the essay competition ‘My Contribution as a Teacher to the Development of the District,’ held among public and private school teachers in Bayangol district, ranking among the “Top 50” out of 195 participants. Furthermore, on October 12, 2024, she competed in the Bayangol district essay contest titled “My Contribution as a Teacher to Every Student’s Development,” placing among the “Top 15” out of 153 teachers. This achievement earned her the opportunity to exchange experiences with educators from the “Dream School” in South Korea.

A Model for Dedicated Teaching

In any country, general or foundational education is critically important. The most dedicated, persistent, and inspiring teachers work tirelessly to provide knowledge and guidance to future citizens. Uugantsetseg exemplifies these qualities, demonstrating how professional training in child protection and rights-based approaches can transform teaching practice.

Her journey shows that when teachers are equipped with the right knowledge and tools—understanding child protection, promoting participation, and implementing active learning methods—they create classrooms where every child not only learns but thrives. Through her dedication to continuous improvement and her commitment to applying what she learned through the Save the Children project, teacher Uugantsetseg has become a role model for educators across Mongolia, proving that protecting and nurturing every child begins with a teacher who is willing to grow alongside their student.

ҮЛ ТАСАЛДАХ АМЖИЛТЫН БУУХИА

THE SOCIAL WORKER MAKING A DIFFERENCE: PROTECTING AND EMPOWERING CHILDREN

Нийслэлийн ерөнхий боловсролын 51 дүгээр сургууль математик-гадаад хэлний төрөлжсөн сургалттай билээ. 1-12 дугаар ангийн 65 бүлэгтэй, 2150 сурагчтай. Тус сургуульд Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжиж байгаа юм.

Б.Энхбаатар нийслэлийн 51 дүгээр сургуулийн ахлах, дунд анги хариуцсан нийгмийн ажилтан бөгөөд мэргэжлээрээ гурав дахь жилдээ ажиллаж байна. Тэрээр, Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн анхны сургагч багш нарын нэг юм. Эдүгээ уг төслийн ахлагчаар ажилладаг.

“Манай сургууль дахь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн баг 10 гишүүнтэй. Гишүүдийн тал хувь нь залуу багш нар юм. Төслийн багийн гишүүд маань өөрийн саналаар нэгдсэн учир гар, сэтгэл нийлэн идэвх, санаачилгатай ажиллаж байна. Сургуулийн нийгмийн ажилтан нь сурагчид, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгмийн болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, хүүхдийн сурлагын амжилт, хүмүүжлийн чанарыг дээшлүүлэх зорилгоор нийгмийн үйлчилгээ, туслалцаа хүргэх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлэхэд минь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл их хувь нэмэр оруулж байгаад талархаж байна гэж нийгмийн ажилтан Б.Энхбаатар ярилаа.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэнээр сургуулийн багш, ажилтнуудын хүүхэд хамгааллын болон хүүхдийн эрхийн

Enkhbaatar is a social worker at General Education School No.51 in Ulaanbaatar, where he is responsible for secondary and high school students. Currently in his third year at the school, he serves as the project lead for the Save the Children’s ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’. He was among the first trainers for the project. The school, specializes in mathematics and foreign languages.

“Our school’s project implementation unit consists of 10 members, half of whom are young teachers. Since all members joined the team voluntarily, they work together with great enthusiasm, initiative, and commitment. School social workers provide social and psychological support to students and their families, aiming to improve children’s academic performance and personal development through social services and assistance. I’m grateful to the project for helping me carry out my duties more effectively,” Enkhbaatar shared.

Training and Capacity Building

Since the project was launched, teachers and school staff have strengthened their understanding of child protection and child rights violations, while also gaining practical skills such as conducting risk assessments. The implementation unit organized activities targeting three key groups: parents, teachers, and students. They have trained 125 children and around 1,000 parents and caregivers.

A key component of the project was the “I Support My Friends” program. Senior students actively participated in the training and became well-informed about child protection topics. By ensuring the information was accessible to

зөрчлийн мэдлэгийн түвшин эрс нэмэгдэж, эрсдэлийн үнэлгээ хийх зэрэг олон талын чадварт суралцжээ. Төслийн баг эцэг эх, багш нар, сурагч гэсэн гурван талд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулж, нийт 125 хүүхэд, 1000 орчим эцэг, эх, асран хамгаалагчид сургалт явуулжээ. Ялангуяа, “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн чухал бүрэлдэхүүн хэсэг болсон “Би найзаа дэмжинэ” хөтөлбөрт тус сургуулийн ахлах ангийн сурагчид идэвхтэй хамрагдаж, мэдлэг мэдээлэлтэй болсон байна. Төслийн баг нь нийт анги бүлэгт мэдээллийг нээлттэй хүргэснээр олон сурагч хүсэлтээрээ сургалтад хамрагдаж, чиглүүлэгч болжээ. Чиглүүлэгч хүүхдүүд нийгмийн ажилтны хамт 6-9 дүгээр ангийн үе тэнгийн найзууддаа “Би найзаа дэмжинэ” сургалтаас олж авсан мэдлэгээ дамжуулан түгээж байна.

Нийслэлийн ерөнхий боловсролын 51 дүгээр сургуульд сурагчдын эвлэлдэн нэгдсэн 11 клуб тогтмол үйл ажиллагаа явуулдаг юм. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн чиглүүлэгч хүүхдүүдийн олонхи нь эдгээрийн аль нэг клубт харьяалагддаг билээ. Нэг клуб улирал бүр олон нийтийг хамарсан 1-2 аян тогтмол зохион байгуулж хэвшжээ.

Энэ сургууль гадны хүн нэвтрэхэд нарийн хяналт тавьж, тухайн зочны мэдээллийг тэмдэглэн бүртгэж, сургуульд байх хугацаанд таних үүднээс үнэмлэх олгодог болжээ. Энэ нь сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх энгийн хэрнээ үр дүнтэй арга болсон байна. Бусад сургуулиуд ч эл санал санаачилгыг дэмжин, олзуурхан хүлээн авч, сургуульдаа хэрэгжүүлж эхэлжээ. Түүнчлэн хүүхэд хамгааллын мэдээллийн хэлхээг сурагчдад танилцуулж, анги бүрт байршуулахын зэрэгцээ үүдэн дэх самбараар хүүхэд хамгааллын мэдээллийг тогтмол шинэчлэн хүргэх болжээ.

Нийгмийн ажилтан Б.Энхбаатар “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь”

all students, many voluntarily participated in the training and stepped up as peer facilitators. These student facilitators worked alongside Enkhbaatar to share their knowledge with their peers in grades 6 to 9.

The school has 11 active student clubs, and most of the project's peer facilitators are members of the clubs. Each club regularly organizes one or two community-oriented campaigns every semester, extending the project's reach beyond the school.

Creating Safer Spaces

The program has led to several concrete improvements in school safety. The school now maintains control over external visitors by recording their information upon entry and providing identification badges for the duration of their visit. This simple yet effective measure helps protect children's rights and prevents potential risks within the school environment. Other schools have recognised the value of this initiative and have begun implementing a similar system.

The school introduced a child protection information workflow chart to all students, which is displayed in every classroom. Information on the board at the school entrance is regularly updated to keep the school community informed about child protection resources and procedures.

Enkhbaatar regularly uses the manuals developed under the project in his daily work. One of the changes he highlighted was that every class has developed and actively followed its own set of classroom rules based on the new approach. *“There used to be classroom rules before, but they were often written in a negative tone, full of commands,” he explains. “Now, the rules use positive and encouraging language that promotes cooperation instead of blame. We also organized training for teachers on how to guide students in developing these rules.”*

This shift from negative to positive language represents a fundamental change in how the school approaches discipline and student behaviour,



төслөөс гаргасан гарын авлагуудыг харуулж, өдөр тутмын ажилдаа тогтмол ашигладаг тухайгаа ярилаа. Тэрээр, шинэ арга зүйгээр бүх анги дүрмээ зохиож, даган мөрдөж байгааг онцлон дурдав. “Өмнө нь ангийн дүрэм байсан уу гэвэл, байсан. Гэхдээ сөрөг утгатай үг хэллэгтэй, тушааж зааварчилсан өнгө төрхтэй байж. Харин одоо бусдыг уриалсан, хэн нэгнийг буруутгаагүй, эерэг утгатай үг хэрэглэж бүх анги дүрмээ зохиосон. Ангийн багш нарт энэ талаарх сургалт явуулсан” хэмээн өгүүлэв. Тэрээр, сургуулийнхаа “Урлаг заал”-ын ашиглалтыг ерөнхийд нь хариуцдаг тул сурагчдыг хөгжүүлэх, хамгаалах чиглэлээр олон талт үйл ажиллагаа тогтмол зохион байгуулдаг байна. Түүнчлэн сурагчдын санал санаачилгыг дэмжиж ажилладаг ажээ.

Биднийг зорин очиход нийгмийн ажилтан Б.Энхбаатар сургуулийн Эцэг, эхийн зөвлөлийн даргыг хүлээн авч, ажил хэргийн талаар ярилцаж, дөнгөж дуусаад байсан бол биднийг явах үед төслийн чиглүүлэгчээр бэлтгэгдсэн хүүхдүүд нийгмийн ажилтантайгаа уулзаж, ажлаа танилцуулахаар хүлээж байсан юм.

Нийгмийн ажилтан Б.Энхбаатарын ажил ийнхүү завгүй үргэлжилж, тэр хэрээр үл тасалдах амжилтын буухиа үргэлжилсээр байна.

creating a more supportive learning environment.

Enkhbaatar is also responsible for overseeing the use of the school's Art Hall, where he regularly organizes diverse activities that promote student development and protection. He actively encouraged and supported students' ideas and initiatives, creating opportunities for them to lead and grow.

When we arrived for our visit, he had just finished a meeting with the head of the School's Parent Council to discuss ongoing work. As we were about to leave, a group of student facilitators came in to meet with him and present their activities.

Social worker Enkhbaatar's busy, productive days reflect a chain of success that continues to grow. Through dedicated leadership, collaborative teamwork, and a genuine commitment to child protection, he has helped transform his school into a safer, more supportive environment where every child can thrive.

ҮР ДҮН, АМЖИЛТ ТОДОРХОЙЛОГЧ

DRIVING FORCE BEHIND THE SUCCESS

Р.Гэрэлчимэг 2022 онд нийслэлийн ерөнхий боловсролын 73 дугаар сургуульд анхны сэтгэл зүйчээр ажиллахаар иржээ. Энэ цаг үе нь Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжиж эхлэхтэй давхцав. Р.Гэрэлчимэг төслийн ажлын хэсгийн 12 гишүүний нэг болж, ерөнхий зохион байгуулалтыг хариуцахын зэрэгцээ сургалтаа удирдан явуулах болжээ. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл 73 дугаар сургуульд амжилттай хэрэгжиж байгаа нь чухамхүү сэтгэл зүйч Р.Гэрэлчимэгтэй салшгүй холбоотой юм.

Сургуулийн сэтгэл зүйч хүн бол сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээг суралцагч-хамт олон-гэр бүлд хүргэж, суралцагчийн сэтгэл зүйг зөв төлөвшүүлэх, багш, ажилчдыг арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллах, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилготой билээ. Р.Гэрэлчимэг төсөлтэй хамтран ажилласнаар залуу ажилтны хувьд шинэ зүйлд суралцах, сурсан мэдсэнээ бүсдад түгээх боломж гарсан байна. Тэрээр “Би өмнө нь хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байсан туршлагагүй ч “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд зохион байгуулагдсан бүх сургалтад хамрагдаж, сургагч багш болсноор шинэ мэдлэг хуримтлуулж чадсан.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд сургуулийнхаа багш нарт ёс зүй, ангийн дүрмийн талаар болон “Би найзаа дэмжинэ”, “Сайн эцэг эх” зэрэг хүүхэд хамгааллын сургалтуудыг зохион байгуулж, нөлөөллийн олон контент хийсэн” гэж ярилаа. Ингэснээр

Gerelchimeg joined School No.73 in 2022 as the school's first-ever psychologist. Her arrival coincided with the launch of Save the Children project ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia.’ She became one of the 12 members of the project's implementation unit, charged with coordination and leading training sessions. The project's success at the school is closely tied to her dedication and leadership.

A school psychologist's goal is to support the mental and emotional well-being of everyone in the school community. They provide professional psychological services to students, colleagues and families, helping children develop healthy minds, while guiding teachers and staff with practical advice and strategies. As a young professional, this role opened opportunities for Gerelchimeg to learn new approaches and share her experiences with others.

“I didn't have prior experience in child protection work. But by attending all the training sessions and becoming a trainer, I was able to gain new knowledge and skills. I organized sessions for teachers on the code of conduct, developing classroom rules, and child protection topics such as ‘I Support My Friend’ and ‘Safe Families’. We also created a variety of advocacy materials to raise awareness,” she reflected.


As a result, teachers at School No.73 not only improved their understanding of child protection but also changed their attitudes toward interacting with children. The transformation was noticeable among everyone, from young teachers just starting their careers to experienced educators with more than 30 years in the classroom,

тус сургуулийн багш нар зөвхөн сургалт явуулахаас гадна хүүхэд хамгааллын мэдлэгээ нэмэгдүүлж, хүүхэдтэй харилцах хандлагаа эрс өөрчилсөн байна. Залуу багш нар төдийгүй 30 гаруй жил ажилласан ахмад багш нар ч төслийн үр нөлөөг үнэлэх болжээ.

“Манай сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээнд ахиц, өөрчлөлт их гарч байна. Багш нараас гадна сургуулийн аж ахуйн албаны үйлчлэгч, жижүүр, цахилгаанчин зэрэг ажилтнуудаа хүүхэд хамгаалалд үүрэг оролцоо нь ямар байх талаар сургалтад хамруулж, мэдээлэл тогтмол өгдөг болсон. Тэгснээр аж ахуйн албаны ажилтнуудын хүүхэдтэй харилцах харилцаа сайжирч өөрчлөгдсөн. Энэ нь хүүхдүүдэд эерэг нөлөө үзүүлж байна. Наад зах нь шал угаах үедээ анхааруулах шар тэмдгийг байнга тавьж хэвшсэн. Суралцагч хүүхдүүд ч тэдний ажлыг ойлгож, хүндэлдэг болсон. Ажилтнууд маань хүүхдийн эрхийн зөрчил гарвал хэнд мэдээлэх вэ гэдгийг мэддэг болсон. Мөн гадны хүн сургууль руу нэвтрэхэд бүртгэл хөтөлж, тухайн хүн сургуульд байх хугацаандаа “Зочин”, “Эцэг эхийн зөвлөл” гэсэн таних тэмдэг бүхий энгэрийн тэмдэг зүүх болсон” гэж Р.Гэрэлчимэг багш ярилаа.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хүүхдүүдийн оролцоог ч нэмэгдүүлжээ. 2024 онд 125 хүүхэд “Би найзаа дэмжинэ” сургалтад хамрагдсанаас 25 хүүхэд үе тэнгийн дэмжигч болж, “Сэтгэл зүйн анхны тусламж” зэрэг сургалтуудыг сургуулийнхаа бусад найз нарт зааж сургасан байна. Сургуулийн нийт сурагчдын 70-80 хувь нь сургалтад хамрагдаж, ингэснээр хүүхдүүд хоорондын зөрчил маргаан эрс багассан аж. “Би найзаа дэмжинэ” сургалтын дэмжигч

all of whom recognized the project's positive impact.



Impact on School Staff and Environment Significant progress has been made in strengthening the school's child protection services. Gerelchimeg shared that even school staff, such as cleaners, guards, and electricians, are now regularly included in training and receive ongoing information about their role in child protection. This has greatly improved how they interact with children, creating a safer and more respectful environment.

She explains, “Our cleaning staff have developed the habit of always placing yellow warning signs when mopping the floors. Students now understand and respect their work, which has created a more caring atmosphere in the school. Children also know whom to talk to if their rights are violated. Now, we keep a visitor log and require all visitors to wear identification badges marked ‘Guest’ or ‘Parent Council’ while they enter school.”

Gerelchimeg: The Psychologist

The project has gradually increased student participation. In 2024, 125 students participated in the “I Support My Friend” training. Among them, 25 students became peer supporters, and they shared their knowledge with other students, offering “Psychological First Aid” sessions.”

Around 70-80% of all students participated in the training, resulting in a decrease in conflicts among children. The peer supporters of the “I Support My Friend” program also collaborated to initiate a project, which received two rounds of funding from Save the Children Mongolia. They successfully implemented the project while actively participating in the school's Student Coun-

хүүхдүүд хамтран төсөл бичиж, Хүүхдийг Ивээх Сангаас хоёр удаагийн санхүүжилт авч, төслөө амжилттай хэрэгжүүлэхийн зэрэгцээ сургуулийнхаа “Сурагчдын өөрөө удирдах зөвлөл”, “Хөвгүүдийн зөвлөл”, “Охидын зөвлөл”-д оролцон ажиллаж байгаа аж. Сэтгэл зүйч Р.Гэрэлчимэгийн хувьд хүүхдүүдийг төсөл бичихэд чиглүүлж, зөвлөсөн байна.

Сургагч багш нар маань эцэг эх, асран хамгаалагчдад зориулан “Сайн эцэг эх” цуврал сургалтыг зохион байгуулжээ. Эхний сургалтад хамрагдсан эцэг, эх, асран хамгаалагчдын 60-70 хувь нь дараагийн сургалтад дахин ирдэг байна. Тэд хүүхэдтэй хэрхэн ажиллах онцлог, арга зүйг заалгаж, “Үр дүнтэй, сайхан сургалт байна. Дахин сургалт явуулаарай” хэмээн хүсч, захидаг болжээ. Эцэг эхчүүдийн идэвх нэмэгдэж, сургуулийн Эцэг эхийн зөвлөлтэй хамтарч ажиллах хүсэлтэй болж, хандлага нь өөрчлөгджээ. Түүнчлэн, эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхэдтэйгээ хэрхэн харилцах, ярилцах, сэтгэл зүйн асуудалд нь яаж туслах вэ гэхчлэн олон чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл авах нь нэмэгдсэн байна.

Р.Гэрэлчимэг Хүүхдийг Ивээх Сангаас боловсруулж гаргасан сурах бичиг, гарын авлага материалыг үйл ажиллагаандаа тогтмол ашигладаг. Ангийн дүрмийн үлгэрчилсэн загвар, эцэг эх, асран хамгаалагчдын Зөвлөлийн ажиллах жишиг удирдамж, модуль сургалтуудыг сургуулийнхаа бүх багш, ажилтанд түгээн дэлгэрүүлж байна. Тэрээр, сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад зориулсан өөрийгөө халамжлах дэвтрийг өдөр тутамдаа ашигладаг аж. “Хүүхдийг Ивээх Сангийн сургалтууд онол, дадлага хосолсон болохоор үр дүнтэй. Түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэхэд хялбар байдаг. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн ажлын хэсгийн гишүүд тэгш оролцоотой. Сургуулийн нийгмийн ажилтан бид хоёр голлон чиглүүлж ажилладаг” гэж сэтгэл зүйч Р.Гэрэлчимэг хэллээ.

cil, Boys' Council, and Girls' Council. The school psychologist guided and advised the students throughout the project proposal process.

Engaged Parents and Caregivers

Trainers organized “Safe Families” sessions for parents and caregivers. Remarkably, 60-70% of those who attended the first session returned for the next training. Attendees learned about effective parenting approaches and techniques for communicating with children. They shared positive feedback, saying, “*It was a meaningful and helpful training. Please organize more sessions like this.*”

Parents have become more engaged and motivated to collaborate with the school's Parent Council, showing changes in attitude and behavior. More parents and caregivers are now seeking advice and information on how to communicate better with their children, hold meaningful conversations, and support their student's emotional well-being.

Gerelchimeg: School's Implementation Unit Member

The school psychologist regularly uses the learning materials and manuals developed by Save the Children in her work. She actively shared and promoted key resources such as ‘Exemplary Guidelines of Child Protection Mechanism in General Education Schools’, ‘Exemplary Guidelines for Parents' Council of Schools’ and various training modules among all teachers and staff at her school. She uses the self-care journal designed for psychologists and social workers daily.

“*Save the Children's training is very effective because it combines both theory and practice. It's easy to share and put these materials into practice,*” she shared. Our project team works with equal participation, while I, as the school's psychologist, we take the lead in guiding the process. Gerelchimeg, can truly be described as one of the key drivers behind the project's success. She has played a central role in coordinating and guiding the project's implementation at the school,

Нийслэлийн 73 дугаар дунд сургуулийн сэтгэл зүйч Р.Гэрэлчимэгийг “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн үр дүн, амжилтыг тодорхойлогч хэмээн нэрлэж болмоор. Уг төслийн үйл ажиллагааг сургуульдаа амжилттай хэрэгжихэд чиглүүлэн зохицуулах, сургалт явуулах, тайлан мэдээ бэлтгэх, сурагчдын төслийг чиглүүлж, зөвлөх гээд олон ажлаас нь харахад эрхгүй ингэж дүгнэмээр юм билээ.

organized training, prepared reports, and mentored students who developed their own projects. Through her leadership, School No. 73 has transformed into a model school for effective child protection, demonstrating how dedicated professionals can create lasting change in their communities.

Reflecting on the transformation she has witnessed, Gerelchimeg shares: *“When I see our students confidently supporting their friends, when I watch parents returning for more training sessions, and when I notice even our cleaning staff placing warning signs to keep children safe, I realize we haven’t just changed policies. We’ve changed hearts. Every child now knows they matter, they are protected, and they have people who will listen. That’s the real success of this project.”*



МӨРӨӨДЛИЙГ МИНЬ ХӨГЖҮҮЛСЭНД БАЯРЛАЛАА

THANK YOU FOR NURTURING MY DREAM

Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн бага ангийн багш Ж.Цэндсүрэн мэргэжлээрээ 10 гаруй жил ажиллаж байна. Эдүгээ тавдугаар ангид хичээл зааж буй тэрээр, Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн “Модуль 1”, “Модуль 2”, “Сайн эцэг эх” сургалтад хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгджээ.

“Багш биднийг агуулга сайтай, багтаамж ихтэй, шинэ арга зүйтэй, чанартай сургалтад урьж, боловсруулж хөгжүүлсэнд төслийн хамт олонд гүнээ талархаж байна. Хүүхдийг Ивээх Сангаас зохион байгуулж байгаа сургалтууд агуулгын хувьд маш их мэдээлэлтэй, логик дараалалтай, арга зүйн хувьд богино хугацаанд өргөн ойлголт өгсөн, суралцагчаар бодуулсан, ажиллуулсан, эргэцүүлэн дүгнүүлсэн, сонирхолтой, халуун дулаан уур амьсгалтай байсныг онцлон дурдмаар байна. Би сурсан мэдсэнээ бусад багш нар, эцэг эхчүүдэд зааж, мэдлэг туршлагаа нэмэгдүүлж, өөрийн гэсэн арга зүй, туршлагатай болсон” гэж Ж.Цэндсүрэн багш сэтгэл хангалуун ярилаа.

Tsendsuren, a primary school teacher at School No.1 in Jargalant soum, Khovd province, has dedicated over 10 years to teaching. She currently teaches fifth-grade students and has become a passionate advocate for child protection in her school and community.

Through the Save the Children’s Child Protection Project, Tsendsuren was trained as a certified trainer, completing Module 1¹, Module 2² and ‘Safe Families training.’

Discovering New Approaches

“I’m grateful to the project team of Save the Children for inviting teachers to such high-quality trainings with new approaches that helped us grow professionally,” Tsendsuren said. She highlighted that the training sessions were well-structured and logically organized, and offered broad and practical knowledge in a short time.

¹ Module 1: Training for teachers, school staff and parents on positive discipline methods, nurturing non-violent approaches to children’s learning and development.

² Module 2: Training on prevention, early identification, reporting, response flow and roles of school staff:

Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн багш нар сургагч багш Ж.Цэндсүрэнгээр дамжуулан хүүхэд хамгааллын талаарх ойлголт, мэдлэгээ гүнзгийрүүлж, илүү зөв хандлага, мэдрэмжтэй болжээ. Тухайлбал, тэд өмнө нь “Хүүхэд хамгаалал бол сургуулийн нийгмийн ажилтны л хийх ажил” хэмээн ойлгож байсан нь ташаа байсныг ярьж байна. Урьд нь ширээ цохиж, хүүхдүүдээ “айлгаж” хүмүүжүүлэхийг хичээдэг байснаа одоо эерэг аргаар, уурлаж, бухимдалгүйгээр учир байдлыг ойлгуулж, харилцаж сурсан ажээ. Загнаж зандрах биш, урам зориг өгч, алдаа гаргасан ч дахин оролдож, хичээхэд нь дэмжвэл бүх хүүхэд сурах боломж бололцоотой гэдгийг анзаарчээ.

Ж.Цэндсүрэн багш ангийн хүүхдүүдээсээ тэдний сайн сайхан байдалд нөлөөлдөг гадна ба дотно орчны судалгаа авчээ. Тухайлбал, тухайн сурагч гэрээсээ сургуульд ирэх замдаа ямар эрсдэлтэй тулгардаг, сошиал хэрэглээндээ хяналт тавьж чаддаг уу? гэдгийг мэдсэний дараа эцэг, эхтэй нь холбогдож, эрсдэлийг бууруулах чиглэлд урьдчилан сэргийлэх боломжтой бүх л арга хэмжээний талаар ярьж зөвлөлджээ. Ангийнхаа эцэг эх, асран хамгаалагчидтай тусгайлан цаг гарган уулзаж, яаж сайн аав, ээж байх талаар ярилцдаг болов. Сургагч багш Ж.Цэндсүрэн ангийнхаа хүүхэд бүрийн ар гэрээр орж, амьдрал ахуйг нь үзэж танилцжээ. Ангийн дүрмийг хүүхдийн оролцоонд тулгуурлан зохиож, олонхийн саналаар батлан, улмаар хэрэгжүүлж эхэлжээ. Ангидаа хүүхдүүдийн стресс тайлах, булчин суллах хөгжимт дасгал хийж хэвшив.

“Өмнө нь чадлаараа л ажиллаж байна гэж боддог байсан ч учир дутагдалтай байсан юм билээ. Хүүхдийг суралцахад дуртай болгох, тэднийг хамгаалах талын мэдлэг дутмаг байжээ. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн ачаар хүүхэдтэй болон эцэг эхтэй харилцах үр дүнтэй, шинэлэг арга барилд суралцлаа. Бага ангийн багш бол миний багын мөрөөдөл юм. Хүүхэд байхдаа багш дэвтэр засах, самбарт

“The sessions encouraged us to think, reflect, and actively participate. The training was interactive and created a warm, welcoming environment,” she added. “I have been able to share what I learned with other teachers and parents, further expanding my knowledge and developing my own teaching methods and approaches,” as she expressed her satisfaction. With Tsendsuren’s support as a trainer, the teachers at the school have deepened their understanding and knowledge of child protection, and developed a more positive and empathetic attitude.

“They previously believed child protection was the responsibility of the school social worker. She shared a common misconception.” In the past, some teachers tried to discipline students by raising their voices or using fear, now they have learned to communicate through positive approaches, helping children understand situations calmly.

Instead of scolding, they now encourage and support their students, realizing that when children are motivated and guided with care, even after making mistakes, every child has the potential to learn and succeed.

Putting Knowledge into Practice

Tsendsuren didn’t just learn new approaches; she put them into action. She conducted surveyed her students to better understand the internal and external factors affecting their well-being. For example, she examined what risks children might face on their way to school and whether the children could limit their own social media and screen time properly.

After identifying these risks, Tsendsuren reached out to parents to discuss preventive measures and ways to keep their children safe. She arranged time to meet parents and caregivers individually to provide guidance and support. She also visited each student’s home to learn about their living conditions and family environment.

Together with her students, she developed classroom rules based on participation and major-

бичих нь сайхан санагддаг байж билээ. Гэвч амьдрал дээр өөр байсан. Би сайн багш болж, цаашид мэргэжлээрээ илүү хөгжиж, амжилт гаргах болно. Хүүхдийг Ивээх Сангийн энэ төсөл надад мөрөөдлөө хөгжүүлэх боломж олгосонд баяртай байна” хэмээн Ж.Цэндсүрэн багш сэтгэл хангалуун ярилаа.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хүүхэд хамгааллын механизмыг хөгжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах, сургууль болон хамтарсан багийн хамтын ажиллагааны сайн зохицуулалт, хяналтын тогтолцооны загвар бий болгоход чиглэж байгаа юм. Сурагчдад эрхийг нь мэдүүлж, эрхийн зөрчлийг таньдаг болгож, эрхийн зөрчил гарвал хэнд, хаана, хэрхэн хандахаа ойлгож, улмаар аливаа эрсдэлтэй үед өөрийгөө халамжлах болон үе тэнгийнхэндээ сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үр чадварт сургах ач холбогдолтой билээ. Түүнчлэн, хүүхэд хамгааллын асуудлаар хүүхдийн дуу хоолойг холбогдох байгууллагуудад хүргэж, бодлого журмуудад тусгах зорилготой.

“Багш хүн шавь нарынхаа төдийгүй аав, ээжийнх нь ч багш юм. Маш их үүрэг хариуцлага хүлээдэг. Би энэ үүргээ нэр төртэй биелүүлэхэд төслийн сургагч багш болсон минь том хувь нэмэр оруулсан юм” гэж Ж.Цэндсүрэн багш нэмж хэлсэн.

ity consensus, ensuring every child's voice was heard. In class, she introduced music-based relaxation and stretching exercises to help children relieve stress.

A Dream Realised

“I used to think I was doing my best as a teacher, but I realized I lacked the knowledge on how to encourage children to enjoy learning and to truly protect them,” Tsendsuren reflected. Through the project ‘Establishing School-Based Child Protection

Mechanism in Mongolia’, I learned new and effective ways to communicate with both children and parents.

She shared, “Becoming a primary school teacher has always been my childhood dream. When I was a child, I admired how teachers checked notebooks and wrote on the blackboard; it looked so wonderful. But in real life, I discovered that teaching is much more challenging. Still, I’m determined to become a better teacher, to grow in my profession, and to achieve more.

She added with a smile, “Thanks to this project by Save the Children, I now have the opportunity to develop my dream and become the kind of teacher I’ve always wanted to be.”

Creating Lasting Impressions

The project aimed to strengthen the child protection mechanism through prevention, early identification, and prompt response to cases of violence against children. It created model practices that facilitated robust coordination, monitoring and supervision between schools and the multidisciplinary team.

The project equipped children with essential skills to address challenges and serve as advisors within their peer groups. The project taught children their rights and helped them understand where, how, and to whom they can report when their rights are infringed. Furthermore, it ensures children’s voices are heard by relevant authorities and reflected in policies and procedures related to child protection.

Teachers like Tsendsuren are at the heart of making this vision a reality

A Teacher’s Pride

“A teacher is not only an educator for their students but also for the parents. It’s a role that comes with great responsibility,” Tsendsuren concluded, “Becoming a trainer through this project has been a tremendous support in helping me fulfil that responsibility with pride.”

ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАЖ ЗОХИОСОН, ОЛУУЛАА МӨРДӨХ “АНГИЙН ДҮРЭМ”

CLASSROOM RULES BUILT ON PARTICIPATION AND SHARED RESPONSIBILITY

Хэрэв Та ерөнхий боловсролын сургуулийн анги даасан багш бол хүлээцтэй, уян хатан, өр зөөлөн, тэсвэр тэвчээртэй байхын зэрэгцээ харилцааны олон сорилтыг даван туулахад бэлтгэгдсэн байх ёстой. Багш Та соён гэгээрүүлэгч байж, сониучхан, томоогүй, зөрүүд, нухацтай, олон ааш араншин, үзэл бодолтой шавь нараа зөв чиглүүлж чадна. Тэгж байж л хүүхдэд шинжлэх ухааны нотолгоонд суурилсан мэдлэг олгож, суралцах арга барил эзэмшүүлнэ. Шавь нараа ирээдүйд нийгэмшин амьдрахад, биеэ зөв авч явах чадварт сургана. Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн биологийн багш О.Мядагмаа ийм чадвартай багш нарын нэг билээ. Тэрээр, хүүхдүүдийн оролцоо, саналд тулгуурлаж зохиосон ангийн дүрмээр багийг удирдах эрэл хийж буй юм.

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд 2023 оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхэлжээ. О.Мядагмаа багш төслөөс зохион байгуулсан сургалтуудад эхнээс нь идэвхтэй хамрагдав.

“Би “Хүүхдийг Ивээх Сан”-гийн сургагч багш нараасаа маш ихийг сурч мэдсэн. Тэр дотроос ангийн дүрэм, түүний ач холбогдлын талаар илүү сонирхон судалсан юм. Ангийн дүрэм нь сурагчид сайн дураараа оролцсон, саналаа чөлөөтэй илэрхийлж, олонхоороо баталсан учир үр дүнтэй хэрэгжих боломжтой, хүүхэд бүр нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд зохицон амьдарч сурахад нэн чухал туршлага болох ач холбогдолтой юм. Ангийн дүрэм нь

Effective teachers must be patient, flexible, kind-hearted, and resilient, ready to navigate many challenges of communication in the classroom. They are not only educators but also mentors who can understand and positively direct students with diverse personalities, those who are curious, playful, stubborn, or serious. These abilities enable students to gain evidence-based knowledge and cultivate effective learning habits, build essential life competencies and develop a strong sense of responsibility.

One educator who demonstrates these qualities is Myadagmaa, a biology teacher at School No. 1 in Jargalant soum, Khovd province. She has been exploring innovative ways to lead her class through rules created with active student participation and input.

A New Approach Through Professional Development

In January 2023, the Save the Children project ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ was launched at School No.1. Since that time, teacher Myadagmaa actively participated in the program’s training sessions.

“I learned so much from the Save the Children trainers, and one topic I found especially interesting was classroom rules,” she said. “Since students voluntarily participated in creating the rules, freely shared their opinions, and approved them democratically, the rules were implemented effectively. It became an experience that helps every child learn to live in harmony with norms accepted by all.

сурагчдыг багаар ажиллах, амжилтад хүргэх, сурч боловсроход хүчирхийллийн бус аргаар чиглүүлэх чухал хэрэглүүр болж байна” гэж О.Мядагмаа багш ярилаа. Тэрээр, сурч мэдсэнээ сургуулийнхаа багш, сурагчдад бүтээлчээр түгээж байгаа билээ. Тэр дундаа ангийн дүрмийг сонгож, судалгаа хийн, сургуулийнхаа эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлжээ.

Багш О.Мядагмаа юуны өмнө хэд хэдэн асуулт боловсруулж, сургуулийнхаа нийт сурагчдаас судалгаа авсан байна. “Ангийн дүрэм яагаад чухал вэ?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан сурагчдын 79 хувь нь “Сургууль болон анги бүлэгт дэг журам тогтоно, тэгснээр сурагчид суралцах үйл явцад анхаарлаа төвлөрүүлж чадна, бие биедээ хүндэтгэлтэй хандана” гэж хариулжээ. Тэгвэл 11 хувь нь, “Ангийн дүрэм нь ямар нэг эрсдэлээс хол байлгана, хамгаална”, 5 хувь нь, “Асуудлаа ярилцана, ангиараа шийднэ” гэсэн байна. “Сурагчид ангийн дүрмээ хичээлийн үед хэр мөрддөг вэ?” асуултад судалгаанд оролцогчдын 68 хувь нь “Мөрддөггүй”, 14 хувь нь “Хичээлийн үед сайн мөрддөг”, 14 хувь нь “Заавал сануулж байж мөрддөг”, 4 хувь нь “Огт мөрддөггүй” гэсэн байв. Түүнчлэн “Сайн анги гэж ямар ангийг хэлэх вэ?” асуултад 39 хувь нь “Анги хамт олноороо баг болон нэгдэж, аливаа ажилд манлайлан оролцдог”, 23 хувь нь “Бусдад үлгэр жишээч бол”, 18 хувь нь “Байнга идэвх санаачилгатай байдаг бол”, 20 хувь нь “Эв нэгдэлтэй, дээрэлхэлтгүй бол” гэж хариулжээ.

Ангийн дүрэм яагаад чухал талаар О.Мядагмаа багш “Судалгаанаас үзэхэд, сайн менежменттэй анги байхын тулд ангийн сурагч нэг бүрийн оролцоо хамгийн чухал гэдэг нь харагдаж байна. Ангийн дүрмийг амжилттай хэрэгжүүлбэл сурагчдын идэвхтэй оролцоогоор дамжуулан багш болон байгууллагын менежментийг сайжруулах боломжтой” хэмээн ярих. Аливаа асуудалд санал, шийдэл хамгийн чухал. О.Мядагмаа багш “Ангийн дүрмийг сурагч бүрийн оролцоотой боловсруулах,

Classroom rules serve as an important tool for nurturing non-violent approaches to children’s learning and development.”

Turning Learning into Action

Myadagmaa has been creatively sharing what she learned with both her colleagues and students. In particular, she chose the topic of classroom rules for deeper study, conducted her own research, and presented the results at her school’s academic conference for discussion.

She developed several questions and surveyed all students at the school. The results revealed important insights into how students view classroom rules and their role in the learning environment.

Why are classroom rules important?

- 79 % of students said, “They help establish order in the school and classroom, allowing students to stay focused on learning and treat one another with respect.”
- 11% responded, “The rules help protect and keep us away from risks.”
- 5% said, “They help us talk through our problems and solve them together as a class.”
- 5% did not reply to the question

How well do students follow classroom rules during lessons?

- 68% admitted “We don’t always follow them,”
- 14 % said “We follow them well during class,”
- 14% said “We follow them only when reminded,” and
- 4% admitted “We don’t follow them at all.”

What makes a good class?

- 39% students said, “A class where everyone works together as a team and takes the lead in activities.”
- 23% answered, “A class that sets a good ex-

хэрэгжүүлэх, ангийн дүрмийг хэрэгжүүлснээр гарсан эерэг өөрчлөлтүүдийг сурталчлах, түгээх, ангийн дүрмийг “үнэт зүйл” болгох, ангийн дүрмийн хэрэгжилтээр дамжуулан сургалтын үеийн сургуулийн дотоод дүрмийг тогтоох” гэсэн санал, шийдлийг бусад багш нарт танилцуулжээ.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс гарч буй үр дүн, амжилтуудын нэгийг ийнхүү товч танилцууллаа. Төслийн ажлын хэсгийн гишүүд, сургагч болон сургалтад хамрагдсан багш нар олж авсан мэдлэг, үр чадвар, арга зүйгээ ашиглан, олон бүтээлч ажил санаачилж, хэрэгжүүлж байгаагийн тод жишээ нь О.Мядагмаа багш билээ.

ample for others,”

- 20% responded “A class that is united and free from bullying.”
- 18% said, “A class that is always active, motivated and full of initiative,”

The Importance of Classroom Rules

Based on her research findings, Myadagmaa drew important conclusions about classroom management. According to the survey results, the participation of every student plays a key role in creating a well-managed classroom. Effective implementation of classroom rules enhances both teacher performance and overall school management through active student involvement.



She shared her recommendations of four important principles with fellow teachers:

1. Ensure the participation of every student in creating and reviewing the classroom rules
2. Promote and share the positive changes that result from student-led rule creation
3. Transform classroom rules into shared values for the entire class; and
4. Strengthen the school's internal discipline through consistent implementation of these collaboratively created rules.

A Model for Meaningful Change

Teacher Myadagmma's work shows how problem-solving begins with thoughtful ideas and practical classroom innovations. By taking the concepts learned through the Save the Children project and conducting her own research, she has created a model that other educators can follow. Her approach shows that when students have a voice in creating the structures that govern their learning environment, they develop both a deeper understanding of rules and a greater sense of responsibility for their community.

This success story highlights the impact of the project: equipping teachers with knowledge, skills, and methods that inspire creative, meaningful activities in the targeted schools.



МЭДЛЭГ ДАГАЖ ХАНДЛАГА ӨӨРЧЛӨГДӨВ

EMPOWERING A TEACHER TO TRANSFORM A COMMUNITY

Гадна ба дотно орчинд эрсдэлгүй...

Нийслэлийн ерөнхий боловсролын 73 дугаар сургуулийн бага ангийн багш Б.Чулуунцэцэг мэргэжлээрээ арав дахь жилдээ ажиллаж байна. Ажлын гараагаа энэ сургуулиас эхэлсэн, залуу багш хэдий ч богинохон хугацаанд арвин баялаг туршлага хуримтлуулж чаджээ. Ялангуяа, Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөлтэй хамтран ажилласан хугацаанд их зүйлд суралцаж, хандлагаа өөрчилж, сургалтын арга барилаа эрс шинэчилжээ.

Shaping Safer Spaces for Children at School No.73

Chuluuntsetseg, a primary school teacher at General Education School No. 73 in Ulaanbaatar, has turned her decade of teaching experience into a mission for change. As part of the ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project led by Save the Children, she has embraced a transformative approach that prioritizes safety, mutual respect, and holistic development in her classroom

Өөрчлөлт авчирсан аялал

Хоёр жилийн өмнө Б.Чулуунцэцэг төслийн сургагч багш болжээ. “Хүүхдийг Ивээх Сангийн “Сурагчдын сурч хөгжих үйл явцыг хүчирхийллийн бус аргаар дэмжих нь” сургалтаас “Багш хүн бол нийгмийн ёс зүйн соён гэгээрүүлэгч байх ёстой” гэдгийг их сайн ойлгосон доо. Энэрэнгүй байж, сурагчидтайгаа зөв харилцах, хүндлэх ёстой юм байна гэдгийг ухаарсан. Бид сурагчдаасаа гадна тэдний эцэг эхэд, нэг үгээр улсынхаа нийт иргэдэд хүний эрх, хүнлэг байхын боловсролыг түгээх үүрэгтэй” гэж тэрээр, ярих. “Гэр бүлийн оролцоо чухал” гэдгийг ухаарснаар Б.Чулуунцэцэг сургалтаа эцэг эхчүүдийн дунд түгээж эхэлсэн юм. Хүүхдээ дэмжих арга, мэдлэг ухааныг тэдэнд зааж өгснөөр сургууль болон хүүхдийн ар гэрийн хамтын ажиллагаа сайжирсан. Энэ хамтрал сургуулийн хүүхэд хамгааллын төлөөх зүтгэлийг улам бүр баяжуулж, сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлсэн байна.

Б.Чулуунцэцэг багш төслийн модуль сургалтуудаар сурсан мэдсэнээ сургуулийнхаа анги даасан 60 гаруй, тэр дундаа бага ангийн 36 багшид дамжуулан түгээв. Түүний заавар, үлгэр дуурайл нь хамт олныг хүүхэд төвтэй сургалтын арга барилыг хэрэгжүүлэхэд урамшуулж, эерэг өөрчлөлтийн давалгаа бий болгосон юм.

Аюулгүй гадаад болон дотоод орчинг бүрдүүлжээ

Төслийн үр дүнд сургуулийн гадна болон дотно орчинд эрсдэлийг зохих төвшинд арилгаж чаджээ. Тухайлбал, сургуулийн хонгилд энд тэнд байх галын сарааг хүүхэд мөргөж гэмтэх эрсдэл байсныг залруулж, хурц өнцгийг нь дарж, дөрвөн талд нь зөөлөвч хаджээ. Хүүхдийн цүнхний жинг стандартын төвшинд байнга барьж байхын тулд сурагч бүрийг хувийн шүүгээтэй болгосон байна. Түүнчлэн, багш, хүүхэд хэн хэн нь гаднаас орж ирээд гутлаа сольж хэвшжээ.

A Teacher's Journey of Transformation

Two years ago, Chuluuntsetseg began her journey as a project trainer. Through Save the Children's training on Promoting Non-Violent Methods in Students' Learning and Development Processes, she discovered the critical role educators play in shaping a peaceful, violence-free society. *"I've learned to teach with compassion, communicate respectfully, and treat students with dignity,"* she said. *"Now, I don't just teach my students; I also engage their parents and our community, fostering awareness of human rights and humane values."* Recognizing the importance of family engagement, Chuluuntsetseg extended her training efforts to parents. By equipping them with knowledge and tools to support their children, she strengthened the partnership between home and school. This collaboration has further enriched the school's child protection efforts.

Her growth as a trainer and mentor has not only enhanced her teaching but also influenced over 60 of her colleagues, including 36 primary school teachers. Chuluuntsetseg's guidance has inspired her peers to adopt child-centered teaching methods, leading to a ripple effect of positive change.

Building Safer Environments, Inside and Out

With the project's support, School No. 73 has undergone a remarkable transformation. The school implemented safety-focused improvements, such as: Padded fire extinguisher cases in hallways to prevent injuries. Personal lockers for students, reducing the physical strain of heavy schoolbags. Mandatory shoe-changing policies, improving hygiene and comfort in classrooms. Outside the school, collaboration with government agencies led to the removal of unsafe car garages and the creation of a secure parking lot. Roads near the school and the Narnii Bridge area were equipped with protective barriers, ensuring students' safety during their commute.



Эрсдэлийн үнэлгээгээр сургуулийн гадна орчинд ноцтой байж болох хэд хэдэн эрсдэл байсныг арилгаж чадсан байна. Тухайлбал, сургуулийн хашааны гадна олон тооны автомашины гарааж байрлаж, зай талбайгүй байсныг төрийн байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд буулган газар чөлөөлж, автомашины зогсоол барьжээ. Сургуулийн ойролцоо, Нарны гүүрийн орчимд, автозам дагуу хамгаалах хашлага хийсэн байна. Ойролцоо нь баригдаж буй өндөр барилгаас учрах эрсдэлийг арилгаж, өнгө үзэмж сайтай хашаа хаалт татжээ.

Students Leading the Way

In Chuluuntsetseg's 5B class, students have taken ownership of their learning environment. Guided by their teacher, they established classroom rules through a democratic process, fostering respect, responsibility, and a positive atmosphere. *"Our class thrives because of the values we've built together," she shared. "Students now prepare independently for arts festivals and other school events. They're confident and proud of their contributions."*

Сурагчдын манлайлал

Төслийн сургагч багш Б.Чулуунцэцэгийн удирдсан 5в ангийн сурагчид санал санаачилгаараа ангийн дүрмээ баталсан байна. Сурагчид биесээ хүндэлж, мэндэлдэг болж, үүнийгээ ч дүрэмдээ оруулжээ. Мөн ангийн даргаа сонгуулиар сонгодог болжээ. Сурагчид таван заалт бүхий ангийн дүрмийг 100 хувь өөрсдийн оролцоотой баталсан учир дуртайяа биелүүлдэг байна. Тэр хэрээр ангийн уур амьсгал эерэг, найрсаг болов. Мэдээж, сурлагын амжилт ч дагаж дээшилсэн. “Манай анги сургагч багшийн анги гэсэндээ арай л өөр шүү. Наад зах нь сургуулийн урлагийн наадамд бие дааж бэлтгээд амжилттай оролцдог болсон байна” гэж Б.Чулуунцэцэг багш бахархалтай өгүүлсэн.


Хүүхэд хамгаалал, гэрэлт ирээдүй

Ерөнхий боловсролын 73 дугаар сургууль одоо амжилтын бэлгэ тэмдэг болж, дотоод болон гадна орчин нь аюулгүй, хүүхэд өсөж хөгжих эерэг уур амьсгалтай болсон байна. Төслийн хүрээнд хамтын ажиллагаа, хүндлэл, асуудлыг урьдчилан шийдвэрлэх хандлагыг түгээн дэлгэрүүлж, хүүхэд хамгаалал нь нийтэд хамаарах хариуцлага болохыг баталлаа. Өөрийн замналын талаар Б.Чулуунцэцэг багш ярихдаа, “Багш бол миний мөрөөдлийн мэргэжил бөгөөд энэ төслийн нэг хэсэг болсноор мөрөөдлийг минь бүр ч утга учиртай болгож өгсөн. Би сурган хүмүүжүүлэгч, манлайлагч болон хөгжиж, хамтдаа эерэг нөлөөлөл бий болгосноороо бахархаж байна” гэсэн юм.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл нь тууштай, мэргэжлийн багш нар болон хамтын хүчин чармайлт ямар том өөрчлөлт бий болгож чаддагийг тодорхой харуулжээ. Б.Чулуунцэцэг багш шиг манлайлагчидтай байх үед Монголын хүүхдүүдийн ирээдүй гэрэл гэгээтэй, аюулгүй, боломжоор дүүрэн харагдаж байна.

A Bright Future for Child Protection

School No. 73 now stands as a beacon of success, with both its internal and external environments made safer and more nurturing. The project has fostered a culture of collaboration, respect, and proactive problem-solving, proving that child protection is a shared responsibility. Reflecting on her journey, Chuluuntsetseg said: *“Teaching is my dream profession, and being part of this project has made that dream even more fulfilling. I’ve grown as an educator and a leader, and I’m proud of the positive impact we’ve achieved together.”* The ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project showcases the profound difference that dedicated educators and collaborative efforts can make. With teachers like Chuluuntsetseg at the helm, the future for Mongolia’s children looks brighter, safer, and full of potential.



ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЖ, БУСДАД ТҮГЭЭСЭН ЗАМНАЛ

A JOURNEY OF SELF-DEVELOPMENT AND SHARING KNOWLEDGE

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, Дарив сумын сургуульд амжилттай хэрэгжлээ. Г.Цэвэлмаа Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд Монгол хэл-уран зохиолын багшаар ажилладаг. Тэрээр “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөр бэлтгэгдсэн сургагч багш нарын нэг. Төслийн хэрэгжилт нь тус сургуульд хүүхэд хамгааллын чиглэлээр олон эерэг өөрчлөлт, санаачилгыг бий болгосон. Эдгээр ололт амжилтыг төлөөлүүлэн, төслийн ажлын хэсгийн гишүүн, сургагч багш Г.Цэвэлмаагийн туршлага, манлайллыг онцлон хуваалцаж байна.

Хүн мэдлэг, чадвараа бусадтай хуваалцах нь зөвхөн бусдын сайн сайхны төлөөх үйлдэл биш, өөрийгөө ч хөгжүүлэх чухал алхам болдог. Аливаа зүйлийг бусдад заах явцад өөрийн мэдлэгийг тэлж, туршлага хүримтлүүлж, асуудлыг шинэ өнцгөөс харах чадвар

The “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project, developed by Save the Children, was successfully implemented at General Education School No.4 in Yesunbulag soum, Govi-Altai Province. As a result, the school has seen numerous positive changes and new initiatives in the field of child protection.

Tsevelmaa, a Mongolian language and literature teacher at School No. 4 in Yesunbulag soum, has been teaching for eight years. She is also a member of the Project Implementation Unit and serves as a project trainer. This story highlights her experiences and leadership throughout the project.

Sharing knowledge and skills is not only an act that benefits others but also a vital step in one's own personal development. Teaching others allows us to expand our understanding, gain valuable experience, and approach issues from new perspectives. Today, there are many ways to share knowledge, yet the most meaningful forms involve offering sincere guidance, engaging in open dialogue, and learning together.

нэмэгддэг. Өнөө үед мэдлэгээ бусдад түгээх олон арга зам бий ч хамгийн үнэ цэнтэй хэлбэр нь чин сэтгэлээсээ зөвлөх, харилцан ярилцах, хамтдаа суралцах явдал юм.

Г.Цэвэлмаа багш “Төсөлд хамрагдсандаа баяртай байдаг. Найм дахь жилдээ багшилж байна. Төслөөс сурч мэдсэн зүйлс маань аливаа асуудлыг өөр өнцгөөс харах, өөрийгөө хөгжүүлэхэд их түлхэц болсон. Хэрэв боломжтой бол төслийг аймгийнхаа бүх сургуульд хэрэгжүүлэх хэрэгтэй” хэмээн сэтгэгдлээ хуваалцсан юм. Тэрээр зөвхөн өөрөө суралцаад зогсохгүй мэдлэг, чадвараа бусадтай хуваалцах, хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд бүтээлчээр ажиллаж байгаа сургагч багш нарын нэг. Говь-Алтай аймаг 18 сумтай ч ердөө хоёрхон сургуульд л “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэн. Тиймээс аймгийн Боловсролын газраас “Би багш” арга хэмжээг сумдад бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, сургагч багш нарын оролцоотойгоор эцэг эх, сурагчдад төслийн үр дүн, сургалтын агуулга, арга зүйг таниулан сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулжээ. Түүний хувьд Эрдэнэ, Цээл, Хөхморьт, Жаргалан суманд төвлөрч, эргэн тойрны сумдыг нь хамруулан хуваасан дөрвөн бүсийн суманд очиж, “Сайн эцэг эх”, “Би найзаа дэмжинэ” сургалтуудын агуулга, мэдээллийг эцэг эхчүүд, хүүхдүүдэд өгсөн байна. Эдгээр мэдээллүүдийг эцэг эхчүүд, хүүхдүүд сайнаар хүлээн авч хүүхэд хамгааллын талаарх ойлголтоо нэмэгдүүлжээ. Тэд “Ийм сургалтууд их хэрэгцээтэй, бид өмнө нь хүүхдүүдээ ойлгож, сонсох талд дутагдалтай байжээ. Харин эндээс нас, насны онцлогийг хэрхэн таньж, тэдэнтэй зөв харилцах арга барилыг сурч, мэдэж авлаа” хэмээн багш нартаа талархал илэрхийлжээ.

Сургууль бол хүүхэд бүрийн мэдлэг боловсрол эзэмшиж, ирээдүйд нь бэлтгэдэг хоёр дахь гэр. Энэ орчин нь сурагчдын хувьд аюулгүй, итгэлтэй, тайван, хүндлэлтэй байх ёстой. Мэдээж хүүхэд бүр айдас, дарамт, хүчирхийллээс ангид орчинд л амжилттай

Teacher Tsevelmaa shared, “I am very happy to have participated in the project. What I learned encouraged me to see things from different perspectives and greatly contributed to my personal growth. If possible, I hope to see this project implemented in all schools in our province.”

Expanding the Reach: Training Beyond Yesunbulag

Tsevelmaa is one of the project trainers who not only continued learning herself but also shared her knowledge and skills with others, applied what she learned, and worked creatively to disseminate these practices. Although Govi-Altai Province has 18 soums, the project was implemented in schools in only two soums. To expand its reach, the Provincial Education Department organized the “I Am a Teacher” event in a regional format across the soums. With the participation of project trainers, the event introduced parents and students to the project’s results, as well as the content and methodology of the training.

Teacher Tsevelmaa traveled to Erdene, Tseel, Khukhmorit, and Jargalant soums to conduct “Safe Families” and “I Support My Friends” training. Students, parents, and caregivers in these soums expressed deep gratitude to the project trainers.

Parents who attended the training said they had gained a better understanding of child protection. Many shared, “These trainings are truly important and necessary. We realized that we had not been so good at understanding and listening to our children before. Thanks to the project trainers, we learned how to recognize our child’s developmental needs and how to communicate with them in the right way.”

Creating a Safe School Environment

A school is a second home where every child gains knowledge, learns, and prepares for the future. For students, the school environment must be safe, trusting, calm, and respectful. Children can only learn and develop successfully in an environment free from fear, stress and violence.

сурч, хөгжиж чадна. Ийм орчин бүрдүүлэхэд багш, ажилтнуудын оролцоо, хандлага, хамтын ажиллагаа чухал нөлөөтэй. Г.Цэвэлмаа багш “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд сурагчдын сэтгэлзүйн аюулгүй байдлыг хангах, эцэг эх, хамт олонтой хамтран ажиллах, хүүхдүүдийн итгэлийг сэргээхэд чиглэсэн олон санаачилга, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь үүний тод жишээ юм. Түүний бүтээлч оролцоо нь хүүхдүүд сургуульдаа айдас биш итгэл мэдрэн ирэх нөхцөлийг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор бүх багш, ажилтнаа найман багт хуваан, сургуулийн орчинг улирал бүр үнэлдэг тогтолцоог нэвтрүүлжээ. Үнэлгээний явцад баг бүр тодорхой чиглэл хариуцан ажилладаг, жишээлбэл, нэг баг сургуулийн гадна орчны эрсдэлийг тодорхойлдог бол дараагийн баг тухайн үнэлгээг баталгаажуулж, нэмэлт эрсдэлийг илрүүлэх замаар ажилладаг. Ийм байдлаар багууд харилцан хяналттай, шат дараалсан үнэлгээ хийснээр сургуулийн орчны эрсдэлийг илүү нарийвчлалтай, системтэй тодорхойлох боломж бүрддэг. Энэ нь зөвхөн гадаад орчны аюулгүй байдлыг хангахаас гадна сурагчдын сэтгэлзүйн тайван орчинг бүрдүүлэхэд ч чухал нөлөө үзүүлдэг.

Хүүхэд хамгааллын орчинг бодитоор үнэлэх, эрсдэлийг таньж тодорхойлохын тулд энэ сургууль “Зочин багш” арга хэмжээг санаачлан хэрэгжүүлжээ. Энэ арга хэмжээний хүрээнд анги удирдсан багш нар сурагчдынхаа гэрээр зочилж, амьдардаг орчин, гэрээс сургууль хүрэх замын эрсдэлийг судалж, гарч болзошгүй эрсдэлүүдийг тэмдэглэн, нийгмийн ажилтанд мэдээлдэг. Эрсдэлд өртөх магадлал өндөртэй хүүхдүүдийн мэдээллийг онцгойлон тэмдэглэж, шаардлагатай дэмжлэг, хамгааллын үйлчилгээг төлөвлөхөд ашигладаг байна. Г.Цэвэлмаа багш “Төсөлд хамрагдсаны дараа сурагчдынхаа гэрээр зочлоход өмнөхөөс харах өнцөг их өөр болсон. Хүүхдийн орчин

The participation, attitudes, and cooperation of teachers and staff play a crucial role in creating such an environment.

The numerous initiatives and activities implemented by Tsevelmaa under the project focused on ensuring students’ psychological safety, collaborating with parents and colleagues, and restoring children’s trust—serve as a clear example of this. Her creative engagement has contributed greatly to building an environment where children come to school with confidence and joy rather than fear.

Systematic Risk Assessment

To create a child-friendly and safe environment, School No. 4 divided all teachers and staff into eight teams and introduced a system to assess the school environment each quarter. During these assessments, each team is responsible for a specific area. For example, one team identifies risks in the school’s external environment, while another team verifies the assessment and detects additional risks. This system of peer reviewed, phased evaluations enables the school to identify risks more accurately and systematically. It not only ensures safety in the external environment but also plays a crucial role in fostering a psychologically calm and secure atmosphere for students.

The Visitor Teacher Initiative

To accurately assess the child protection environment and identify potential risks, School No. 4 initiated the “Visitor Teacher” activity. Through this initiative, classroom teachers visit their students’ homes to examine living conditions and the route from home to school, noting any potential hazards and reporting them to the social worker. Information about children at higher risk is specifically recorded and used to plan the necessary support and protection services.

Tsevelmaa said, “After taking part in the project, I began to see things very differently when I visited my students’ homes. I now have a deeper understanding of their living conditions and a stronger

илүү гүнзгий ойлгож, эрсдэлийг таних чадвар нэмэгдсэн” хэмээн ярьсан юм. Тэрээр анги даасан багшийн хувьд “Зочин багш” арга хэмжээнд тогтмол оролцож, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад бодит хувь нэмэр оруулж байна. Энэхүү арга хэмжээ нь хүүхдийн бодит амьдралын орчинд тулгуурласан үнэлгээ, мэдээлэлд суурилсан хамгааллын арга хэмжээг төлөвлөхөд чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд багш нарын оролцоо, хандлагад эерэг өөрчлөлт авчирсан туршлагын нэг болж байна.

Төслийн ажлын хэсгээс хэрэгжүүлсэн бас нэг чухал ажил бол хүүхэд хамгааллын мэдээллийн хэлхээ юм. Тэд төслийн сургалтад хамрагдсаны дараа багш нар хүүхдийн эрхийн зөрчлийн мэдээлэл дамжуулах, хариу арга хэмжээ авах үйл явцыг тодорхой заасан дотоод журмаа боловсруулжээ. Тэрээр, энэ талаар “Мэдээллийн хэлхээ гэдэг нь хүүхэд

ability to identify potential risks.”

As a class teacher, she regularly participates in the “Visitor Teacher” initiative, making a concrete contribution to her students’ safety. This initiative plays an important role in planning protection measures based on assessments and information grounded in each child’s real living environment. It has also become an experience that positively influences teachers’ engagement and attitudes.

Establishing Clear Reporting Procedures

Another key initiative achieved by the Project Implementation Unit was the creation of a child protection information workflow. Using the project’s methodology, the school’s teachers developed an internal procedure that clearly defines the process for reporting and addressing matters related to children’s rights violations.



хүчирхийлэлд өртсөн, эсвэл өртсөнийг таамагласан, илрүүлсэн тохиолдолд хамгийн түрүүнд хэнд хандах, мэдээллийг хэрхэн хүлээн авах, ямар хугацаанд хэнд дамжуулах, ямар хариу арга хэмжээ авах, мэдээллийн нууцыг хэрхэн хамгаалах зэрэг бүхий л үе шатыг нарийн зохицуулсан үйл явц юм” хэмээн тайлбарлав. 4 дүгээр сургуульд энэхүү мэдээллийн хэлхээгээр хүүхдийн эсрэг бие махбодын, сэтгэл санааны, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл, хөдөлмөрийн мөлжлөг зэрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг хүүхдэд ойлгомжтой, тодорхой тайлбарлаж, мэдүүлдэг аж. Сургуулийн орчинд байршуулсан мэдээллийн самбараас хүүхдүүд энэ мэдээлэлтэй танилцаж, эрсдэл үүссэн тохиолдолд хэнд, хэрхэн мэдээлэх ёстойг ойлгож авдаг. Энэхүү систем нь хүүхдийг хамгаалах үйл ажиллагааг илүү төлөвлөгдсөн, хариуцлагатай, нэгдсэн байдлаар зохион байгуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн эрсдэлд өртөх магадлалтай хүүхдүүдийн мэдээллийг тусгайлан бүртгэж, анхаарал хандуулан судалж, шаардлагатай тохиолдолд нийгмийн ажилтанд дамжуулдаг нь хүүхэд хамгааллын үр дүнтэй, уялдаа бүхий тогтолцоог бүрдүүлж байгаа сайн жишээ юм.

Багш Г.Цэвэлмаагийн амжилтыг онцлон өгүүлэхэд, тэрээр зөвхөн мэдлэг, чадвараа түгээн дэлгэрүүлээд зогсохгүй, сургууль дахь төслийн ажлын хэсэгт идэвхтэй ажиллаж өөрийн хувь нэмрийг оруулсан юм. Түүний хичээл зүтгэл, манлайлал нь эцэг эхчүүд, сурагчдын хүүхдийн эрх, хамгааллын талаарх ойлголтод эерэг өөрчлөлт авчирч, орон нутгийн хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа билээ.

“An information workflow is a carefully coordinated process that lays out every step to take when a child has experienced or is suspected of experiencing violence: whom to contact first, how the information should be received, the timeframe for sharing it with the appropriate parties, what response measures to take, and how to ensure confidentiality,” explained teacher Tsevelmaa.

At School No. 4, the information workflow was used to explain different forms of violence—physical, emotional, neglect, sexual abuse, and child labor—in a clear and easy to understand way for students. They also learned whom to report to and how to seek help if their rights are at risk. This system plays an important role in organizing child protection efforts in a more planned, responsible, and coordinated manner.

Additionally, information about children who are at higher risk is recorded, closely monitored, and, when necessary, shared with the school social worker. This serves as a strong example of building an effective and well-coordinated child protection system.

A Model of Leadership and Impact

Tsevelmaa has not only shared and applied her knowledge and skills but has also worked actively with the school’s PIU to support its efforts. Her dedication and leadership have brought positive changes to parents’ and students’ understanding of children’s rights and protection, making a valuable contribution to strengthening the local child protection system.

Through her journey of learning and teaching, she embodies the principle that sharing knowledge enriches both the giver and the receiver—a true transformation through collaborative protection.

“ЭВЕРЕСТИЙН ОРГИЛД НИСЭЖ БУЙ БОЛЖМОРУУД”

A SMART BOARD GAME CREATED BY STUDENTS TO TEST THEIR KNOWLEDGE

**-Цахим орчны хэт хэрэглээг багасгаж,
эрүүл мэндийг хамгаалахын төлөө-**

Хүүхдийг Ивээх Сан /ХИС/-гийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг Улаанбаатар хотын Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг болон Говь-Алтай, Ховд аймгийн нийт 14 сургууль, 14 хамтарсан багт хэрэгжүүлж байгаа билээ. Төслийн хүрээнд зорилтот сургуулийн эцэг, эх, сурагчдад хүүхэд хамгааллын чиглэлээр сурсан, мэдсэнээ бодитоор хэрэгжүүлэх боломж олгосон нь бичил төслийн шалгаруулалт байв. Шалгаруулалтад тэнцэж, санхүүжилт авсан төслүүдийн нэг нь нийслэлийн 50 дугаар сургуулийн “Эверестийн оргилд нисэж буй болжморууд” багийн санаачилсан сэтгэл зүйн анхны тусламжийн талаарх мэдлэг түгээх хөлөгт тоглоом байлаа.

Нэрнээсээ эхлээд л өвөрмөц, нэн сонирхолтой энэ тоглоомыг зөвхөн хүүхдүүд гэлтгүй томчууд ч тоглоно. Үр дүнд нь тоглогч хэн ч бай, хүүхдэдээ, үе тэнгийнхэндээ сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх мэдлэгтэй болно. Нөгөөтэйгүүр энэ хөлөгт тоглоом нь хүүхдүүдийн сэтгэн бодох чадварыг тэлж, цахим орчны хэт хэрэглээг багасгаж, эрүүл мэндийг нь хамгаалах ач холбогдолтой ажээ. Тоглоомын аргаар дамжуулан хүүхэд хамгааллын чухал бүрэлдэхүүн болсон сэтгэл зүйн дэмжлэг, тусламжийн талаарх мэдлэг түгээх нь тун үр дүнтэй юм.

“Эверестийн оргилд нисэж буй болжморууд” багт 8-11 дүгээр ангийн 10 сурагч нэгджээ. Тэд цөм үе тэнгийн сургагч хүүхэд билээ. Багийн хамт олон маань ХИС-гийн

Save the Children is implementing the Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia project 14 schools in Gobi-Altai, Khovd aimags and the districts of Bayangol, Bayanzurkh, Sukhbaatar, Khan-Uul and Chingeltei in Ulaanbaatar. The project works with 14 multidisciplinary teams to strengthen child protection systems in schools.

As part of the initiative, micro project funding was provided to parents and students at target schools, giving them the chance to apply what they had learned about child protection in practical and creative ways. At General Education School No.50 in Ulaanbaatar, one student team turned this opportunity into a smart and engaging project: a board game to spread the knowledge of psychological first aid. A group of 10 students from grades 8 to 11, trained as peer educators through the project, received a micro project grant to develop their idea. The Larks Flying to the Peak of Everest team created a game that combines fun with learning. U.Tuguldur, a 10th grade student, and team member of the said, “Disseminating and sharing psychological first aid knowledge will produce the best results. We created this game with the hope that it would be innovative, interesting, and accessible to every child. The “I Support My Friends” handbook was very useful in preparing the questions.”

The board game includes 40 stations. Players take turns rolling the dice, move according to the number of dot and stop at the stations where they must answer questions about psychological first aid before continuing. Some stations can be skipped, while others, present challenges players. The first player to “Climb Mount Ever-

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллын сайжруулах нь” төслийн хүрээнд хэвлэсэн “Би найзаа дэмжинэ” гарын авлагыг ашиглаж асуултууд зохиосон байна. Хөлөгт тоглоом нь сүмбэр уулын дүрстэй, бэлээсээ оргил хүртэл 40 буудалтай аж. Тоглогчид шоо ээлжээр хаяна. Буусан нүдний тоогоор урагшилна. Гэхдээ бартаа саадтай. Зарим буудалд буцаж ухрах, зарим нь өнжих буюу хөдлөхгүй үлдэх “занга” хүлээж буй. Тоглогч урагшлахын тулд мэдлэг сорьсон асуултад зөв хариулах ёстой юм. Зөв хариулбал шооны буусан нүдний тоогоор буудал ахиж “авирах” бөгөөд нийт 40 буудлын дараа “Эверестийн оргил”-д амжилттай гарснаар тоглоомын ялагч тодрох юм.

“Эверестийн оргилд нисэж буй болжморууд” багийн гишүүн, нийслэлийн 50 дугаар сургуулийн 10в ангийн сурагч У.Төгөлдөр “Манай сургуулийн сэтгэл зүйч Н.Даваажаргал, дизайн технологийн багш Г.Энхчимэг нар биднийг чиглүүлж ажилласан юм. Багийн гишүүд маань хөлөгт тоглоомынхоо загварыг гаргах, бүтээх, тоглоомоо сурталчлан таниулах гэсэн үндсэн гурван чиглэлээр хуваагдан ажилласан. Төлөвлөж, хүчээ зөв хуваарилсан нь үр дүнтэй байлаа. Бидний санааг бодит ажил хэрэг болоход бүх талаар дэмжин тусалсан ХИС-гийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн ах, эгч нартаа болон чиглүүлэгч багш нартаа гүнээ талархаж байна гэлээ.

“Эверестийн оргилд нисэж буй болжморууд” багийн гишүүд хөлөгт тоглоомын загварыг өөрсдөө гаргаж, бат бөх, удаан эдэлгээг бодолцож хуванцараар цутгаж хийжээ. Тэд бичил төслийнхөө хүрээнд нийт 24 ширхэг хөлөгт тоглоомыг урлан, олонд таниулсан юм. Магадгүй, улс даяар энэ тоглоом тархаж, тэр хэрээр багийн гишүүдийн маань өнөөдрийн үүсэл санаачилга ирээдүйн үйлдвэрлэлийн эхлэл болох ч юм билүү. Тоглоомоор дамжин хүүхэд хамгааллын талаарх хэн хүний ойлголт нэмэгдэж, эерэг хандлага тогтох нь лавтай.

est” wins. Team member Anujin, a 10th grade student, explained, “When I was first attending the training, I thought about how to spread psychological first aid knowledge. I came up with a solution, asked for advice from our teachers, and wrote the project. The rules of the game are simple and easy to understand, but they help children to think and test their knowledge. The main thing is that children gain information through psychological first aid training and apply it. We felt proud for achieving our goal, receiving project funding, and successfully implementing the project”. Throughout the process psychologist Davaajargal and design technology teacher Enkhchimeg at School no.50 mentored the. The team organized themselves into three groups: design, construction, and promotion to divide the tasks. They prepared the materials, molded the game pieces and built sturdy boards strong enough to withstand repeated use. Tuguldur explained, “If you all focus on one thing, you will not be effective. Planning is very important”.

The “Larks Flying to the Peak of Everest” team produced 24 board games, now enjoyed by children who play compete, learn new skills and test their knowledge of psychological first aid.

Anujin said, “I think our team spent the project money effectively and creatively. We had ideas for improvement even while making the game. Our parents supported us in every way. Not only children, but adults can play this game too because people’s knowledge of psychological first aid is not very good.” Alongside the board game, peer supporters also delivered the “I Support My Friends” training to all students in their school. School No.50 in Ulaanbaatar has 2,668 students and 125 children were selected as peer supporters by their classmates in grades 9-11. With the project’s support, children became more active established 10 clubs, and took on leadership roles promoting child protection. “I arranged my lessons based on my interests. I participated in the training and became a peer supporter. My classmates accepted me. While teaching children, we had the idea of bringing psychological first aid knowledge to people of all ages. This

“Бидний энэ тоглоомыг хүүхдүүд ихэд сонирхон тоглож байгааг харахад урамтай байдаг. Тоглоомын дүрэм энгийн, ойлгомжтой. Сэтгэхүй хөгжүүлэх, мэдлэг сорих боломжтой. Найз нөхөд, багийн гишүүдээрээ бахархаж байна. Шинэлэг, сонирхолтой байж, тоглогчдод сэтгэл зүйн анхны тусламжийн талаарх мэдлэг түгээх зорилго маань бүрэн биелсэн. Бид ХИС-гийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн сургалтаас олсон мэдлэгтээ тулгуурлан энэ санааг гаргаж, тал бүрээс нь ярилцаж, судалж, улмаар чиглүүлэгч багш нараасаа зөвлөгөө авч, төслөө бичиж байлаа. Бидэнд үзүүлсэн санхүүгийн дэмжлэгийг үр дүнтэй, бүтээлчээр зарцуулсан. Аав, ээжүүд маань биднийг бүх талаар дэмжин тусалж байсныг хэлмээр байна” гэж “Эверестийн оргилд нисэж буй болжморууд” багийн гишүүн, тус сургуулийн 106 ангийн сурагч Т.Анужин ярилаа.

idea came to fruition, and we were able to turn the project into a reality” Tuguldur reflected.

At the start, few students understood psychological first aid. Through peer lead training, they learned to recognize and respond to emotional distress, listen attentively, provide comfort, and show greater empathy. Using the Look, Listen, Link approach, they also developed the skills to connect their peers to the appropriate services when needed.

By creating and sharing their board game, the “Larks Flying to the Peak of Everest” team not only expanded children’s knowledge and strengthen their thinking skill, but also encouraged healthier habits by reducing screen time and prompting teamwork. Their project demonstrates how student-led initiatives can make child protection practical, creative, and meaningful in everyday school life.



Нийслэлийн 50 дугаар сургууль нийт 2.668 сурагчтай. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд 9-11 дүгээр ангийн 125 хүүхэд үе тэнгийн сургагч болжээ. Сургагч хүүхдүүд найз, дүү нартаа “Би найзаа дэмжинэ” сургалтаас олж авсан мэдлэгээ дамжуулж байгаа юм. Үр дүнд нь тус сургуулийн бүх хүүхэд хэн нь ч бай, ойр орчмын найзаа ажиглаж, сэтгэлийн зовиуртай байгаа эсэхийг нь таньж мэдэх чадвартай болжээ. Нэг үгээр төслийн зорилго нутагшиж, энэ сургуулийн хүүхдүүд сэтгэлийн зовиуртай байгаа найзаа анхааралтай сонсох, тайвшруулах, улмаар “тань, ойлго, сонс” гэсэн “холбох зарчим”-ын дагуу шаардлагатай үйлчилгээ авахад нь холбон зуучлах чадвартай болж байна.

Нөгөөтэйгүүр, “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн нөлөөгөөр хүүхдүүдийн идэвх оролцоо нэмэгдэж, зорилго, чиглэлтэй болжээ. Үүний тод жишээ гэвэл, 50 дугаар сургууль дээр сурагчдын сайн дураараа нэгдсэн 10 клуб үйл ажиллагаа явуулж байгаа явдал юм.



АЮУЛГҮЙ СУРГУУЛИЙН АЗ ЖАРГАЛТАЙ СУРАГЧИД

SAFE SCHOOLS, HAPPY STUDENTS

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл Монголын алс баруун хязгаар Ховд аймгийн хоёр ч сургуульд хэрэгжсэн билээ. Үүний нэг нь, Ховд аймгийн Дарви сумын ерөнхий боловсролын сургууль юм. Тус сургуульд дээрх төсөл хэрхэн амжилттай хэрэгжсэнийг, ямар ололттой байсныг оролцогч талуудын жишээгээр танилцуулъя.

Аюулгүй орчинтой сургууль буюу сурагчийн амжилт

Дарви сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид төслийн хүрээнд “Би найзаа дэмжинэ”, “Хүүхдийн оролцоог дэмжих арга зүй”, “Хүүхдийн спринт үйл ажиллагаа буюу төсөл бичих” зэрэг олон сургалтад хамрагджээ. Эдгээр сургалтууд сурагчдын хүүхэд хамгааллын талаарх мэдлэгээ гүнзгийрүүлж, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлсэн байна. 12 дугаар ангийн сурагч Г.Алтанхүү хэлэхдээ, “Төслийн үр дүнд манай сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээ сайжирч, хүүхэд хамгааллын

In the remote western province of Khovd, of Mongolia, the General Education School of Darvi soum one of two pilot schools for Save the Children’s “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project. Over nearly three years, this initiative has transformed not just policies and procedures, but the very culture of how teachers, students, and the community approach child wellbeing and safety.

The following stories from a student, teacher, and school leader illustrate how comprehensive training, clear systems, and sustained commitment have created lasting change in this remote community.

The Student’s Voice: A Safe School Environment and Student Success

Altankhuu, a 12th-grade student, has witnessed and contributed to remarkable changes at her school. Through her participation in the ‘I Support My Friends’ peer support program, training on meaningful child participation, and project development skills workshops, she has gained both knowledge and confidence.

мэдээллийн хэлхээ илүү тодорхой болсон. Бид үүний ачаар аюулгүй сургуулийн аз жаргалтай сурагчид болж чадсан юм. Би өөрийгөө илэрхийлэх, бусадтай нээлттэй харилцах, аливаа зүйлд идэвх санаачилгатай оролцох, шаардлага тавих чадвартай болсон нь давуу тал. Сургуульд маань хүүхдийн сайн дурын оролцооны бүлгийн тоо нэмэгдэж, хүүхдүүд багаар ажиллах, манлайлах, бие даан санаачилга гаргах чадвараа хөгжүүлсэн” гэв. Тэрээр, үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалт, аюул ослоос урьдчилан сэргийлэх, хүнд нөхцөлд орсон найздаа хэрхэн туслах, хаана хандах талаар анхан шатны мэдлэгтэй болсон байна. Цаашлаад Хүүхдийн эрхийн тухай хуулийн талаар болон хүүхдийн орчинд байж болох аюул осол, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэж, мэдлэгээ бусдад түгээжээ.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн нөлөөгөөр идэвхтэй сурагчдын тоо нэмэгдэж, дуу хоолойгоо бусдад хүргэх болсон ажээ. Үүний үр дүнд сумын “Орон нутгийн хөгжлийн сан”-гаас “Хүүхдийн оролцооны байгууллага”-д жил бүр 3 сая төгрөгийн төсөв баталж, үйл ажиллагаа зохион байгуулах боломж бүрдүүлсэн байна. Түүнчлэн сумын удирдлагууд дунд, ахлах ангийн сурагчдыг “Үдийн хоол” хөтөлбөрт хамруулж эхэлжээ.

Мэдлэг, үр чадварын хөгжил буюу багшийн түүх

Монгол хэл, бичиг, уран зохиолын багш Д.Энхжаргал “Манай сургуульд төсөл хэрэгжихээс өмнө сурагчдыг хэрхэн хамгаалах, хөгжүүлэх талаар ойлголт багатай байлаа. Төсөлд хамрагдсанаар энэ талын мэдлэгээ нэмэгдүүлж, үр чадвараа сайжруулсан. Сургуулийнхаа ажлын хэсгийн багш нартай зөвлөлдөж, хамтран ажиллаж байна” хэмээн өгүүлэв. Тэрээр, багш бүхэн сургалтад хамрагдаж, өөрийгөө ямагт хөгжүүлж, оюунаа цэнэглэж байх ёстой гэж боддог. Тиймээс “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах

As a result of the project, our school's child protection services have improved, and the workflow chart for these services has become much clearer. Altankhuu explained. Because of this, we have become happy students in a safe school environment.

For me, a key benefit is that I have learned to express myself, communicate openly with others, participate actively and proactively, and speak up,” she said.

She has gained practical knowledge on how to prevent peer bullying, exclusion, supporting friends in difficult situations and knowing where to seek help when needed. She also learned about the Law on the Rights of the Child and how to identify and prevent potential dangers in children's environments, knowledge she now shares with others.

The growth in student engagement is another positive change Student volunteer groups have increased at the school which helped students develop skills in teamwork, leadership, and initiative. The visible change in student participation has prompted action from the local authorities. Darvi soum's 'Local Development Fund' has allocated an annual budget of 3 million MNT to the 'Children's Participation Organization, enabling a range of activities. Additionally, the soum government has started the School Lunch program for secondary and high school students. Students are active participants shaping their school environment and influencing community priorities.

A Teacher's Transformation through Knowledge and Skills Development:

Enkhjargal, a Mongolian language and literature teacher, admits that before the project was implemented her understanding of how to protect and support students' development was limited. “I thought that child protection was solely the responsibility of the school social worker, and that if any violations of children's rights occurred in her classes, she only needed to report them, assuming it was not the concern of others’.

нь” төсөл цагаа олсон, нэн хэрэгцээтэй, ач холбогдолтой байсныг онцлон дурдав. Д.Энхжаргал багш “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд “Сурагчдын сурч хөгжих үйл явцыг эрхэд суурилсан хандлагаар дэмжих нь”, “Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах арга зүй”, “Сайн эцэг эх”, “Би найзаа дэмжинэ” зэрэг сургалтуудад хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгдсэн юм. Тэрээр “Сургалтууд агуулгын хувьд мэдээлэл ихтэй, логик дараалалтай, арга зүйн хувьд богино хугацаанд, өргөн ойлголт өгсөн, суралцагчаар бодуулсан, ажиллуулсан, эргэцүүлэн дүгнүүлсэн, сонирхолтой хэлбэрээр өрнөж байсныг онцлон дурдмаар байна” гэлээ. Түүний хувьд сурсан мэдсэнээ бусад багш нартаа, сурагч болон эцэг эхчүүдэд зааж, мэдлэг туршлагаа нэмэгдүүлж, өөрийн гэсэн арга зүйтэй болон хөгжиж байна. Багш Д.Энхжаргал өмнө нь хүүхэд хамгаалал бол зөвхөн сургуулийн нийгмийн ажилтны хийх ажил хэмээн ойлгож, анги даасан болон хичээл заадаг ангиудад хүүхдийн эрхийн зөрчил гарвал зөвхөн мэдээлэх л ёстой, бусад хүмүүст энэ асуудал хамаагүй гэж боддог байв. Мөн сурагчдаа хэрхэн хамгаалах, дэмжих, хөгжүүлэх талаар ойлголт багатай байсан учир айлгаж хүмүүжүүлэхийг хичээдэг байснаа сургалтад сууснаар өөрчилж, эерэг аргаар, уурлаж бухимдалгүй, учир байдлыг ойлгуулж, харилцан ярилцах нь зөв гэдгийг ухаарсан нь том ахиц болжээ. Хамгийн чухал нь, хүүхдэд урам зориг өгч, алдаа гаргадаггүй хүн гэж байхгүй учир дахин оролдож хичээхэд нь тусалж дэмжвэл өөртөө итгэх итгэл нь нэмэгдэнэ гэдгийг ойлгожээ.

Өөрчлөлтийн эхлэл буюу төслийн ажлын хэсгийн түүх

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл Дарви суманд хэрэгжээд даруй гурван жилийг үджээ. Энэ хугацаанд сургуулийн багш, ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчид, сурагчид бүгд хүүхдийн

Her teaching methods reflected this limited view. She often relied on fear-based discipline.

Enkhjargal attended multiple workshops, including ‘Promoting a Rights-Based Approach in Students’ Learning and Development Processes,’ ‘Prevention, Early Identification, Reporting, and Response to Violence Against Children,’ ‘Safe Families,’ and ‘I Support My Friends.’ She was also trained as a project trainer.

“The trainings were content-rich, well-structured, and methodologically designed to provide comprehensive knowledge in a short time. The trainers encouraged participants to think critically, engage in activities, reflect, and draw conclusions in an interactive and engaging way, she shared the change in her teaching practice has been significant shift, realizing that using positive methods—such as calmly explaining situations, engaging in dialogue, and addressing issues without anger—is the proper way to guide and support students. Most importantly, she understands that by encouraging children and supporting them to try again—recognizing that no one is perfect and everyone makes mistakes—they can develop greater self-confidence.

Today, Enkhjargal, as a trainer and a member of the Project Implementation Unit, shares what she has learned with other teachers, students, and parents, which allows her to expand her knowledge and experience while further developing her own teaching methodology. “Every teacher should participate in the training, continually develop their skills, and keep their knowledge up to date, she emphasized. This project was timely, much needed, and highly significant.

The Beginning of Change: The Story of the Project Implementation Unit

Bulgamaa, head of the PIU at Darvi Soum General Education School, has had a unique vantage point from which to observe the project’s impact over nearly three years. From her position she has seen how teachers, school staff, parents, caregivers, and students have developed

эрх, эрхийн хамгааллын чиглэлээр нэгдсэн нэг гарааны ойлголттой болж, хүүхдийн сайн сайхны төлөө хамтдаа зүтгэх чин эрмэлзэлтэй болсон юм. Хичээл зүтгэлийн үр дүнд сурагчид бие биеэ хүндэтгэн суралцах соёлт зан үйлд суралцжээ. Тэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нартайгаа бүхий л сэдвээр “ханагүй”, “хаалтгүй”, илэн далангүй ярилцаж, ойлголцож чаддаг болжээ. Хүүхдийн сайн сайхан байдал бол орхигдуулж болохгүй, хамгийн нандин зүйл гэдгийг хүн бүр ухаарсан байна. Олон нийт, сумын удирдлагууд хүүхдийн төлөө нэгэн зорилгоор хамтран ажиллах болж, хандлага өөрчлөгдсөн аж. Дарви сумын ерөнхий боловсролын сургуулийн төслийн ажлын хэсгийн ахлагч Ч.Булгамаа “Бид төслийн сургалтын модуль, арга зүй болоод үйлийн удирдлагыг ашиглан ирээдүйн Дарви нутгийн хөгжил дэвшлийг түүчээлж, сайн сайханд хөтлөх иргэдийг бэлтгэж чадлаа. Би төслийн ажлын хэсгийг удирдан чиглүүлж, хүүхдийн ертөнцөд итгэлээр дүүрэн ажиллахдаа олж авсан хандлагын хамгийн том өөрчлөлт бол “Хүүхдийн хийсэн томоогүй, гэнэн цагаахан ямар ч үйлдэлд туйлын муу бөгөөд засаршгүй алдаа гэж үгүй” гэдгийг ойлгож, мэдэрсэн явдал юм” гэж ярьж байлаа. Тэрээр, анхны сайн багш, ажилтны сургалтаас эхлээд үе шаттай олон сургалтууд, олон талын хамтын оролцоотой ажлууд, эцэг эхийн санаачилсан төсөл, үйл ажиллагааны тухай нэмж хэлсэн. “Би найзаа дэмжинэ” үе тэнгийн сургагч бэлтгэх сургалтууд, багш нарын хамтын үйл ажиллагаа, сумын удирдлагуудын дэмжлэг, эцэг эхийн харилцаа, хандлагын болон хүүхдийн дундах эерэг өөрчлөлтүүдийг дурдсан. Мөн хүүхэд хамгааллын мэдээллийн хэлхээ боловсруулалт, түүнийг сурталчилах үйл явц, ангийн дүрмийн талаарх нэгдсэн ойлголт, дүрмээ боловсруулж батлах, баталсны дараа даган мөрдөх гэж хичээж буй хүүхдүүдийн тухай ч сэтгэл хөдлөн өгүүлсэн. Дотуур байрны орчин нөхцөлд хийсэн эрсдэлийн үнэлгээ, түүнийг сайжруулах хамтын ажиллагаа, үр дүнг харж баярласан мөчөө ч бидэнтэй хуваалцсан. Сумын орчинд

a shared understanding of children's rights and child protection.

Together, they have become united in their genuine commitment to promoting the well-being of children.

Leading the PIU and fully engaging with the world of children, I have experienced the greatest shift in my own attitude,” Bulgamma reflected. “I’ve realized that no action by a child—however small, naive, or innocent—is entirely wrong or beyond repair.”

The changes she describes go beyond policy implementation. Students now study in a culture of mutual respect. They are now able to discuss and understand all topics openly, honestly, and without reservation with their parent and caregivers. The community has come to recognize that the well-being of children is invaluable and must never be neglected. Local authorities have begun collaborating with a shared goal of supporting children, reflecting a positive shift in attitudes.

The project has been implemented in Darvisoum for nearly three years.

“By using the project’s training modules, methodology, and activity management, we have been able to prepare future citizens who will contribute to the development and prosperity of Darvisoum.”

Bulgamma highlighted several key achievements ‘I Support My Friends’ peer support training program, the series of step-by-step training for teachers and staff, along with the various collaborative activities and parent-led projects. This resulted in strong relationships with parents, and the positive changes in children’s attitudes and behavior.

She spoke movingly about the development of the child protection workflow chart, its implementation and the collaborative creation of and shared understanding of classroom rules.

Bulgamma spoke with genuine delight about the students who researched risk factors in the soum environment and presented their findings, to the student self-governance groups that were

эрсдэлт нөхцөлийг судлан илтгэл тавьсан суралцагчид, санаачилгаараа нэгдэн бий болсоор байгаа сурагчийн өөрөө удирдах байгууллагууд гээд олон ололт, амжилтыг бахархан дурсаж байсан юм.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн үр дүнд сургуулийн хамт олон зөвхөн хүүхэд хамгааллын мэдлэгтэй болоод зогсохгүй, хандлага, харилцаа, итгэлцэл дээр суурилсан шинэ соёл бүрдүүлж чаджээ. Энэ бол тэдний амжилтын түүх, нэг сургууль дахь нэгдмэл зорилгын биелэлт юм.

formed through their own initiative. *“By using the project’s training modules, methodology, and activity management, we have been able to prepare future citizens who will contribute to the development and prosperity of Darvi soum,” she said.*

The collaborative efforts of teachers, the support from local The the three years, this remote school community has built a new foundation based on changed attitudes, positive communication, and mutual trust.

Students have found their voices and learned to support one another. Teachers have moved from fear-based discipline to understanding and encouragement. School leaders have created systems that empower rather than simply regulate. And perhaps most importantly, parents, local authorities, and the broader community have joined together in recognizing that every child’s wellbeing matters.

АНГИЙН ДҮРМИЙГ ЗҮЙР ЦЭЦЭН ҮГЭНД “ХӨРВҮҮЛНЭ”

CLASSROOM RULES EXPRESSED AS PROVERBS

Нийслэлийн ерөнхий боловсролын 51 дүгээр сургууль 2200 гаруй суралцагчтай. 100 гаруй багш, ажилтантай. Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөлд Баянгол дүүргээс сонгогдсон хоёр сургуулийн нэг нь юм.

-Нийгмийн хөгжлийг дагаж хүүхэд их өөрчлөгддөг юм байна. Танхимаар хичээл орж байхад төдийлөн мэдэгдэхгүй байсан ч “Ковид-19” цар тахлын дараа энэ өөрчлөлтийг илүү мэдэрсэн. Багш, эцэг эх, томчууд хүүхдийн хувьсан өөрчлөлтийг гүйцэж чадахгүйгээс зөрчил үүсэж байна. Тэгвэл Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүй, аргачлалыг нутагшуулснаараа энэ бэрхшээлийг арилгаж чадлаа гэж тус сургуулийн захирал О.Мягмаржав ярьсан. Тэрээр, багш, нийгмийн ажилтан, сургалтын менежер, сүүлийн гурван жилд захирлаар, боловсролын салбарт 20 гаруй жил ажиллаж байгаа туршлагатай юм. Түүний нэмж хэлснээр, төсөл хэрэгжсэнээр сургалтын үйл ажиллагаанд оролцож буй талуудад үл ойлголцол үгүй болж, хамтын ажиллагаа эрс сайжирчээ.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн сургалт, үйл ажиллагаа нь зөвхөн хүүхдэд бус, эцэг эх, багш нар, цаашлаад хорооны Хамтарсан баг руу чиглэж, хүүхэд хамгаалал, хөгжилд тулгамдаад буй олон асуудлыг цогц байдлаар шийдсэн нь ач холбогдолтой билээ. Уг төслийн хүрээнд 51 дүгээр сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн гишүүд “Сайн эцэг эх” сургалтын сургагч багшаар бэлтгэгдэн, тус

School No. 51 in Ulaanbaatar has more than 2,200 students and over 100 teachers and staff members. It is one of two schools from Bayangol district selected to participate in Save the Children’s “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project.

“Children change significantly along with social developments. While these changes were less noticeable during in-person classes, we felt them much more strongly after the COVID-19 pandemic. Conflicts began to arise because teachers, parents, and other adults were unable to keep pace with the children’s evolving needs and behaviors. However, by introducing internationally recognized methodologies through the Save the Children’s project, we were able to address these challenges,” said School Principal O. Myagmarjav, who has more than 20 years of experience in education, including roles as a teacher, social worker, training manager, and, for the past three years, principal. She added that the project has helped eliminate misunderstandings among stakeholders in the teaching and learning process and has significantly strengthened collaboration.

The training and activities carried out under the project targeted not only children but also parents, teachers, and the local khoroо’s Multi-Disciplinary Teams (MDT), effectively addressing child protection and development issues comprehensively. As part of the project, members of School No. 51’s Parents’ Council were trained as “Safe Families” facilitators. Through repeated sessions, they reached around 1,000 parents and caregivers.

“As a result of the training, we saw real changes in parents - you could see it in their eyes. At first,

сургалтыг олон удаагийн давтамжтайгаар зохион байгуулснаар нийт 1000 орчим эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан байна. “Сургалтын үр дүнд эцэг эхчүүд маань өөрчлөгдсөн. Энэ нь харцнаас нь мэдэгддэг. Анхандаа хүүхэд хамгааллын сургалтад сууна гэхээр их л дургүй байсан. Харин сургалтын төгсгөлд нүүрэнд нь мишээл тодорч “Үнэхээр их юм мэдэж авлаа, дахиад ийм сургалт бий юу” гэдэг. “Өдрийн тал сургалтад хамрагдчихаад л буцаад явах гэж байснаа ажлаа зохицуулаад сургалтаа дуусгачихлаа. Хүүхэд болохгүй байна л гэдэг. Угтаа үр хүүхэд маань болохгүйд биш, бидний үүрэг оролцоо их байсан юм байна” гэж сургалтын дараа сэтгэгдлээ илэрхийлдэг болсон. Мөн хүүхдүүд маань ч мундаг байлаа. Бүх насны хүүхдийг зөв чиглүүлбэл үнэхээр ихийг хийж, бүтээж чадаж байна” гэж О.Мягмаржав захирал ярилаа.

Төслийн хүрээнд “Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах” сэдэвт сургалтад багш, ажилтнууд хамрагджээ. “Хүнлэг байя, ойлгоё, хүндэлье, хайрлая” аяны хүрээнд ахлах ангийн сурагчдыг хамруулсан сургалт нөлөөллийн ажил зохион байгуулсан байна. “Хүүхдийн эрх зөрчигдөхөд хаана, хэнд, хэрхэн хандах вэ?” сэдэвт үе тэнгийн сургагч багш бэлтгэх сургалтад ахлах ангийн 40 сурагч хамрагджээ. Эдгээр бэлтгэгдсэн хүүхдүүд маань сургуулийнхаа бүх сурагчдад жүжигчилсэн тоглолт, өртөөчилсөн сургалт, танилцуулгын аргаар хүүхдийн эрхийг таниулах нөлөөллийн ажлыг үе шаттай хэрэгжүүлсэн байна. Мөн “Би найзаа дэмжинэ”, “Стрессгүй сургуулийн орчинд хүүхэд бидний оролцоо” сэдвээр хөтөлбөр, сургалт тогтмол зохион байгуулагддаг болсон.

“Би найзаа дэмжинэ” үе тэнгийнхэнд чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд дунд, ахлах ангийн 125 хүүхдийг үе тэнгийн дэмжигчээр бэлтгэсэн бол тус сургуулийн өөрсдийн санаачилгаар нэмж 40 хүүхдийг сургасан байна.



many were hesitant to attend child protection sessions. But by the end, their faces lit up with smiles as they said, 'We've learned so much! Will there be more training like this?' Some who had planned to leave halfway through ended up rearranging their schedules to stay until the end. Parents often used to say, 'We are not happy with our kids,' but after the training, they realized the real issue was not the children - it was our own lack of understanding and involvement. The feedback has been overwhelmingly positive. Our students have also shown remarkable growth. When guided properly, children of all ages can truly achieve great things," said principal Myagmarjav.

Teachers and staff also participated in training on “Prevention, Early Identification, and Response to Violence Against Children.” Under the campaign titled “Let’s Be Humane, Understanding, Respectful, and Loving,” advocacy and awareness sessions were conducted for high school students. Forty senior students attended peer educator sessions on “To Whom, Where, and How to Report in Case of Child Rights Violations.” These trained students gradually developed drama performances, interactive workshops, and presentations for their peers to raise awareness of children’s rights. Regular programs are now held under the themes “I Support My

“Харилцан туршлага хуваалцах нь” хөтөлбөрийг санаачилж үүнийхээ хүрээнд Ховд аймгийн Боловсролын газрын хүсэлтээр тус аймгийн бүх сумдын сургуулийн нийгмийн ажилтан, багш нарт өөрсдийн туршлагыг цахимаар хуваалцсан байна.

Төслийн аргачлалд буй “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үлгэрчилсэн загвар”-ын дагуу сургуулийн гадна, дотно орчинд эрсдэлийн судалгаа хийж хэвшжээ.

Захирал О.Мягмаржавын хэлснээр, дотор орчинд давхрын шатны бариул нам, хүүхдүүд гулгаж тоглож байгаад унах эрсдэл бий учир шатны бариулыг өндөрлөхөөр зэхэж, зураг төслийг хийжээ. Харин гадна орчинд дугуйн зогсоол байгуулсан, хогоо ангилан ялгадаг болсон байна.

Тус сургуульд “School police” идэвхтэй ажилладаг байна. Эцэг эхчүүд гадна орчинд хүүхдийн эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажиллахаас гадна сар бүр эрсдэлийн үнэлгээ хийж, юуг, яаж засан сайжруулах боломжтой талаар саналаа сургуулийн захиргаанд уламжилдаг юм байна. Сургуулийн захиргаа үнэлгээний дагуу цаг алдалгүй арга хэмжээ авч зөрчлийг арилгаж чаддаг байна. Өдөрт 8 эцэг эх “School police”-гийн үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгаалал, эцэг эх хоорондын харилцаа гэх мэт зөвлөмжийг нийгмийн ажилтны зүгээс өгч, эргүүлийн үүргийг гүйцэтгүүлдэг байна. Мөн тухайн сургуулийн эрэгтэй багш нар 7 хоног бүр сургуулийн орчинд эргүүлийн үүрэг гүйцэтгэж, хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, аливаа эрсдэлээс сэргийлэн ажилладаг байна.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн арга зүйгээр 51 дүгээр сургуулийн анги бүлэг бүр өөрийн “Ангийн дүрэм”-тэй болсныг онцлон дурдъя. Ангийн дүрэм өмнө нь шаардсан, захирсан байсан бол одоо эерэг болжээ. Сургуулийнхаа 6-12 дугаар ангийн бүлгийн дарга нарыг тусгайлан

Friends” and “Children’s Participation in a Stress-Free School Environment.”

Within the framework of “I Support My Friends,” 125 secondary and high school students were trained as peer supporters. Additionally, on the school’s own initiative, another 40 students received similar training.

The school also launched a “Sharing Experiences” initiative - at the request of the Khovd Provincial Education Department, where they shared their experiences online with social workers and teachers from all soum-level schools in the province.

Following the “Exemplary Model of Child Protection Mechanism in General Education Schools,” which serves as the project’s guiding methodology, the school has established regular risk assessments in both its internal and external environments.

According to Principal Myagmarjav, the indoor assessment revealed that stair railings were too low, posing a risk of students slipping and falling when using the stairs. The school prepared designs to raise the railings. Outdoors, they built a bicycle parking area and introduced waste separation practices.

The School Police operate actively within the school. Parents play an important role in preventing child rights violations in outdoor areas and conduct monthly risk assessments, submitting recommendations to the school administration. The administration promptly responded, ensuring issues are resolved quickly. Each day, eight parents take turns serving as School Police. During their duty, they receive guidance from the school’s social worker on ensuring children’s safety, promoting child protection, and fostering positive communication between parents. In addition, male teachers at the school carry out weekly patrols around the school grounds to ensure student safety and prevent potential risks.

One creative initiative under the project methodology is the introduction of “Classroom Rules.” Previously rules were strict and authoritarian,

урьж уулзан, “Ангийн дүрмийг хэрхэн эерэг байдлаар гаргах вэ” сэдэвт арга зүйн зөвлөгөө, сургалтыг зохион байгуулжээ. Ангийн дарга нар сургалтад хамрагдсаны дараа ангиараа ангийн дүрмээ хэлэлцэн гаргаж хэвшжээ. Төслийн багийн гишүүн, монгол хэлний багш Энх-Ундраа санаачлан, бусад багш нарын оролцоотойгоор бүх ангийн дүрмийг зүйр цэцэн үгээр илэрхийлж хувиргахаар бэлтгэж байна. Ангид сурагчид, багш, эцэг эхийн хамтран гаргасан ангийн дүрэм байхаас гадна, зүйр цэцэн үгээр илэрхийлсэн дүрэм байх аж. Энэ нь монгол ёс уламжлалаа өвлүүлэх, хэлний яруу тансагийг мэдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Тус сургуульд энэ мэт сайн жишээ олон байна. Өнгөрсөн намар “Итгэлтэй утас”-ыг байршуулж, сар бүрийн төлбөрийг сургуулиас хариуцдаг болсон байна. Хүүхэд эцэг эхтэйгээ болон Хүүхэд хамгааллын багийн аль нэг гишүүнтэй үнэ төлбөргүй ярих, эрхийн зөрчлийг цаг алдалгүй мэдээлэх боломжтой юм. Түүнчлэн сургуулийн үйлчлэгч ажилтнууд “шар тэмдэг” хэрэглэдэг болжээ. Сургуулийн коридорт гар утас цэнэглэх боломжийг бүрдүүлснээс гадна сурагчид гэрээсээ авчирсан хоол хүнсийг халааж хэрэглэх төхөөрөмжийг аюулгүй байдлыг бүрэн хангасны үндсэн дээр байрлуулсан байна. Түүнчлэн сургууль руу нэвтэрч буй бүх эцэг эх, иргэд, зочдыг бүртгэл хөтлөн “Зочин” тэмдэгтэй болгожээ. Энэ нь хүүхдийн аюулгүй байдлыг хангахад түлхэц өгсөн байна.

Хүүхдийн хөгжил, хамгааллын ажлуудыг дан ганцаараа биш, нэгдэл, бүлгээрээ хамтарч энэ мэт үр дүнтэй хэрэгжүүлж байгаа юм. Энэ нь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс бэлтгэгдсэн сургагч багш нарын санаачлагын нөлөө ажээ. Хорооны хамтарсан багтай илүү өргөн хүрээнд хамтран ажиллах болсон байна. Сургуулийн хүүхэд хамгааллын баг нь 2 дугаар хорооны хамтарсан багтай хамтран ажиллах гэрээ байгуулжээ. Хамтран ажиллах ажлын төлөвлөгөө гаргаж, бүгдийг

but now they are positive and encouraging. The school organized a special meeting and training for class presidents from grades 6 to 12 on “How to Develop Classroom Rules Positively.” After the training, class presidents facilitated discussions within their own classes to create and adopt their rules.

A project team member and Mongolian language teacher, Enkh-Undraa, collaborated with colleagues to introduce an innovative idea – to express each classroom's rules through traditional Mongolian proverbs and wise sayings. As a result, every classroom now displays the jointly developed rules created by teachers, parents, and students, but also a poetic version expressed through proverbs. This creative approach preserves Mongolian cultural heritage and introduced students to the beauty and wisdom of their language.

The school has introduced many good practices. Last Autumn, a “Trust Phone” was installed, with the monthly service fee covered by the school, children can call their parents or members of the school's Child Protection Team, free of charge to report any rights violations without delay. Cleaning and maintenance staff have started using “yellow signs” as part of their safety protocol. The school installed charging stations for mobile phones in the corridors and provided food heating devices for students who bring food from home, ensuring comfort and safety. Furthermore, all parents, visitors, and guests entering the school are now registered and provided with a “Visitor” ID card, greatly enhanced child safety.

Child development and protection efforts are effectively implemented through teamwork and collaboration rather than individual efforts. These successes have been largely driven by the initiative of the trainers under the project. The school has also expanded cooperation with the local khoroo's Multi-Disciplinary Team. The school's Child Protection Team signed a formal cooperation agreement with the MDT of Khoroo No. 2. Principal Myagmarjav emphasized that the project played a crucial role in developing a

шинээр эхлэхэд “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн оролцоо, хувь нэмэр их байсан талаар захирал О.Мягмаржав ярилаа.

Тус сургуулийн үүдээр ороход ханын дагуу том дэлгэц байрлуулсан нь харагдана. Энэ дэлгэцээр “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн үр дүн, сургалт, нөлөөллийн ажлуудыг сурталчлахаас гадна сургуулийн Хүүхэд хамгааллын багийн гишүүдийг танилцуулдаг байна. Түүнчлэн дасгал хөдөлгөөн хийх зааварчилгаа, сурагч өөрийгөө хэрхэн, яаж халамжлах талаар “Хүнлэг байя” нөлөөллийн аяны зөвлөмжүүдийг хүүхдийн нас, насны онцлогт тохирсон байдлаар өдөр бүр тогтмол түгээдэг аж.

Энэ мэт олон ажлын үр дүнд тухайн хүүхэд эрх зөрчигдвөл хаана, хэнд, хэрхэн хандахаа мэддэг болжээ. Өмнө нь эрхийн зөрчил гарахад “Надад хамаагүй” гэж нуудаг байсан бол одоо өөрөө биш юм гэхэд найзынх нь эрх зөрчигдвөл тэр даруй мэдэгддэг болжээ. “Энэ бол хов биш, өөрийнхөө төдийгүй найз нөхдийнхөө эрх ашгийг хамгаалж, тусалж байгаа хэрэг” гэдгийг ойлгож, сургуулийн хамгааллын багт хандаж, асуудлаа шийдвэрлүүлж, зөвлөгөө мэдээлэл авч хэвшиж байгаад туйлын баяртай байна гэж захирал О.Мягмаржав хэлсэн. Тэрээр мөн “Энэ төслийг хэрэгжүүлэхэд арга зүйн үнэтэй дэмжлэг үзүүлсэн Хүүхдийг Ивээх Сангийн хамт олондоо гүн талархаж байгаагаа илэрхийлье ” гэсэн юм.

collaborative work plan and building everything from the ground up.

Upon entering the school, there is a large screen mounted on the wall that showcases project outcomes, training sessions, and advocacy activities while introducing the members of the school's Child Protection Team. It displays physical exercises and daily messages from the “Let's Be Humane” campaign offering age-appropriate guidance for students on self care.

As a result of these continuous efforts, students now know exactly where, to whom, and how to report if their rights are violated. In the past, children might have thought, “It's not my concern,” and stayed silent. Now, even if they are not directly affected, they immediately report any violations of their friends' rights.

“They understand that this is not gossip, but an act of protecting and supporting not only their own rights but also those of their friends. They have become accustomed to approaching the school child protection team, resolving issues, and seeking guidance and information, which makes us extremely happy. I would like to express our deepest gratitude to the Save the Children team for their invaluable methodological support in implementing this project,” said Principal O. Myagmarjav.



БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ ТӨСЛИЙН АРГА ЗҮЙГ ТҮГЭЭНЭ

SCALING SUCCESS: BAYANZURKH DISTRICT EXPANDS CHILD PROTECTION MODEL

Нийслэлийн Баянзүрх дүүрэгт ерөнхий боловсролын 74 сургууль, үүнээс төрийн өмчийн 38, хувийн өмчийн 34 сургууль үйл ажиллагаа явуулж байна. 2025 оны хичээлийн жилд эдгээрт нийт 4220 багш ажиллаж, 101,295 сурагч суралцдаг ажээ.

Хүүхдийг Ивээх Сан “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг 2023-2025 онд хэрэгжүүлэхэд нийслэлийн Баянзүрх дүүргээс ерөнхий боловсролын 33, 48 дугаар сургуулиуд сонгогдож, тус төсөлд хамрагдсан билээ.

Энэ төсөл нь дээрх хоёр сургуулийн багш, ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчид, сурагчид, хорооны Хамтарсан багууд хамрагдаж, сургуулийн хүүхэд хамгааллын баг, хорооны хамтарсан багийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр орууллаа.

Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах чиглэлд ахиц дэвшил гарчээ. Төсөл хэрэгжсэнээр сурагчид чадавхижж, багш нар арга зүйгээ сайжруулснаас гадна хүүхдийн

When a program works, the most important question becomes: How do we bring this success to everyone who needs it? In Bayanzurkh District of Ulaanbaatar, they have a clear answer.

After witnessing transformative results at two pilot schools, School No. 33 and School No. 48, over three years, the Bayanzurkh District Education Department has committed to expanding a comprehensive child protection model to all 74 general education schools in the district, 38 public and 34 private schools that employ 4,220 teachers and serve 101,295 students in the 2025 academic year.

It represents a significant outcome: a district government taking full ownership of child protection, committing to localize and sustain proven methodology, and creating a model for how successful pilot programs can achieve lasting, system-wide impact.

*“The Bayanzurkh District Education Department now aims to disseminate the results and best practices achieved through the project to all other schools in the district, marking an important step forward.”*said Lkhajav, Child Development and

эрхийн зөрчлийг мэдээлэх, илрүүлэх байдал эрс нэмэгдсэн байна. Хүүхдийн оролцоо, идэвх санаачилга урьд байгаагүйгээр өрнөв. Эцэг эх, асран хамгаалагч нарт “Сайн эцэг эх” сургалтыг явуулснаар сургууль, эцэг эх хоорондын харилцаа хандлага нь эергээр өөрчлөгдөж байна. Тэднийг сургуулийн болон хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд татан оролцуулснаар олон өөрчлөлт гарчээ. “Багш нарын мэргэжлийн чадвар өссөн. Төслийн хүрээнд дээрх хоёр сургуульд шаардлагатай гарын авлага, материал болон техник хэрэгслээр бүрэн хангасан нь ач холбогдолтой байлаа” гэж Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсийн хүүхдийн хөгжил хамгаалал хариуцсан мэргэжилтэн Н.Лхаажав ярилаа.

Түүний нэмж хэлснээр, Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсээс төслийн хүрээнд хүрсэн үр дүн, туршлагыг дүүргийнхээ бусад бүх сургуульд түгээн дэлгэрүүлэхийг зорьж байгаа юм байна. Энэ бол үнэхээр чухал алхам билээ. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагаас санаачлан Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэн хоёр сургуулийн туршлагад үндэслэн, цаашид хүүхэд хамгааллын чиглэлээр модуль сургалтуудыг үе шаттайгаар явуулж, төслөөс уламжлагдан ирсэн арга зүйг нутагшуулна гэсэн үг юм. Дүүргийн зүгээс тус ажлыг хариуцан эхлүүлсэн байна.

Одоогоор манай дүүргийн 18 сургууль хүүхэд хамгааллын “Мэдээллийн хэлхээ”-тэй болоод байна. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөлд хамрагдсан хоёр сургуулиар дамжуулж бусад нь сайн туршлага, гүн мэдлэг, ач холбогдол бүхий арга зүйд суралцах эхний алхам ийнхүү эхэлж байна. Хүүхдийг Ивээх Сангаас гаргасан гарын авлага, материал нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, манай нөхцөлд хэрэгжих бүрэн боломжтой, зохиогчийн эрх тусгайлан шаардахгүй зэрэг давуу талтай. Харин гарын авлага, материалыг олшруулан түгээж, дахин ашиглахдаа Хүүхдийг Ивээх Сангийн нэрийг

Protection Specialist at the Bayanzurkh District Education Department.

The Foundation of Success in Two Schools

Between 2023 and 2025, Save the Children’s “Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia” project selected two schools from Bayanzurkh District—School No. 33 and School No. 48. The three-year implementation provided time to test approaches, refine methods, and demonstrate results.

The project engaged every level of the school community, teachers and staff, parents and caregivers, students, and the khoroo’s Multi-Disciplinary Team (MDT). This comprehensive approach ensured that child protection wasn’t the responsibility of just one person or department, but a shared commitment across the entire ecosystem surrounding children.

Building Collaborative systems

One of the project’s most significant contributions was strengthening collaboration between the schools’ Child Protection Team and the khoroo MDT. Previously, these groups often worked independently. The project created structures for systematic coordination, ensuring that when a child needed help, school-based and community-based services worked together seamlessly.

As part of the project, both schools were fully equipped with the necessary manuals, materials, and technical tools. These resources proved highly beneficial, that teachers, administrators, and protection team members could use immediately in their daily work.

Measurable Progress

The results at Schools No. 33 and No. 48 demonstrated the model’s effectiveness. Notable progress was achieved in preventing, identifying, and responding to violence against children. The reporting and identification of child rights violations have increased substantially because teachers and students gained the knowledge

заавал дурдах ёстой юм гэж мэргэжилтэн Н.Лхаажав нэмж өгүүлэв.

“Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл нь Боловсролын багц хууль, Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн тухай хууль, дүрэм журмыг амжилттай хэрэгжүүлэхэд томоохон хөшүүрэг болж, арга зүй, мэдлэгээр хангасанд талархалтай байдаг. Миний хувьд “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн бүх сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа ахиулсандаа баяртай байна. Эрхэлж буй албан тушаалынхаа дагуу дүүргийнхээ сургуулиудад хүүхэд хамгааллын чиглэлээр арга зүйн туслалцаа үзүүлэн илүү үр дүнтэй ажиллах боломжтой болсондоо талархаж байна” гэж нийслэлийн Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсийн хүүхдийн хөгжил хамгаалал хариуцсан мэргэжилтэн Н.Лхаажав сэтгэл дүүрэн өгүүлсэн юм.

and confidence to recognize and report concerns that previously went unaddressed. Children’s participation and initiatives became more active and meaningful than ever before as students’ learned they had agency in creating safe, supportive school communities.

Transforming Family Engagement

The “Safe Families” training for parents and caregivers has proved particularly transformative positively changing communication and attitudes between schools and families. Parents who attended the training didn’t just gain information—they shifted how they understood their role in their children’s development and protection.

Their active involvement in school and child protection activities has led to many positive changes. Parents became partners rather than outsiders, working collaboratively with schools to address concerns and create supportive environments for all children. Teachers’ professional capacities have also improved through ongoing training and the practical experience of implementing new approaches..

Early Momentum: Adoption Beyond the Pilot

Even before formal expansion began, the success of the pilot schools started to spread. Currently, 18 schools in Bayanzurkh District have established a Child Protection Information Workflow Chart based on the model used at Schools No. 33 and No. 48. Schools are proactively seeking to learn from the pilot schools’ effective methods, deep knowledge, and best practices—even without formal district mandates or additional funding.

The Expansion Plan: District-Led Sustainability

Based on the pilot schools’ experience, the district government has initiated a phased process to conduct modular trainings on child protection throughout Bayanzurkh District. This work will

be led by the district authorities. That ensures sustainability and single the project timeline.

Resources for Success: Materials That Work

The manuals and materials developed by Save the Children are internationally recognized and well-suited for local implementation. Importantly they can be freely used without requiring special copyright permissions, though Save the Children's name must be clearly acknowledged when reproducing or distributing these materials.

This open approach to knowledge sharing means that Bayanzurkh District—and any other district that wants to learn from this experience—can access proven tools without barriers. The materials include practical guidance on topics ranging from identifying signs of abuse to facilitating peer support programs to engaging parents effectively.

Legal Framework and Methodological Support

The project has served as a major catalyst in effectively implementing Mongolian Laws on Education, as well as laws and regulations related to child protection and child rights. While the legal framework existed the project provided essential knowledge and methodological support for translating policy into practice.

For Lkhajav herself, the project represented professional growth that now benefits the entire district. *"I am happy to have participated in all trainings under this project, which greatly enhanced my knowledge and skills," she reflects. "In my current position, I am now able to provide methodological support to schools in the district and contribute more effectively to child protection work,"*

Her enhanced capacity as the district's Child Development and Protection Specialist means she can provide expert guidance as other schools adopt the model. She becomes a bridge between the pilot schools' experience and the 56 schools still beginning their journey—translating lessons learned into practical advice, troubleshooting challenges, and ensuring quality implementation.

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨХ МИНИЙ ЗАМНАЛ

MY JOURNEY FOR CHILDREN

Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд хэрэгжиж байгаа билээ.

Тус сургуулийн эцэг эхийн төлөөлөл М.Оюунсүрэн бол хүүхдийн төлөөх ажил үйлд амьдралаа зориулсан хүн юм. Тэрээр, цагдаагийн байгууллагад хүүхдийн байцаагчаар олон жил ажилласан туршлагатай. Эдүгээ Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн Эцэг эхийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, идэвхтэй гишүүн, мөн тус сумын “Хүүхдийн элч” юм.

“Би өмнө нь хүүхэд хамгааллын талаар хангалттай сайн мэдлэгтэй, гэр бүлийн хүрээнд үр хүүхдээ сайн ойлгож, хамгаалж, аюулгүй байлгадаг гэж бодож байлаа. Мөн энэ мэдлэг, чадвараа бусадтай хуваалцаж чаддаг гэж итгэдэг байсан. Гэвч би “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн үйл ажиллагаанд оролцсоноор хүүхэд хамгаалал, хүүхдийн эерэг хүмүүжил, эцэг эхийн үүрэг, хариуцлага гэж юу болох талаар огт өөр өнцгөөс харж, шинэ мэдлэг, мэдээлэлтэй болж чадлаа. Ялангуяа, эцэг эхчүүд бид стрессгүй байж, өөрийгөө халамжилж чадвал үр хүүхдэдээ илүү сайнаар нөлөөлж, ирээдүйн сайн иргэнийг төлөвшүүлж чадна гэдгийг ойлгосон” гэж М.Оюунсүрэн ярьсан юм.

М.Оюунсүрэн төслийн модуль сургалтууд болох “Сурагчдын сурч хөгжих үйл явцыг эрхэд суурилсан хандлагаар дэмжих нь”, “Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах арга зүй”, “Сайн эцэг эх” сургалтууд, “Ерөнхий боловсролын сургуулийн эцэг эх, асран хамгаалагчдын ажиллах жишиг удирдамж” “Хүнлэг байя” аян зэрэг сургалт болон нөлөөллийн олон үйл ажиллагаанд хамрагдсанаар хүүхэдтэй

Oyunsuren, has dedicated her life to working for children. She has many years of experience as a child investigator in the police force in Khovd province. She had seen firsthand the consequences when child protection fails. She was confident in her knowledge about child protection, when she joined Save the Children Hong Kong, the ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia project at School No. 1 of Jargalant soum, but realized how much she still had to learn.

Today, Oyunsuren serves as the secretary and an active member of the Parents’ Council at the school and holds the role of the soum’s “Child Ambassador.”

“Previously, I believed I had sufficient knowledge about child protection and that, within my family, I understood, protected, and kept my children safe,” Oyunsuren recalled.” I also thought I could share this knowledge and these skills with others.

Through modules on ‘Promoting a Rights-Based Approach in Students’ Learning and Development Processes,’ ‘Prevention, Early Identification and Response to Violence Against Children,’ ‘Safe Families,’ the ‘Exemplary Guideline for School’s Parents’ Council,’ and the ‘Let’s Be Humane’ campaign Oyunsuren gained an entirely new perspective on child protection and positive parenting, “I realized that if we as parents can remain stress-free and take care of ourselves, we can have a greater positive influence on our children and help raise responsible citizens of the future,” said Oyunsuren.

Oyunsuren gained deeper knowledge about interacting with children, understanding their needs, and the roles and responsibilities of parents. She also gained experience in sharing her knowledge and skills with other parents, taking initiative to protect children’s rights, and creating a safe environment in schools.

харилцах, тэднийг ойлгох, эцэг эхийн үүрэг хариуцлагын талаар илүү их мэдлэгтэй болсон байна. Тэрээр, мэдлэг, туршлагаа бусад эцэг эхчүүдтэй хуваалцаж, хүүхдийн эрхийг хамгаалах, сургуульд аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлд санаачилга гарган ажиллах туршлагатай болжээ.

-Энэ төслийн хувьд хүнийг нэг сургалтад сургаад орхидоггүй, тэр хүнээ бүрэн сургаж, мэдээллээр хангаж, хамт зааж чиглүүлж өгдөг. Төслийн сургалтууд дотроос “Сайн эцэг эх” сургалт маш их таалагдсан. Би энэ сургалтаас сурч мэдсэнээ бусад эцэг, эхчүүдэд дамжуулан түгээсэн юм. Эцэг, эхчүүд маань сургалтад идэвхтэй оролцсонд талархаж байна. Би “Сайн эцэг эх” сургалтын ач холбогдлыг ингэж дүгнэж байна. Үүнд:

- Энэ сургалтын агуулга, эцэг эхчүүдэд өгч байгаа мэдээлэл өгөөжтэй, сурах зүйл ихтэй
 - Сургалтын арга зүй маш сайн, хүмүүст ойлгуулахад энгийн
 - Маш сайн сургалтын танилцуулга бэлтгэж өгсөн нь сургалт явуулахад амар байсан. Мөн их урамтай байлаа гэж М.Оюунсүрэн ярилаа. Тэр нэмж хэлэхдээ, “Олон эцэг эх над шиг ийм мэдлэг, чадвар эзэмшиж, өөртөө болон бусдад үлгэрлээсэй гэж хүсэж байна гэсэн юм.
- “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн сургалтын үр дүнд эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ илүү харилцан ойлголцох болж, идэвх оролцоо нь нэмэгдсэн билээ. Хүүхдүүд эрхээ мэддэг болж, аюулгүй байдлынхаа талаар илүү мэдээлэлтэй болсон. Сургууль ч мөн хүүхэд хамгааллын талаар илүү анхаарал хандуулж, бодлогын хэмжээнд ажиллаж эхэлсэн нь төслийн үр дүн байлаа.

Becoming a Student Again

Among the project's training, I found the 'Safe Families' training particularly meaningful. Oyunsuren said: “In this project, participants are not simply trained in a single session and left on their own; each person receives comprehensive training, provided with support, and is guided throughout the process.” She summarized the 'Safe Families' training was:

- Provided rich content and valuable information for offering much to learn.
- Used excellent methodology which was easy for participants to understand.
- Used well-prepared training materials which made it easier to facilitate the sessions and were very encouraging.


She added, “I hope that many parents, like me, acquired the knowledge and skills to serve as positive examples for themselves and others.”

Parents became more communicative and understanding with their children, and their engagement and participation increased. Children understand their rights and gained greater knowledge about their safety. Schools also began to place greater emphasis on child protection and address it at the policy level—outcomes directly attributable to the project.

Putting Knowledge into Action

Oyunsuren, together with members of the Parents' Council, initiated and implemented two projects 'Let's Learn to Spend Time with Our Children' and 'We Were Also Children,'

Both initiatives brought positive changes.. Parents became more communicative and understanding with their children. Engagement and participation in school activities increased no-



М.Оюунсүрэн нь “Хүүхдэдээ цаг гаргахад суралцъя”, “Бид бас хүүхэд байсан” төслүүдийг Эцэг эхийн зөвлөлийн бусад гишүүдтэйгээ хамтран санаачлан хэрэгжүүлж, сургуулийн олон эцэг эхчүүдэд эерэг өөрчлөлт авчрахад нь нөлөөлж чадсан юм. Мөн хүүхэдтэйгээ илүү ойр дотно харилцаж, тэдний санаа бодлыг сонсож, асуудлыг хамтдаа шийдвэрлэх арга барилд суралцсан байна. Түүнчлэн найз нөхдөд нь тулгарсан бэрхшээлийг сонсож, тэдэнд зөвлөдөг болсон. Өөртөө илүү итгэлтэй болж, гэр бүлийн уур амьсгал илүү халуун дулаан болсон гэж ярьсан.

“Хүүхэд хамгаалал бол зөвхөн нэг багш, аав ээж, нийгмийн ажилтны ажил биш, харин бүх хүний оролцоог шаарддаг. Төслийн багийн дэмжлэгээр бид хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангаж, тэдэнд өөртөө болон ирээдүйдээ итгэх итгэл өгч байгаа нь үнэлж баршгүй том үр дүн юм. Энэ төсөл олон гэр бүлийн амьдралд эерэг өөрчлөлт авчирч байгаа тул илүү өргөжиж, бусад сургууль, гэр бүлд хүрээсэй гэж хүсэж байна. Ихэнх эцэг эхчүүд хүүхдийнхээ буруу хандлага, хүмүүжил, төлөвшлийг бусдын нөлөөнөөс үүдэлтэй гэж үздэг. Хүүхдийнхээ гаргаж буй үг, үйлдлийг гэр бүл дотроосоо, өөрөөсөө эрж хайх хандлагад суралцах хэрэгтэй. Ер нь эцэг эхчүүдийн харилцаа хандлага ямар байна, хүүхэд яг л тийм хүмүүжил, үлгэр дуурайлал авдаг учир энэхүү төсөл хүүхэдтэй хэрхэн харьцах, аливаа асуудлыг нь хэрхэн шийдвэрлэх, хүүхдийг хэрхэн хүмүүжүүлэх вэ гэсэн асуултуудад маш ойлгомжтой хариу өгч чадсан юм. Аливаа хүнд ойлгомжтой мэдээлэл, зөвлөгөө бэлтгэн боловсруулж, сургалтууд зохион байгуулсан нь ач холбогдолтой байсан. Цаашид энэ төслийг өөр олон сургуулиудад хэрэгжүүлээсэй” гэж М.Оюунсүрэн хэлсэн.

М.Оюунсүрэнгийн түүх нь зөвхөн нэг хүний амжилт биш, харин олон гэр бүлийн амьдралд эерэг өөрчлөлт авчирсан, хүүхдүүдийн аюулгүй орчин бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан түүх юм. Тэрээр, өөрийн мэдлэг, туршлагаа бусад эцэг эхчүүдтэй хуваалцаж, тэдэнд үлгэр дуурайлал болж, урам өгч чадсандаа баяртай байсан билээ.

ticeably. Children, in turn, became more aware of their rights and gained greater knowledge about their own safety.

Oyunsuren’s developed closer, more caring relationships with her own children, learning to listen to their thoughts and solve problems together. *“I have become more confident in myself, and the atmosphere in our family has become warmer and more supportive,”* she said.

The project taught Oyunsuren a lesson that her previous experience had not. *“Many parents tend to attribute their children’s wrong attitudes, behavior, or development to the influence of others. We need to learn to look within our families and ourselves to understand the reasons behind our children’s words and actions.”*

Children, she now understood adopt the attitudes and behaviors they see in their parents. This meant that creating safe environments for children required more than policies and procedures—it required parents who could model the behavior and emotional health they wanted to see in their children.

“Child protection is not the responsibility of just one teacher, parent, or social worker—it requires the involvement of everyone” Oyunsuren emphasized. *“This project has provided very clear guidance on how to interact with children, solve their problems, and support their upbringing.”* Children have gained confidence not just in their physical safety, but in their right to be heard and respected.

With the support of the project team, we are able to ensure the safety of children and help them gain confidence in themselves and their future, which is an invaluable outcome. Since this project has brought positive changes to many families’ lives, I hope it will expand and reach other schools and families as well.

She takes pride in sharing her knowledge and experience with other parents, serving as a role model and inspiring them to look at child protection in a new way, making positive changes to many families and a valuable contribution to creating safe environments for children

Her story is not just the success of one individual; it is a story that has brought .



ТАЛАРХАЛ

REFLECTION

Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга
М.Цогзолмаа

M.Tsogzolmaa, Director of the General Education Policy and Regulation Department, Ministry of Education

Хүүхэд бүрийн эрхийг хамгаалж, тэднийг хүчирхийллээс ангид, айдасгүй, аюулгүй орчинд сурч, хөгжих боломжийг бүрдүүлэх нь боловсролын салбарын нэн тэргүүний зорилт билээ. Энэ зорилгод хүрэхийн тулд дан ганц нэг салбар бус олон нийтийн хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, мэргэжлийн дэмжлэг шаардлагатай.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд цэцэрлэг, сургуулийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчинд сурч, хөгжих боломжийг бүрдүүлэх, хүүхдийн хөгжил төлөвшил, хамгаалалд нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, боловсролын сургалтын байгууллага, эцэг эх, асран хамгаалагч зэрэг талуудын оролцоо, түншлэлийн асуудлыг тусгайлан зохицуулсан.

Боловсролын хувирган өөрчлөлт, цахим сургалтын системийн хөгжил, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, түүнчлэн сургуулийн орчин дахь дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт зэрэг нөхцөл байдлын улмаас хичээл сургалтын зохион байгуулалтад гарч буй өөрчлөлт нь хүүхдийн сурч боловсрох эрх төдийгүй суурь эрх зөрчигдөх, ялгаатай байдлыг нэмэгдүүлэх нөхцөл үүсэж байгаад бид анхаарал хандуулж байна.

Protecting the rights of every child and ensuring that they can learn and develop in an environment free from violence, fear, and danger is a top priority for the education sector. Achieving this goal requires not only the efforts of a single sector but also the active collaboration of the wider community, social partners, and professional support.

The Law on Pre-School and General Education specifically provides for ensuring child safety in kindergartens and schools, creating opportunities for children to learn and develop in a healthy, safe, and protected environment, and fostering the participation and partnership of local self-governing and administrative bodies, educational institutions, parents, and caregivers in supporting children's development, growth, and protection.

Changes in the organization of teaching and learning are occurring due to educational reform, the development of digital learning systems, unexpected or force majeure events, and situations such as bullying and discrimination within the school environment. We are closely monitoring these changes, as they not only affect children's right to education but also risk violating their fundamental rights and increasing inequalities.

The implementation of the 'Establishing School-Based Child Protection Mechanism in Mongo-

Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэлийн санхүүжилттэйгээр “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжсэн нь энэхүү зорилгод хүрэх бодит алхам байлаа. Бид төслийн хүрээнд сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагч, багш, сургуулийн хүүхэд хамгааллын баг, хороодын Хамтарсан багийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн шат дараатай сургалт, нөлөөллийн ажлууд амжилттай зохион байгуулсны үр дүнд төсөлд хамрагдсан ерөнхий боловсролын 14 сургуульд олон үр дүн гарсныг дурдахад таатай байна.

Хүүхдийн сурч боловсроход эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо хамгийн чухал. Төсөлд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиуд эцэг эх, асран хамгаалагчдын зөвлөлөө шинэчлэн байгуулж, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг шинэ түвшинд хүргэхэд жишиг загварыг бий болгож байна.

Энэхүү төслийн үр дүнд бий болсон ололт амжилтууд нь зөвхөн нэг төслийн үр дүн бус боловсрол дахь хүүхэд хамгааллыг сайжруулах, өөрчлөлт авчрахын төлөөх хамтын ажиллагааны бодит илрэл юм.

Боловсролын яамны зүгээс энэхүү санаачилгыг дэмжин ажилласан бүх талуудад талархал илэрхийлж, цаашдын үйл ажиллагаанд амжилт хүсье.

lia'project, funded by Save the Children , represented a concrete step toward addressing these challenges and achieving this goal.

Within the framework of the project, we successfully organized a series of trainings and advocacy activities aimed at protecting children's rights in the school environment, preventing risks, and strengthening the collaboration of parents and caregivers, teachers, schools' child protection teams, and Multi-Disciplinary Teams (MDTs) at the khoroo level. As a result, it is gratifying to note that the 14 general education schools participating in the project have achieved numerous positive outcomes.

Parents' and caregivers' involvement is essential to children's learning and development. The general education schools participating in the project have restructured their Parents' Councils, creating an exemplary model that elevates child protection activities to a new level .

The achievements of this project are not merely the outcomes of a single initiative; they serve as tangible evidence of collaborative effort aimed at strengthening child protection and driving meaningful change in the education sector.

The Ministry of Education expresses its sincere gratitude to all parties who supported this initiative and wishes them continued success in their future endeavors.



ТАЛАРХАЛ

REFLECTION

Нийслэлийн Боловсролын газрын Хүүхэд хөгжил, хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мөнх-Эрдэнэ

B.Munkh-Erdene, Senior Specialist for Child Development and Protection, Metropolitan Education Department of Ulaanbaatar

Нийслэлийн Боловсролын газар боловсролын олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлж, оюуны өндөр боловсролтой, ёс суртахуунтай, эрүүл чийрэг, өрсөлдөх чадвартай иргэнийг төлөвшүүлэх эрхэм зорилготой ажилладаг.

Хүүхэд сургуулийн орчинд хамгаалагдах нь тун чухал билээ. Бид тэдний эрхийг хамгаалж, аюулгүй, эерэг орчинд өсөж хөгжих боломжийг бүрдүүлэх үүрэг, зорилготой. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг хэрэгжүүлсэн нь энэхүү зорилгыг хэрэгжүүлсэн бодит алхам байлаа.

Төслийн үр дүнд сургуулийн орчинд сургуулийн хүүхэд хамгааллын багийн ажил төлөвшин тогтворжиж, багш, ажилтан, эцэг эх, хүүхдүүд болон хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, хандлага, оролцоо мэдэгдэхүйц сайжирсан юм. Ингэснээр зөвхөн нэг удаагийн үйл ажиллагаа бус, харин тогтвортой, уялдаа холбоотой, үр дүнтэй хамтын ажиллагааны шинэ соёл бий болгожээ.

Үе тэнгийн дэмжигч хүүхдүүд, Эцэг эхийн зөвлөл зэрэг оролцоонд суурилсан жишиг загварууд нь сургуулийн орчинд хүүхдэд

The primary goal of the Metropolitan Education Department of Ulaanbaatar is to improve the quality and accessibility of education and to nurture citizens who are highly educated, morally responsible, healthy, and competitive by providing equitable, accessible, and high-quality services in line with international trends in education development.

Ensuring that children are protected within the school environment is of utmost importance. We have the responsibility and commitment to safeguard their rights and create opportunities for them to grow and develop in a safe and positive environment. The implementation of the ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project toward establishing a strong foundation for realizing this goal.

As a result of the project, the work of schools’ child protection teams became more organized and stable, and the knowledge, attitudes, and participation of teachers, staff, parents, students, and Multi-Disciplinary Team members improved significantly. This fostered not just a one-time activity, but a sustainable, coordinated, and effective culture of collaboration.

Exemplary models involving the participation of peer supporters, along with Parents’ Councils, have made a significant contribution to creating a child-friendly and safe school environment. The

ээлтэй, аюулгүй орчинг бүрдүүлэхэд үнэт хувь нэмэр оруулсан байна.

Энэхүү номд багтсан амжилтын түүхүүд нь зөвхөн нэг төслийн үр дүн биш, харин хамтын хүч, итгэл, хариуцлагын үнэ цэнийг илтгэх бодит жишээ юм. Та бүхнийг эдгээр түүхээс урам зориг авч, хүүхэд бүрийн эрхийг хамгаалах үйлсэд хамтран оролцохыг урьж байна.

success stories featured in this publication are not merely the results of a single project; they serve as tangible examples of the value of collective effort, trust, and responsibility. We invite you to draw inspiration from these stories and actively engage in efforts to protect the rights of every child.

ТАЛАРХАЛ

Хүүхдийг Ивээх Сан 2023-2025 онд Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг Улаанбаатар хотын Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг болон Говь-Алтай, Ховд аймгийн 14 сургууль, 14 хамтарсан багт амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Энэхүү төслийн ололт, туршлагыг өгүүлсэн амжилтын түүхийн ном хэвлэгдэж, санхүүжүүлэгчид, хамтрагчид болон олон нийтэд хүрч байна. Хүүхэд хамгааллын механизмыг нийслэл хот болон орон нутагтаа хөгжүүлж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах хамтын ажиллагааны шинэ загвар бий болгож, төслөө амжилттай хэрэгжүүлсэн багийн үе үеийн гишүүдэд гүн талархал илэрхийлье.

Ж.Батцэцэг

Э.Оюунмаа

Ч.Мөнгөнтуяа

Г.Цолмон

П.Цэдэндamba

Н.Бүрэнжаргал

Ц.Тошлой

Ц.Цогзолмаа

Э.Цолмон

Э.Анудар

М.Эрдэнэбилэг

Л.Дэлгэржаргал

Д.Болормаа

ACKNOWLEDGEMENT

Save the Children successfully implemented the ‘Establishing School-Based Child Protection Mechanism in Mongolia’ project from 2023 to 2025, funded by Save the Children Hong Kong, in 14 schools and 14 Multi-Disciplinary Teams across Khan-Uul, Bayangol, Chingeltei, Sukhbaatar, and Bayanzurkh districts of Ulaanbaatar, as well as in Govi -Altai and Khovd provinces. A publication highlighting the achievements and experiences of the project has been produced and shared with funders, partners, and the public.

We extend our sincere gratitude to the dedicated members of the project team who successfully implemented the initiative, strengthened child protection mechanisms in the capital and provinces, and established a new collaborative model for the prevention, early identification, and response to violence against children.

J. Battsetseg

E. Oyunmaa

Ch. Munguntuya

G. Tsolmon

P. Tsedendamba

N. Burenjargal

Ts. Toshloi

Ts. Tsogzolmaa

E. Tsolmon

E. Anudar

M. Erdenebileg



L. Delgerjargal



D. Bolormaa





Save the Children

МОНГОЛ ДАХЬ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН
SAVE THE CHILDREN IN MONGOLIA


 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона
төвийн 4-р давхар
 +976+11-329365, 11329371
ISBN дугаар: 978-9919-9209-5-1

 Ulaanbaatar city, Chingeltei district, 1st khoroo, 4th floor of
Arizona Center
 +976-11-329365, 11329371
ISBN 978 9919 9209 5 1

 www.savethechildren.mn

 Save the Children in Mongolia

 Save the Children MN

 HairaarUlgerley